



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРОО



ОЛОН УЛСЫН  
ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА

# МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

## 2011-2012

УЛААНБААТАР ХОТ  
2013 ОН

---

Энэхүү тайланг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр  
Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.

---

**Хаяг:**

Үндэсний Статистикийн Хороо  
Засгийн газрын III байр  
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар  
Монгол Улс  
Цахим шуудан: [nso@magicnet.mn](mailto:nso@magicnet.mn)  
Факс: 976-11-324518

## АГУУЛГА

Хүснэгт, зургийн жагсаалт  
Өмнөх үг  
Товчилсон үгийн тайлбар  
Хавсралт хүснэгтийн жагсаалт

### Бүлэг 1. Ерөнхий тойм

- 1.1 Нийтлэг зүйл
- 1.2 Судалгааны зорилго, ач холбогдол
- 1.3 Судалгааны хугацаа
- 1.4 Тайлангийн бүтэц, агуулга
- 1.5 Судалгааны товч дүн

### Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт тодорхойлолтууд

- 2.1 Судалгааны хамрах хүрээ
- 2.2 Судалгааны түүвэрлэлт
- 2.3 Судалгааны асуулгын хуудас, ахлагч, судлаач нарын сургалт, мэдээлэл цуглуулалт
- 2.4 Судалгааны мэдээлэл боловсруулалт
- 2.5 Ойлголт, тодорхойлолтууд

### Бүлэг 3. Хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд

- 3.1 Нийтлэг зүйл
- 3.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд
- 3.3 Хүн амын тоо, байршил, бүс нутгаар
- 3.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц
- 3.5 Хүн ам зүйн ачаалал
- 3.6 Өрхийн бүтэц
- 3.7 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх
- 3.8 Боловсролын түвшин
- 3.9 Сургуульд хамрагдалт, сургууль завсардалтын шалтгаан
- 3.10 Бичиг үсгийн мэдлэгийн түвшин .

### Бүлэг 4. Ажил эрхэлж буй хүүхэд, тэдний өрхийн нийгэм эдийн засгийн байдал, сургуульд хамрагдалт

- 4.1 Нийтлэг зүйл
- 4.2 5-17 насны хүүхдийн тоо, хүйс, насны бүлэг, байршил, бүсээр
- 4.3 5-17 насны хүүхэд, тэдний өрх, гэр бүлийн байдал
- 4.4 5-17 насны хүүхдийн амьдарч буй орон сууцны төрөл, ахуйн нөхцөл
- 4.5 5-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, сургуульд хамрагдаагүй шалтгаан
- 4.6 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдал
- 4.7 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, байршил, бүсээр
- 4.8 Ажил эрхэлж буй хүүхэд, тэдний өрх, гэр бүлийн байдал
- 4.9 Ажил эрхэлж буй хүүхдийн гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдал
- 4.10 Ажил эрхэлж буй 6-17 насны хүүхдийн боловсролын түвшин, сургуульд хамрагдалт
- 4.11 Ажил эрхэлж буй хүүхдийн чөлөөт цаг

### Бүлэг 5. Ажил эрхэлж буй хүүхдүүдийн төлөв байдал

- 5.1 Нийтлэг зүйл
- 5.2 Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа
  - 5.2.1 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, тухайн үеийн идэвхээр
  - 5.2.2 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
  - 5.2.3 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

- 5.2.4 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар
- 5.2.5 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажилласан хугацаагаар
- 5.2.6 Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн сарын орлого
- 5.3 Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд

#### **Бүлэг 6. Хүүхдийн хөдөлмөр, түүнийг эрхлэх болсон шалтгаан, үр дагавар**

- 6.1 Нийтлэг зүйл
- 6.2 Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо
- 6.3 Сургуулиас гадуурх үйл ажиллагаа
- 6.4 Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн сургуульд хамрагдалт
- 6.5 Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох болсон шалтгаан
  - 6.5.1 Өрхийн бизнес, мал аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд туслах болсон шалтгаан
  - 6.5.2 Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгаан
- 6.6 Ажил эрхлэхгүй бол хүүхэд, гэр бүлд үзүүлэх нөлөө

#### **Бүлэг 7. Ажил хийж буй хүүхдийн ажлын байр, ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээ**

- 7.1 Нийтлэг зүйл
- 7.2 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 5-17 насны хүүхдийн ажлын байрны байршил
- 7.3 Ажлын байрны талаарх үнэлгээ
- 7.4 Хөдөлмөр хамгааллын хувцас, багаж, хэрэгслээр хангагдсан байдал

#### **Бүлэг 8. Хүнд хортой болон аюултай ажил хийж буй хүүхдүүд**

- 8.1 Нийтлэг зүйл
- 8.2 Хүнд хортой болон аюултай ажил хийж буй хүүхэд

#### **Бүлэг 9. Хүүхдийн ажил эрхлэлтийн улирлын хэлбэлзэл**

- 9.1 Нийтлэг зүйл
- 9.2 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо
  - 9.2.1 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
  - 9.2.2 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар
  - 9.2.3 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар
- 9.3 Судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдийн чөлөөт цаг

#### **Бүлэг 10. Хүүхдийн хөдөлмөрийн 2002–2003, 2006–2007, 2011–2012 оны судалгааны үр дүнгийн харьцуулалт**

- 10.1 Нийтлэг зүйл
- 10.2 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо.....
- 10.3 Ажил эрхэлж буй хүүхэд
- 10.4 Хүүхдийн хөдөлмөр

#### **Бүлэг 11. Түүврийн алдаа**

- 11.1 Нийтлэг зүйл
- 11.2 Түүвэрлэлт
- 11.3 Түүврийн алдаа

#### **Хавсралт**

- 1 Хүснэгтүүд
- 2 Асуулгын хуудас

## ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1	Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүрээр сонгогдсон ТАШН, өрхийн тоо
Хүснэгт 3.1.	Өрхөөс гадуур 6 сараас дээш хугацаагаар байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөөгөөр, бүсээр
Хүснэгт 3.2.	Судалгаанд хамрагдсан өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр, хүйсээр
Хүснэгт 3.3.	Хүн ам зүйн ачаалал, хот, хөдөө, бүсээр
Хүснэгт 3.4.	Өрхийн тоо, ам бүлийн тоогоор, байршлаар, бүсээр, хувиар
Хүснэгт 3.5	Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор, хот, хөдөөгөөр
Хүснэгт 3.6.	15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, боловсролын түвшингээр, хүйсээр, хот, хөдөөгөөр, хувиар
Хүснэгт 3.7.	6-18 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр
Хүснэгт 3.8.	Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, хот, хөдөө, бүсээр, хүйсээр
Хүснэгт 3.9.	Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, насны бүлгээр, хот, хөдөөгөөр, хүйсээр
Хүснэгт 4.1	Хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр
Хүснэгт 4.2	5-17 насны хүүхдийн нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр, хувиар
Хүснэгт 4.3	5-17 насны өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн тоо, шалтгаан, хот, хөдөөгөөр
Хүснэгт 4.4	5-17 насны хүүхэд, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоогоор, хувиар
Хүснэгт 4.4.a	5-17 насны хүүхэд, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоогоор, хот, хөдөө, бүсээр, хувиар
Хүснэгт 4.5	5-17 насны хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, хүйс, насны бүлгээр
Хүснэгт 4.5.a	5-17 насны хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, хүйс, насны бүлгээр, хувиар
Хүснэгт 4.5.б	5-17 насны хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, хот, хөдөөгөөр, хувиар
Хүснэгт 4.6	5-17 насны хүүхдийн сургууль, курст хамрагдаагүй шалтгаан, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 4.7	6-17 насны хүүхдийн тоо сургууль, курст суралцаагүй шалтгаан, насны бүлгээр
Хүснэгт 4.8	Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 4.8a	Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар
Хүснэгт 4.9	5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхи, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоо, хот, хөдөөгөөр
Хүснэгт 4.10	5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр
Хүснэгт 4.11	5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхийн ам бүлийн тоогоор, хувиар
Хүснэгт 4.12	6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, боловсролын түвшнээр, хүйсээр, хот, хөдөөгөөр, хувиар
Хүснэгт 4.13	6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр
Хүснэгт 4.14	6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, насны бүлэг, хот, хөдөөгөөр
Хүснэгт 4.14a	6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, хувиар
Хүснэгт 4.15	6-17 насны ажил эрхэлж буй сургууль, курст хамрагдаагүй хүүхэд, шалтгаанаар, хувиар
Хүснэгт 4.16	6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн чөлөөт цаг, бүгдэд эзлэх хувиар
Хүснэгт 5.1	5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 5.2	Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр
Хүснэгт 5.3	Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр

Хүснэгт 5.4	5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
Хүснэгт 5.4.a	5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар
Хүснэгт 5.5	5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, бүгдэд эзлэх хувиар
Хүснэгт 5.6	5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 5.7.	5-17 насны цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд, хүйс, олсон орлого, сургуульд хамрагдалтаар
Хүснэгт 5.8	Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр
Хүснэгт 5.8.a	Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр, хувиар
Хүснэгт 5.9	Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, 7 хоногт зарцуулсан цагаар
Хүснэгт 6.1.	Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлэг, хүйсээр /батлагдсан аргачлалын дагуу/
Хүснэгт 6.2.	Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлэг, хүйсээр/хөдөлмөрийн хуулийн заалтын дагуу/
Хүснэгт 6.3.	5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 6.4.	Сургуульд сураагүй хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 6.5.	Өрхийн аж ахуйд тусалж буй хүүхэд, насны бүлэг, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, хүйсээр
Хүснэгт 6.6.	Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхэд, сургуульд суралцаж буй эсэх, насны бүлэг, хот, хөдөөгөөр
Хүснэгт 6.7.	Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд тусалж байгаа хүүхдүүдийн туслах болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 6.8.	Өрхөөс гадуур ажиллаж буй хүүхдийн өрхөөс гадуур ажиллах болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр
Хүснэгт 6.9.	Өрхөөс гадуур ажил эрхэлж буй хүүхдийн тоо, ажил эрхлэхгүй бол өөрт нь болон гэрт нь үзүүлэх нөлөө, насны бүлэг, хүйс, байршлаар
Хүснэгт 8.1.	Аюултай ажил хийж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр(Батлагдсан аргачлалын дагуу)
Хүснэгт 9.1	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, дүнд эзлэх хувь, хүйсээр, улирлаар
Хүснэгт 9.2	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар, улирлаар
Хүснэгт 9.3	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, дүнд эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, улирлаар
Хүснэгт 9.4	5-17 насны хүүхдийн тоо, чөлөөт цагийн интервалаар, улирлаар
Хүснэгт 10.1.	5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвх, насны бүлэг, хүйсээр, судалгааны дүнгээр, хувиар
Хүснэгт 10.2.	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн насны бүтэц, судалгааны дүнгээр
Хүснэгт 10.3.	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, судалгааны дүнгээр
Хүснэгт 10.4.	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн статусын бүтэц, судалгааны дүнгээр
Хүснэгт 10.5.	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, судалгааны дүнгээр
Хүснэгт 10.6.	Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагийн үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, хүйсээр, судалгааны дүнгээр

- Зураг 3.1. Хүн амын насны бүтэц, ХАОСТ, АХС -ны дүнгээр
- Зураг 3.2. Сургуулиас завсардсан хүний тоо, шалтгаанаар, хувиар
- Зураг 4.1. 5-17 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр
- Зураг 4.2. Өрхийн тэргүүлэгчийн хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр
- Зураг 4.3. 5-17 насны хүүхэдтэй өрх, амьдарч буй сууцны төрлөөр, хувиар
- Зураг 4.4. 5-17 насны хүүхэдтэй өрх, амьдарч буй сууцны эзэмшлийн хэлбэрээр, хувиар
- Зураг 4.5. 5-17 насны хүүхэдтэй өрх, ахуйн цахилгааны эх үүсвэрээр, хувиар
- Зураг 4.6. 5-17 насны хүүхэдтэй өрх, усан хангамжийн эх үүсвэрээр, хувиар
- Зураг 4.7. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн, насны бүтэц, хувиар
- Зураг 4.8. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, бүсээр
- Зураг 4.9. 5-17 насны ажил эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр
- Зураг 4.10. 5-17 насны ажил эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эрхэлж буй ажлын эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар
- Зураг 4.11. Ажил эрхэлж буй хүүхэд, ам бүлийн тоо, хүйсээр, хот, хөдөөгөөр, хувиар
- Зураг 4.12. Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, сууцны төрлөөр, хувиар
- Зураг 4.13. Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, сууцны эзэмшлийн хэлбэрээр, хувиар
- Зураг 4.14. Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, цахилгааны эх үүсвэрээр, хувиар
- Зураг 4.15. Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, усан хангамжийн эх үүсвэрээр, хувиар
- Зураг 4.16. Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, өрхийн орлогын түвшингээр
- Зураг 4.17. Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, өрхөд ажил эрхэлж буй хүний тоогоор, хувиар
- Зураг 4.18. Ажил эрхэлж буй сургуульд хамрагдаагүй 5-17 насны хүүхдийн тоо, хүйс, сургуульд хамрагдаагүй шалтгаанаар
- Зураг 5.1. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр
- Зураг 5.2. Ажил эрхэлсэн хүүхэд, бүх төрлийн эдийн засгийн үйд ажиллагааны салбарын ангиллаар, хувиар
- Зураг 5.3. Ажил эрхэлсэн хүүхэд, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хувиар
- Зураг 5.4. Ажил эрхэлсэн хүүхэд, хүйс, ажил мэргэжлийн ангилал, хот, хөдөөгөөр, хувиар
- Зураг 5.5. Ажил эрхэлсэн хүүхэд, ажилласан хугацаагаар, хувиар
- Зураг 6.1. Хүүхдүүдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, хот, хөдөө, хувиар
- Зураг 6.2. Сургуульд сураагүй хүүхдүүдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, хот, хөдөө, хувиар
- Зураг 6.3. Өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар
- Зураг 6.4. Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхдийн тоо, сургуульд суралцаж буй эсэхээр, хот, хөдөө, хүйсээр
- Зураг 6.5. Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд тусалж байгаа хүүхдүүдийн туслах болсон шалтгааны бүтэц, хувиар
- Зураг 6.6. Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуйдаа тусалж байгаа хүүхдийн ажилд туслах болсон шалтгаан, хувиар
- Зураг 6.7. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгааны бүтэц, хувиар
- Зураг 6.8. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгааны бүтэц, хүйсээр, хувиар
- Зураг 6.9. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгааны бүтэц, хот, хөдөөгөөр, хувиар
- Зураг 6.10. Ажил эрхлэхгүй бол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, хот, хөдөө, Улаанбаатар хот, хувиар
- Зураг 7.1. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 5-17 насны хүүхдийн ажлын байрны байршлын бүтэц, хувиар
- Зураг 7.2. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн ажлын байрны байршил, хүйс,

	хувиар
Зураг 7.3	Өрхөөс гадуур ажил эрхэлж буй хүүхдийн ажлын байрны талаарх үнэлгээ, хувиар
Зураг 7.4	Ажлын байрандаа сэтгэл ханамжгүй байгаа эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн бүтэц, шалтгаанаар
Схем 7.1	Бие болон сэтгэл санааны дарамтад өртдөг хүүхдийн тоо (давхардсан тоогоор), дарамтын төрлөөр, хувиар
Схем 7.2	Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэдэг эсэх
Зураг 7.10	Хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэдэг хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар
Зураг 8.1	Аюултай ажил хийж буй хүүхдийн насны бүтэц, хувиар
Зураг 8.2	Аюултай ажил хийж буй хүүхдийн тоо, хүйс, насны бүлгээр
Зураг 8.3	Аюултай ажил хийж буй хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар
Зураг 9.1	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, байршил, улирлаар
Зураг 9.2	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, хүйс, байршил, улирлаар, хувиар
Зураг 9.3	Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар, улирлаар, хувиар
Зураг 9.4	5-17 насны хүүхдийн чөлөөт цагтаа зарцуулж буй дундаж цаг, хувь, улирлаар
Зураг 10.1.	Хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдлын бүтэц, насны бүлэг, судалгааны дүнгээр
Зураг 10.2.	Сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдлын бүтэц, хүйсээр, судалгааны дүнгээр
Зураг 10.3.	Ажил эрхэлсэн хүүхдийн насны бүтэц, судалгааны дүнгээр
Зураг 10.4.	Ажил эрхэлсэн хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, судалгааны дүнгээр, хувиар
Зураг 10.5.	Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн хүйсийн бүтэц, судалгааны дүнгээр
Зураг 10.6.	Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн насны бүтэц, судалгааны дүнгээр
Зураг 10.7.	Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн насны бүтэц, хүйсээр, судалгааны дүнгээр



## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс 1990 онд НҮБ-аас батлан гаргасан Хүүхдийн эрхийн Конвенц, 2000 онд ОУХБ-аас батлагдсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенц, 2002 онд Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар Конвенцэд нэгдэн орсон орны хувьд хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах болон хүүхдийг хүнд хортой нөхцлийн ажил, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэд татан оруулахыг хязгаарлах, таслан зогсооход чиглэсэн үндэсний хэмжээний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж ирсэн. Үүнтэй холбоотойгоор хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, тархалт, төлөв байдлын талаарх мэдээллийн эрэлт хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж байна.

Үндэсний статистикийн хороо нь “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа(ХХС)”-г “Ажиллах хүчний судалгаа(АХС)”-тай хамтруулан Монгол Улсын хэмжээнд хоёр удаа олон улсын жишиг аргачлалын дагуу явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон юм. Эдгээр судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, хүүхдийн эдийн засгийн идэвх, хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн санг бүрдүүлсэн билээ. Хүүхэд хамгааллын талаар цаашдын стратеги, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай хүүхдийн хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах зорилгоор ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (ХХУОУХ)-ийн газраас тавьсан саналын дагуу Гурав дахь удаагийн ХХС-г ОУХБ-ын санхүү, техникийн дэмжлэгтэйгээр 2011 оны 7 дугаар сард эхэлж нэг жилийн турш явуулав. Судалгааны мэдээллийг цуглуулснаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг тодорхойлох, ажлын байрны нөхцөл, гарч буй үр дагавар зэргийг тооцох замаар хүүхдийн хөдөлмөрийн талаар иж бүрэн дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас 2011 онд батлагдсан “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийн эхний үе шатны хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцож гаргах бололцоотой болсноороо чухал ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны үр дүн нь хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг бодитойгоор тодорхойлон улмаар хүүхдийн хөдөлмөрийг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийн явцад үнэлэлт, дүгнэлт өгөх, хэрэгжилтийг цаашид эрчимжүүлэх, ажил хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгахад чиглэсэн үндэсний хэмжээний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хэрэгцээтэй суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ХХС-г манай оронд гурав дахь удаагаа олон улсын аргачлалаар үндэсний хэмжээнд явуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлэн төслийг хэрэгжүүлэхэд хичээл зүтгэл гарган ажилласан ОУХБ-ын ХХУОУХ-ийн Төслийн удирдагч Бижой Раучадхури, ажилтан Н.Монголмаа, төслийн ажлыг хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулж байсан дотоодын зөвлөх Б.Даваахүү нарт талархал илэрхийлье.

Мөн судалгааг олон улсын жишгийн дагуу мэргэжлийн түвшинд амжилттай зохион байгуулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажилласан ҮСХ-ны даргын болон арга зүйн байнгын зөвлөлийн гишүүд, судалгааг төв, орон нутагт зохион байгуулан явуулах, мэдээллийг цуглуулах, боловсруулах ажилд идэвхтэй оролцож ажилласан төв, орон нутгийн судалгааны багийн гишүүдэд талархал илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

**С.МЭНДСАЙХАН**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>АХС</b>	Ажиллах хүчний судалгаа
<b>АЭТ</b>	Ажил эрхлэлтийн түвшин
<b>МХХС</b>	Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
<b>НХХЯ</b>	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам /хуучнаар/
<b>НҮБ</b>	Нэгдсэн үндэстний байгууллага
<b>ОУХБ</b>	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
<b>ТАШН</b>	Түүврийн анхан шатны нэгж
<b>ТХШН</b>	Түүврийн хоёр дахь шатны нэгж
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ҮТС</b>	Үндэсний тооцооны систем
<b>ХАОСТ</b>	Хүн ам, орон сууцны тооллого
<b>ХАНСГ</b>	Хүн ам, нийгмийн статистикийн газар
<b>ХХУОУХ</b>	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
<b>ХХТХ</b>	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр
<b>ХХС</b>	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа
<b>ХХҮХ</b>	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



I

**БҮЛЭГ**

**ЕРӨНХИЙ ТОЙМ**

## 1.1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Үндэсний статистикийн хороо нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр (ХХУОУХ)-ийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (ХХС)”-г Ажиллах хүчний судалгаа (АХС)-ны хавсарга судалгаа болгон Монгол Улсын хэмжээнд өмнө нь хоёр удаа /2002-2003, 2006-2007 онд/ олон улсын жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон юм. Эдгээр судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, хүүхдийн эдийн засгийн идэвх, хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн санг бүрдүүлсэн билээ.

Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц, ОУХБ-аас батлагдсан “Ажилд авах насны доод хязгаарын тухай” 138 дугаар, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай” 182 дугаар Конвенцид нэгдэн орсон улс орны хувьд хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах болон хүүхдийг хүнд, хортой нөхцлийн ажил, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэд татан оруулахыг таслан зогсооход чиглэсэн үндэсний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж ирсэн. “Дээрх Конвенцид нэгдэн орсон Гишүүн орон бүр өөрийн улсдаа хүүхдийн хөдөлмөрийг бүрмөсөн устгах ба ажилд авах насны доод хязгаарыг хүүхдийн бие бялдар болон оюун санааны хувьд бүрэн боловсрох үеийнх нь настай нийцүүлэн тогтоох үндэсний бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу 2008 онд болсон Олон Улсын Хөдөлмөрийн Статистикчдын 18 дугаар бага хурлаас гарсан “Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн тухай” тогтоолыг хэрэгжүүлэх, энэ тогтоолд заасны дагуу Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, түүний дотроос аюултай ажил хийж буй хүүхдийг тодорхойлох, мөн хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил буюу 2008 онд НХХЯ(хуучнаар)-аас батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-нд буй ажлыг хүүхдүүд хийж буй эсэхийг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Мөн хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, тархалт, төлөв байдлын талаарх мэдээллийн эрэлт хэрэгцээ байнга өсөн нэмэгдэх боллоо. Иймд өмнө нь судалгаа явуулсан туршлагад үндэслэн хүүхэд хамгааллын талаар цаашдын стратеги, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардагдах хүүхдийн хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах зорилгоор ОУХБ-ын ХХУОУХ-ийн газраас тавьсан саналын дагуу Гурав дахь удаагийн ХХС-г АХС-ны хавсарга судалгаа болгон ҮСХ нь ОУХБ/ХХУОУХ-ийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр 2011 оны 7 дугаар сарын нэгнээс 2012 оны 7 дугаар сарын нэгэн хүртэлх хугацаанд явуулав.

Хүүхдийн хөдөлмөрт дүн шинжилгээ хийхэд хүүхэд, өрх, нийгэмтэй холбоотой гурван хүчин зүйлсийн үзүүлэлт байдаг бөгөөд өмнөх судалгаануудад байсан эдгээр үзүүлэлтийг боловсронгуй болгон баяжуулж, өрхийн нийгэм, эдийн засгийн байдал, хүүхдийн сургуульд хамрагдалт, нэн ялангуяа сургууль завсардалтын шалтгаан, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ажлын байрны нөхцөлийн талаарх асуултуудыг асуулгад нэмж тусган, хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргаж, судалгаа явуулан холбогдох үндсэн үзүүлэлтүүдийг тооцоход ашиглах зорилгоор 2009 онд батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу судалгааны асуулгыг боловсруулж, үр дүнг тооцон гаргасан болно.

## 1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Судалгааны гол зорилго нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, хамрах хүрээ, хүүхэд хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, түүний дотроос аюултай, хүнд ажил эрхэлж буй хүүхдийг тодорхойлон гаргах, хүүхдүүдийн хийж буй ажил, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхэлснээрээ хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буй талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах, бодлого боловсруулагчдыг шаардлагатай мэдээллээр хангах, олон улсын түвшинтэй харьцуулах, өмнөх оны судалгаануудын мэдээллийн санг баяжуулахад чиглэгдсэн болно.

Энэхүү судалгааг явуулснаар хүүхдийн эдийн засгийн идэвх, хүүхдийн ажил, хөдөлмөрийн нөхцөл байдалд гарч байгаа өөрчлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөхийн зэрэгцээ “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай” ОУХБ-ын 182 дугаар конвенцийн үзэл санааг үндэслэл болгон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, хязгаарлах, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг бүх салбарт эрчимжүүлэх замаар 2016 он гэхэд Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй

хэлбэрийг бүрэн устгах зорилготой Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 303 тоот тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийн эхний үе шатны хэрэгжилтийг дүгнэхэд тулгуур материал болж байгаагаараа онцлог юм.

Судалгааг явуулснаар дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Хүүхдийн хөдөлмөрийн талаар ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, аргачлалын дагуу судалгааг улирлаар явуулсанаар хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн эдийн засгийн идэвх, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн санг баяжуулах;
- Хөдөө орон нутаг, хот суурин газар болон улсын хэмжээн дэх хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, хүүхдийн хөдөлмөрийн чиг хандлага, тэдгээрийн үндсэн шалтгааныг тодорхойлох;
- “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцож гаргах;
- Хүүхдийн хөдөлмөрийг багасгах, ХХТХ-ийг хориглох, устгахад чиглэсэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгоход чиглэсэн үндэсний хэмжээний үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох үндсэн суурь мэдээлэл болох;
- Хүүхдийн хөдөлмөрийн хяналт, үнэлгээний үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох;
- ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийн сан дахь Монгол Улсын хүүхдийн хөдөлмөрийн талаарх мэдээллийн санг баяжуулах зэрэг болно.

### 1.3. СУДАЛГААНЫ ХУГАЦАА

Судалгааны хамралтын хугацаа нь 4 улирал буюу 2011 оны 7 дугаар сараас 2012 оны 6 дугаар сарыг дуусталх нэг жилийн хугацааг хамарсан. Судалгааны улирлын хугацаа нь өмнөх 2 судалгааны адил цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй байгааг анхаарна уу. Жишээлбэл, судалгааны эхний улирлын мэдээллийг 2011 оны 7-9 дүгээр саруудад, хоёрдугаар улирлынхыг 2011 оны 10-12 дугаар саруудад, гуравдугаар улирлынхыг 2012 оны 1-3 дугаар саруудад, харин сүүлчийн буюу дөрөвдүгээр улирлын мэдээллийг 2012 оны 4-6 дугаар саруудад цуглуулсан болно.

### 1.4. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

Хүүхдийн хөдөлмөрийн энэ удаагийн судалгааны үр дүнгийн тайлан нь дараах 11 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Бүлэг 1. Ерөнхий тойм
- Бүлэг 2. Судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт, тодорхойлолтууд
- Бүлэг 3. Хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд
- Бүлэг 4. Ажил эрхэлж буй хүүхэд, тэдний өрхийн нийгэм эдийн засгийн байдал
- Бүлэг 5. Ажил эрхэлж буй хүүхдийн төлөв байдал
- Бүлэг 6. Хүүхдийн хөдөлмөр, түүнийг эрхлэх болсон шалтгаан, үр дагавар
- Бүлэг 7. Ажил хийж буй хүүхдийн ажлын байр, ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээ
- Бүлэг 8. Хүнд хортой болон аюултай ажил хийж буй хүүхдүүд
- Бүлэг 9. Хүүхдийн ажил эрхлэлтийн улирлын хэлбэлзэл
- Бүлэг 10. Хүүхдийн хөдөлмөрийн 2002-2003, 2007-2008, 2011-2012 оны судалгааны үр дүнгийн харьцуулалт
- Бүлэг 11. Түүврийн алдаа

Тайлангийн 1-р бүлэгт судалгааны зорилго, ач холбогдол, тайлангийн бүтэц, агуулга болон судалгааны товч үр дүн, 2-р бүлэгт судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт, тодорхойлолтууд, 3-р бүлэгт хүн ам зүйн болон өрхийн үзүүлэлтүүд, 4-р бүлэгт ажил эрхэлж буй хүүхдийн өрхийн нийгэм эдийн засгийн байдал, 5-р бүлэгт ажил эрхэлж буй хүүхдийн төлөв байдал, 6-р бүлэгт ОУХ-ийн статистикчдийн 18 дугаар бага хурлаас баталсан “Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн тухай” тогтоолын дагуу хүүхдийн хөдөлмөрийг тооцон гаргаж, хүүхдийн хөдөлмөр эрхлэх болсон шалтгаан, үр дагаврын талаар, 7-р бүлэгт ажил хийж буй хүүхдийн ажлын байр, ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээний талаар, 8-р бүлэгт хүнд хортой болон аюултай ажил хөдөлмөр хийж буй хүүхдийн талаар, 9-р бүлэгт хүүхдийн ажил эрхлэлтийн байдлыг улирлаар харуулсан бол, 10-р бүлэгт хүүхдийн хөдөлмөрийн 3 удаагийн буюу 2002-2003, 2006-2007, 2011-2012 онд явуулсан судалгааны үндсэн үр дүнгийн харьцуулалт хийсэн талаар, 11-р бүлэгт судалгааны түүвэрлэлтийн алдааны талаар тус тус өгүүлсэн болно.

## 1.5. СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮН

Судалгааны үр дүнг тархаасан тооцоогоор 5-17 насны нийт 589076 хүүхэд хамрагдсаны 51.0 хувь буюу 300.700 нь хөвгүүд, 49.0 хувь буюу 288.400 нь охид байна. Нийт хүүхдийн 34.2 хувь нь 5-9 настай, 15.6 хувь нь 10-11 настай, 24.5 хувь нь 12-14 настай, 25.7 хувь нь 15-17 настай хүүхдүүд байна. Судалгаанд хамрагдсан нийт (589076) хүүхдийн 15,9 хувь буюу 93968 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн байна.

### 5-17 насны хүүхэд, тэдний гэр бүлийн нөхцөл байдал

- 5-17 насны нийт хүүхдийн 54.5 хувь нь хот, суурин газарт, 45.5 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.
- Судалгааны дүнгээр нийт хүүхдийн 45.7 хувь нь гэрт, 33.8 хувь нь сууцны тусдаа байшинд, 17.5 хувь нь орон сууцны байшинд амьдарч байна.
- Хүүхдийн амьдарч буй өрхийн сууцны эзэмшлийн хэлбэрийг авч үзвэл 93.9 хувь нь өөрийн эзэмшлийн, 2.8 хувь нь бусдын сууцанд түрээсгүй суудаг, 2.6 хувь бусдын сууцанд түрээстэй, 0.7 хувь нь бусад төрлийн эзэмшлийн сууцанд амьдардаг байна.
- Нийт хүүхдийн 97.9 хувь нь гэртээ цахилгаан хангамжтай байгаагийн 78.1 хувь нь төвлөрсөн системд холбогдсон байна.
- Нийт хүүхдийн 16.5 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байна.
- Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 1.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагийн 67.0 хувь нь төрөлхийн, 33.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй ажээ.

### Хүүхдийн сургуульд хамрагдалт, эдийн засгийн идэвх

- Сүүлийн долоо хоног буюу тухайн үеийн идэвхийн байдлаар 5-17 насны нийт хүүхдийн 88.3 хувь буюу 519.900 нь сургуульд суралцаж байна.
- Нийт суралцагчдын 86.2 хувь нь ерөнхий боловсролын сургуульд, 1.1 хувь нь техник мэргэжлийн анхан шатны болон мэргэжлийн тусгай дунд сургуульд, 0.9 хувь нь дээд сургуульд суралцаж байна.
- Сургуульд суралцаж буй нийт хүүхдийн 15.2 хувь нь сурахын хажуугаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, 62.8 хувь нь зөвхөн эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу гэрийн ажил хийхэд оролцсон, 22.0 хувь нь зөвхөн сурч эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлээгүй, гэрийн ажил хийхэд ч оролцоогүй хүүхдүүд байна.
- 5-17 насны нийт хүүхдийн 11.7 хувь буюу 69.200 хүүхэд сүүлийн долоо хоногт ямар нэгэн сургуульд суралцаагүй байгаа бөгөөд тэдний 26.1 хувь нь зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон харин бараг талаас дээш хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд ч оролцоогүй, гэрийн ажил ч хийгээгүй



хүүхдүүд байна. Сургуульд сурдаггүй таван хүүхдийн нэг нь ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

- Судалгааны тархаалтын тооцоогоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны 55.400 хүүхэд байгаагийн 81.8 хувь нь суралцах, 6.2 хувь нь ажиллах, 12.0 хувь нь бусад шалтгаантайгаар өрхөөсөө гадуур амьдарч байна.
- Өрхөөс гадуур амьдарч буй хөдөөгийн арван хүүхдийн ес нь суралцах зорилготой байгаа бол хот, суурин газрын арван хүүхдийн дөрөв нь сурч, ажиллахаас өөр ямар нэгэн шалтгаантай байгааг нарийвчлан үзэх шаардлагатай байна.

### **Сургуульд суралцаагүй шалтгаан**

- Судалгааны дүнгээр сургуульд суралцаагүй байгаа нийт хүүхдийн 63.4 хувь буюу 39.900 нь 5 настай хүүхэд байна.
- Харин үлдсэн хүүхдийн 9.0 хувь нь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, 4.7 хувь нь мал маллахаар, 3.8 хувь нь сурлага муу, сурах сонирхолгүй, 2.8 хувь нь хичээлийн хэрэглэл, хувцас зэргийг худалдан авч чадаагүйгээс, 1.9 хувь нь хүүхдийн эцэг, эх нь сургуулиас гаргасан, 1.7 хувь нь гэрийн ажилд туслахаар гэсэн шалтгаанаар сургууль завсардсан хүүхдүүд байна.

### **Эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй хүүхдийн тоо**

- Судалгааны тархаалтын тооцоогоор судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 15.9 хувь буюу 93968 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон буюу ажил эрхэлж байгаагийн 54.1 хувь нь хөвгүүд, 45.9 хувь нь охид байна.
- Нийт эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж байгаа хүүхдийн 18.8 хувь нь 5-9 настай, 14.5 хувь нь 10-11 настай, 30.8 хувь нь 12-14 настай, 35.9 хувь нь 15-17 настай хүүхдүүд байна.
- Ажил эрхэлж буй арван хүүхдийн найм нь хөдөө орон нутагт, хоёр нь хот, суурин газарт амьдарч байна.
- Ажил эрхэлж буй нийт хүүхдийн 0.9 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байна.
- Ажил эрхэлж буй арван хүүхдийн нэг нь сарын 140.0-200.0 мянган төгрөгийн, дөрөв нь 200.0-400.0 мянган төгрөгийн орлоготой өрхөд амьдарч байна.
- Харин ажил эрхэлж буй нийт хүүхдийн 0.7 хувь нь өрхийн орлогыг ганцаараа бүрдүүлж байна.
- Ажил эрхэлж буй нийт хүүхдийн 84.1 хувь нь ямар нэгэн сургуульд суралцдаг, харин 15.9 хувь нь сургуульд сурдаггүй байна.
- Ажил эрхэлж буй 15-17 насны таван хүүхдийн нэг нь мал маллах шалтгаанаар сургуулиас гарсан хүүхдүүд байна.
- Ажил эрхэлж буй арван хүүхдийн найм нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт, нэг нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллаж байна. Ер нь бага насныхан хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт голдуу ажил эрхэлж байгаа бол 15-17 насныхан уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, барилга, урлаг үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- 5-17 насны ажил эрхэлж буй арван хүүхдийн зургаа нь мал аж ахуй эрхлэгч, гурав нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна.
- Ажил эрхэлж буй хүүхдүүдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл: нийт хүүхдийн 80.5 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, 12.3 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 3.6 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 2.9 хувь нь энгийн ажил мэргэжлээр, 0.7 хувь нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, техникч болон туслахаар ажилласан байна.

- Хөдөө орон нутгийн ажил эрхэлж буй арван хүүхдийн ес нь хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж байгаа бол хот, суурин газрын ажил хийж буй хоёр хүүхдийн нэг нь худалдаа, үйлчилгээний төрлийн ажил хийж байна.

### **Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн сарын орлого**

- Ажил эрхэлж буй нийт хүүхдийн 2.0 хувь нь цалин хөлстэй ажил эрхэлж байгаа бөгөөд тэдний 84.6 хувь нь хөвгүүд, 15.4 хувь нь охид байна.
- Цалин хөлстэй ажил эрхэлж буй арван хүүхдийн гурав нь сургуульд сурдаг, долоо нь сургуульд сурдаггүй хүүхэд байна.
- Сургуульд сурахын зэрэгцээ цалин хөлс, орлоготой ажил хийдэг хоёр хүүхдийн нэг нь сард 50.000 төгрөг хүртэлх, харин сургуульд сурдаггүй дөрвөн хүүхдийн нэг нь 140.000-169.000 төгрөгийн цалин хөлс, орлоготой ажилласан байна.
- Сарын орлого нь өндөр буюу 200.0 мянгаас дээш төгрөгний орлоготой хүүхдүүд нь дандаа хөвгүүд байна.

### **Эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу гэрийн ажил хийхэд оролцож буй хүүхдүүд**

- 5-17 насны нийт хүүхдийн 70.9 хувь нь буюу 417.700 хүүхэд эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон буюу гэрийн ажил хийсэн байна. Гэхдээ хүүхдүүд хэд хэдэн төрлийн гэрийн ажил хийсэн байж болно.
- Хамгийн олон хүүхэд хоол цай бэлтгэх, аяга таваг угаах (75.8 хувь), гэр, хашаа цэвэрлэх (68.0 хувь), ус авах (53.7 хувь), хувцас угаах, индүүдэх (46.6 хувь), түлээ түлш бэлтгэх (37.9 хувь), гэрийн хэрэгцээт зүйлийг худалдан авахаар дэлгүүр явах (28.0 хувь) ажлуудыг хийж байна.
- Гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоог хүүхдийн насны бүлэг, хүйсээр харахад нилээд ялгаа ажиглагдаж байна.
- Хоол цай бэлтгэх, аяга таваг угаах, гэр, хашаа цэвэрлэх, хувцас угаах, индүүдэх ажлыг хийсэн охидын эзлэх хувь хөвгүүдийнхээс өндөр байхад, ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хийсэн хөвгүүдийн хувь охидынхоос өндөр байна.
- Долоо хоногт 5-17 насны арван хүүхдийн зургаа нь 10 хүртэлх цагийг, гурав нь 10-24 цагийг, нэг нь 25-аас дээш цагийг гэрийн ажил хийхэд зарцуулжээ.

### **Хүүхдийн хөдөлмөр**

- Тухайн үеийн байдлаар 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй 93.968 хүүхдийн 46.3 хувь буюу 43545 хүүхэд хөдөлмөр эрхэлж байна гэсэн дүн гарч байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 7.4 хувь нь (589076 хүүхдийн 213545) хөдөлмөр эрхэлж байна.
- Хөдөлмөр эрхэлж буй нийт хүүхдийн 60.2 хувь нь эрэгтэй, 39.8 хувь нь эмэгтэй хүүхдүүд байна.

### **Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж байгаа хүүхдийн тоо**

- Судалгааны тархаалтын тооцоогоор 5-17 насны 1857 хүүхэд өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж байгаагийн 65.4 хувь нь сургуульд сурдаг, 34.6 хувь нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна.
- Өрхөөс гадуур ажил хийж буй арван хүүхдийн найм нь хөвгүүд, хоёр нь охид бөгөөд тэдний дийлэнхи нь 15-17 насныхан байна.
- Өрхөөс гадуур ажил хийж буй таван хүүхдийн хоёр нь өрхийн орлогод нэмэр болох зорилгоор, нэг нь өөрөө хүссэн болохоор ажиллаж байна гэж хариулсан байна.



- Хүүхдүүдийн өрхөөс гадуур ажил хийх болсон шалтгаан нь хот, хөдөөгөөр ялгаатай байна. Хөдөөгийн хүүхдүүдийн өрхөөс гадуур ажил хийх болсон гол шалтгаан нь өрхийн орлогод нэмэр болох (69.0 хувь) гэж байгаа бол хотын хүүхдүүд өөрөө хүссэн (32.9 хувь), өөрийгөө авч явах буюу эдийн засгийн хувьд бие даах (22.5 хувь) зорилгоор өрхөөс гадуур ажиллах болсон гэсэн хариултыг өгчээ.
- Хэрэв хүүхэд ажил хийхээ боливол өөрт нь болон өрхөд нь ямар нөлөө үзүүлэх вэ гэсэн асуултанд өрхөөс гадуур ажил хийж буй нийт хүүхдийн 48.6 хувь нь ямар ч нөлөө үзүүлэхгүй, 33.8 хувь нь өрхийн амьжиргааны түвшин доошилно, 11.6 хувь нь өрх орлогын эх үүсвэргүй болно, 6.0 хувь нь ажил хөдөлмөрийн дадлага, туршлагагүй болоход нөлөөлнө гэж хариулсан байна.
- Өрхөөс гадуур ажил хийж буй нийт хүүхдийн 86.9 хувь нь ажлын байрандаа сэтгэл ханамжтай гэж хариулсан бол 13.1 хувь нь ажлын байр нь тоосжилт ихтэй, чийгтэй, газар дор, хязгаарлагдмал орчинд, ариун цэврийн шаардлага хангаагүй байдаг гэсэн шалтгаанаар ажлын байрандаа сэтгэл ханамжгүй гэж хариулжээ.
- Өрхөөс гадуур ажил хийж буй арван хүүхдийн дөрөв нь ажлын байран дээрээ хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэдэг бол зургаа нь хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэлгүй ажиллаж байна.

### **Хүнд хортой болон аюултай ажил хийж буй хүүхдүүд**

Монгол Улсад мөрдөгдөж буй “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хүнд хортой ажлын нөхцөл бүхий эдийн засгийн салбарт ажиллаж байгаа, хүнд хортой бус ажлын нөхцөл бүхий салбарт хүнд хортой ажил хийж байгаа, хүнд хортой бус ажлыг долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар хийж байгаа 15-17 насны хүүхэд, сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж буй 5-11 насны бүх хүүхэд, харин 14-өөс илүү цаг ажилласан 12-14 насны хүүхдүүдийг хамруулан хүнд хортой болон аюултай ажил хийж байгаа хүүхдийн тоог тооцож гаргасан дүнг танилцуулж байна.

- Судалгааны тархаалтын тооцоогоор эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй 5-17 насны нийт 93.968 хүүхдийн 11.1 хувь буюу 10398 хүүхэд хүнд хортой болон аюултай ажил хийж байна.
- Тархаалтын тооцоогоор дээрх ажлыг хийж буй нийт хүүхдийн 7.4 хувь буюу 10-17 насны 773 хүүхэд нь Монгол Улсад мөрдөгдөж буй НХХ(хуучнаар)-ийн сайдын 2008 онд баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-нд буй ажил мэргэжлийн ажлыг хийж байна.
- Хуулиар хориглосон хүнд, хортой ажлын нөхцөлтэй ажлын байранд нийт хүүхдийн 10.8 хувь нь ажиллаж байгаа бөгөөд тэдний 84.3 хувь нь 15-17 насныхан байна.
- Хүнд, хортой ажлын нөхцөлд ажиллаж буй арван хүүхдийн ес нь хөвгүүд байна.
- Сүүлийн долоо хоногт 8500 хүүхэд 43 ба түүнээс дээш цагаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажилласан байна.

<sup>1</sup> Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт, НХХ-ийн сайдын тушаал №107, 2008 он

<sup>2</sup> Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, ҮСХ-ны дарга, НХХ-ийн сайдын хамтарсан тушаал №01-68/94, 2009 он





**БҮЛЭГ**

**СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТУУД**

## 2.1 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Ажиллах хүчний судалгаатай хамтруулан явуулсан энэхүү судалгаа нь 2006-2007 оны “Ажиллах хүчний болон хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаа”(АХС+ХХС) -тай ижил аргачлал, арга зүйн дагуу явагдсан. Судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь Монгол Улсын нийт өрх бөгөөд судалгааны түүвэрлэлтэд Хүн ам, өрхийн 2010 оны жилийн эцсийн тайлан мэдээг ашигласан.

Өрхөд суурилсан судалгаа тул тухайн өрхийн 5-17 насны хүүхдүүд судалгаанд хамрагдаж, судалгааны асуулганд хариулсан болно. Харин гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон засан хүмүүжүүлэх газар, асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдаагүй юм

## 2.2. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх бөгөөд нэг орон байранд хамт амьдардаг, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүнийг “өрх” гэж үзнэ. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан, сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг оруулаагүй болно.

Түүвэрлэлтийн арга зүйн хувьд 2006-2007 оны АХС+ХХС-ны түүвэр хийсэн ерөнхий зарчмыг баримталсан бөгөөд судалгаанд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хамруулах магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор түүвэрлэлтэнд дэд бүлэглэлтийг хийж өгсөн. Судалгааны бүлэглэлтийг засаг захиргааны нэгж буюу бүх аймаг, Улаанбаатар хотын дүүргүүд байхаар хийсэн. Энэ нь бодлого боловсруулагчдад хөдөлмөрийн статистикийн түлхүүр үзүүлэлтүүдийг аймаг, дүүргээр гаргаж өгөх боломжийг бүрдүүлж байгаа юм. Судалгаанд 21 аймаг тус бүрийг нэг бүлэг, Улаанбаатар хотын 9 дүүргийг 8 бүлэгт (хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэг болгосон) хувааж нийт 29 бүлэг болгон хамруулсан. Судалгааны түүврийн анхан шатны нэгж (ТАШН) нь Улаанбаатар хотын хувьд хорооны хэсэг, харин аймгийн хувьд багууд болно. Энэ түүвэр судалгаанд Улаанбаатар хотоос 432 хэсэг, аймгаас 636 баг нийт 1068 анхан шатны нэгжийг хамрууллаа (Хүснэгт 2.1-ийг үзнэ үү). Түүврийн хамралт болон төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, алдааны магадлалыг бууруулахын тулд ТАШН бүрээс 12 өрхийг сонгон судалгаанд хамруулсан.

Хүснэгт 2.1 Ажиллах хүчний түүвэр судалгааны бүлэг тус бүрээр сонгогдсон ТАШН, өрхийн тоо

Бүлгийн дугаар	Аймгийн нэр	Нийт хүн ам	Түүврийн нэгжийн тоо	Судалгаанд хамрагдсан өрхийн тоо		
				Нийт	Улиралд	Сард
1	Архангай	89282	36	432	108	36
2	Баян-Өлгий	93931	36	432	108	36
3	Баянхонгор	82205	36	432	108	36
4	Булган	57874	24	288	72	24
5	Говь-Алтай	55378	24	288	72	24
6	Дорноговь	55638	24	288	72	24
7	Дорнод	74514	32	384	96	32
8	Дундговь	47959	20	240	60	20
9	Завхан	76614	32	384	96	32
10	Өвөрхангай	110440	40	480	120	40
11	Өмнөговь	47784	20	240	60	20
12	Сүхбаатар	53785	24	288	72	24
13	Сэлэнгэ	94590	36	432	108	36
14	Төв	88889	32	384	96	32
15	Увс	77184	32	384	96	32
16	Ховд	85897	36	432	108	36
17	Хөвсгөл	124036	48	576	144	48
18	Хэнтий	67770	24	288	72	24

19	Дархан-Уул	91093	36	432	108	36
20	Орхон	89875	36	432	108	36
21	Говь-Сүмбэр	13315	8	96	24	8
	<b>Аймгийн дүн</b>	<b>1578053</b>	<b>636</b>	<b>7632</b>	<b>1908</b>	<b>636</b>
22	Хан Уул	98815	36	432	108	36
23	Багануур Багахангай	29619	12	144	36	12
24	Баянзүрх	235192	96	1152	288	96
25	Налайх	29115	12	144	36	12
26	Баянгол	169278	72	864	216	72
27	Сүхбаатар	133108	48	576	144	48
28	Чингэлтэй	140019	60	720	180	60
29	Сонгино хайрхан	232326	96	1152	288	96
	<b>Нийслэлийн дүн</b>	<b>1067472</b>	<b>432</b>	<b>5184</b>	<b>1296</b>	<b>432</b>
	<b>Улсын дүн</b>	<b>2645525</b>	<b>1068</b>	<b>12816</b>	<b>3204</b>	<b>1068</b>

Энэхүү судалгаанд олон шатат түүврийн арга хэрэглэсэн. Түүвэрлэлтийг хийхдээ нийт хүн амд таамаглаж байгаа ажилгүй иргэдийн тооны эзлэх хувийн жингээр магадлал хийн тооцсон. Нөгөөтэйгүүр түүвэрлэлтийг аймаг, хотын дүүргээр бүлэглэн хуваарилахдаа нийт хүн амд пропорциональ харьцаагаар жигд тархаан тооцлоо.

Түүврийн эхний шатанд “Пропорциональ магадлалт түүврийн арга”-аар ТАШН-ийг Засаг захиргааны нэгжийн нийт хэмжээнд пропорционалиар сонгосон. Харин түүврийн хоёрдугаар шатанд ТАШН бүрээс 12 өрхийг сонгохдоо ТАШН-ээс энгийн санамсаргүй системчилсэн циклт түүврийн дэд түүвэрлэлтийн техникийг ашигласан болно. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдах өрхийг сонгохдоо 2 шаттай түүвэрлэлтийн (sub-sampling) аргыг хэрэглэсэн.

### 2.3. СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ХУУДАС, АХЛАГЧ, СУДЛААЧ НАРЫН СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Ажиллах хүчний болон Хүүхдийн хөдөлмөрийн 2006-2007 оны судалгааны асуулга 7 бүлэг бүхий 159 асуултаас бүрдэж байсан бол энэ удаагийн судалгаа нь 9 бүлэг 183 асуултаас бүрдэж, шинээр 2 бүлэг, 24 асуулт нэмэгдээд байна. Энэ нь хүн амын боловсролтой холбогдолтой нэн ялангуяа сургууль завсардалтын шалтгаануудыг тодруулах, аюултай ажил хөдөлмөр хийж буй хүүхдийг тодорхойлох зорилгоор хүүхдийн хөдөлмөрийн ажлын байрны нөхцөл байдлыг тодруулах үзүүлэлтүүдийг нэмсэнтэй холбоотой. Мөн өрхийн гишүүдийн сүүлийн 7 хоногт цалин хөлсгүйгээр хийсэн үйл ажиллагааг тусад нь шинээр бүлэг болгосон.

Судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан, эдийн засгийн тухайн үеийн болон байнгын идэвхийн тодорхойлолт, тооцох аргачлалыг ашиглан судалгааны асуулгыг боловсруулахдаа дараах мэдээллийг гаргахад чиглүүлж боловсруулсан. Үүнд:

1. Өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд (өрхийн сууцны төрөл, халаалт, өмчлөл, эзэмшлийн хэлбэр, эрчим хүч, усан хангамж, удаан эдэлгээтэй эд хогшил, хувийн мал, газартай эсэх, өрхийн сарын дундаж орлого);
2. Хүн ам зүйн үзүүлэлтүүд (өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох, хүйс, төрсөн он, сар, өдөр, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, гэрлэлтийн байдал);
3. Боловсрол ба сургалттай холбоотой үзүүлэлтүүд (сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх, сургуульд огт суралцаагүй болон сургуулиас гарсан шалтгаан, боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, эзэмшсэн үндсэн мэргэжил, шинээр мэргэжил болон ур чадвар олгох сургалтанд хамрагдсан эсэх, хамрагдсан сургалтын төрлөөр);
4. Сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн идэвх (эдийн засгийн үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг, эдийн засгийн идэвхтэй, идэвхгүй байдал, үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжлийн ангилал, үндсэн ажлынхаа цалин хөлсийг ямар давтамжтай авдаг, авч буй цалин, хөлс, орлого, ажиллаж буй гэрээний төрөл, байгууллага болон ажил олгогч нар тэтгэмж, тэтгэлэг, хөнгөлөлт олгодог эсэх);

5. Нэмэгдэл ажил хийх хүсэл, боломж (нэмэгдэл ажил хийх хүсэл, боломжтой эсэх, ажил хэрхэн хайсан, нэмэгдэл ажил хийх хүсэлгүй, боломжгүй байгаа шалтгаан);
6. Ажилгүйдэл (ажил хийхэд бэлэн байсан эсэх, эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгаан, сүүлийн 30 хоногт ажил хайсан эсэх, хэрхэн ажил хайсан, ямар төрлийн мэргэжлийн ажил хийх хүсэлтэй байгаа, хичнээн төгрөгний цалин хөлс/өдрийн, цагийн/ авах бодолтой байгаа, хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-т бүртгүүлсэн эсэх);
7. Эдийн засгийн байнгын идэвх (сүүлийн 12 сарын буюу эдийн засгийн байнгын идэвх, сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрлөөр, ажилгүй байсан хугацаа, ажил хайсан хэлбэр, сүүлийн 12 сарын үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтээс олсон цалин, хөлс, орлого);
8. Өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт (өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн статус, ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, хамгийн сүүлийн ажлаа хир удаан хийсэн, сүүлийн ажлаа хийхээ больсон шалтгаан, ажилгүй байх хугацаандаа ямар орлого, тусламжаар амьдарч байгаа);
9. Өрхийн гишүүдийн цалин хөлсгүй ажил, үйлчилгээ (сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу цалин хөлсгүйгээр хийсэн үйл ажиллагаа, түүнд зарцуулсан цаг);
10. 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (хүүхдийн сургуульд хамрагдалт, сургуулиас завсардсан шалтгаан, өрхийн бизнест тусалдаг эсэх, анх хэдэн настайгаасаа тусалж эхэлсэн, туслах болсон шалтгаан, гэрээсээ гадуур ямар нэг хөдөлмөр эрхэлдэг эсэх, анх хэдэн настайгаасаа өрхөөс гадуур ажил хийх болсон, өрхөөс гадуур ажил хийх болсон шалтгаан, өдөрт бүтэн болон хагас цагаар ажилладаг эсэх, ажлын байрныхаа нөхцөлд сэтгэл ханамжтай байдаг эсэх, ханамжгүй байгаа шалтгаан, хийж буй ажил нь хүүхдэд бие болон сэтгэл санааны дарамт учруулдаг эсэх, ажлын байранд нь хүнд хортой нөхцөл байдаг эсэх, шөнө оройн цагаар ажилладаг эсэх, хэр олон удаа ажилладаг, хүүхэд ажлаасаа болж өвдөж, гэмтсэн эсэх, ямар өвчин гэмтэл авсан, өвчлөл, гэмтэлтэй холбогдолтой зардлыг хэн гаргасан, олсон орлогоо юунд зарцуулдаг, өдөрт өөрт нь чөлөөт цаг гардаг эсэх).

Судалгааны асуулга авах өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг олон улсын стандартын дагуу 5 насаар тогтоосон болно. Судалгааны асуулгыг боловсруулахдаа Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (хуучнаар), Хүүхдийн төлөө үндэсний газар болон ОУХБ/ХХУОУХ-ийн газраас асуулгын загварт саналыг авч тусган, турших замаар асуулгыг шинэчлэн боловсронгуй болгож эцэслэн, ҮСХ-ны даргын 2011 оны 01/84 тоот тушаалаар батлуулсан. Асуулгын маягыг энэхүү тайланд хавсаргав.

Судалгааны ахлагч, судлаач нарын сургалтыг 2 удаа зохион байгуулан явуулсан. Эхний сургалтыг 2011 оны 6 сарын 15-16-ны өдрүүдэд, харин 2012 оноос эхлэн тус хорооноос хийгдэж буй түүвэр судалгаа болох Өрхийн нийгэм, эдийн засгийн болон Ажиллах хүчний судалгааны мэдээлэл цуглуулах судлаачдын багийг аймаг, нийслэлийн хэмжээнд шинээр зохион байгуулан ажиллуулах болсонтой холбогдуулан 2011 оны 12 сарын 24-27-ны хооронд судалгааны ахлагч, судлаач нарын сургалтыг хоёр дахь удаагаа зохион байгуулан явуулж, дадлагуулсан болно. АХС-ны ахлагч нар хэвээрээ, харин ихэнхи асуулга авагч нар шинэчлэгдсэн учраас оны эхнээс гурван аймаг (Булган, Говь-Алтай, Сэлэнгэ) болон Улаанбаатар хотын судалгааны мэдээлэл цуглуулах ажлын явцад хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Судалгааны судлаачид сонгогдсон өрхүүдэд очиж 5 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Судалгаа авах үеэр өрхийн гишүүд эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхөө бүрэн хамруулах зорилгоор тухайн өрхөд 2-3 удаа очих тохиолдол олон байв. Судалгааны ахлагч нар түүвэрлэгдсэн өрхийг судалгаанд бүрэн хамруулж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажилласан. Судалгааны багийн гишүүд, байгууллагын удирдлагуудаас бүрдсэн хяналтын баг судалгааны ажлын явцыг хянаж, шалган гарсан ололт, дутагдлыг тухай бүр танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллав.

Судалгааны нэгдүгээр улирлын мэдээлэл цуглуулах ажил 2011 оны 7-9 сард, хоёрдугаар улирлынх 2011 оны 10-12 сард, гуравдугаар улирлынх 2012 оны 1-3 сард, дөрөвдүгээр улирлынх 2012 оны 4-6 сард хийгдэж дууссан.



## 2.4. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСХ-нд, харин өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг өгөгдсөн зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулах, шалгах, улмаар засварыг хийсний дараа ҮСХ-нд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын АХС хариуцсан ахлагч, судлаач нар хийж гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CPro 3.1 багц програмыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцож гаргах ажилд SPSS13.0 програмыг тус тус ашиглан, улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянаж, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулсан.

## 2.5 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТУУД

Судалгааны асуулгын хуудсанд тусгагдсан зарим үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтуудыг 2009 оны 6 дугаар сард ҮСХ-ны дарга, НХХ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”, НҮБ болон ОУХБ-аас зөвлөмж болгосон олон улсын нийтлэг стандарт ойлголт, тодорхойлолттой нийцүүлэн боловсруулсан. Ингэснээр энэ судалгааны үр дүнг ҮСХ-ноос явуулсан болон явуулж байгаа бусад судалгаа, бусад орны зарим судалгааны үр дүнтэй зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийх боломжийг олгож байгаа юм.

### Хүүхэд

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны (№ 182) конвенц болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид зааснаар 18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэж тодорхойлно. Тав хүртэлх насны хүүхэд ажил эрхлэх, сурах насанд хүрээгүй, балчир гэж нийтээр хүлээн зөвшөөрсний дагуу ХХС-нд 5-17 насны хүүхдийг хамруулсан.

### Нас

Хүүхдийн насыг тодорхойлохдоо бүтэн насаар нь авна. Төрсөн он, сар, өдрөөр нь тооцож бүтэн насыг тогтооно. Гэхдээ судалгаа авч байгаа өдрөөс буцааж тооцно.

### Хүүхдийн насны бүлэг

Хүүхдийн насыг 5-9, 10-11, 12-14, 15-17 гэж бүлэглэв.

Харин “Хөдөлмөрийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу хүүхдийн хөдөлмөрийг тооцохын тулд хүүхдийн насыг 5-14, 15, 16-17 гэж бүлэглэн авсан.

### Өрх

Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрлийн болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно.

### Өрхийн тэргүүлэгч

Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн өрхийн гишүүн бөгөөд насанд хүрсэн хүн байна. Хэрэв тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

### Судалгааны тайлант хугацаа

Судалгааны тайлант хугацаа нь 2011 оны 7 сараас 2012 оны 6 дугаар сарыг дуусталх хугацааг хамарна.

### Эдийн засгийн үйл ажиллагаа

Зах зээлд болон хувийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг хамруулна. Үндэсний тооцооны системийн хүрээнд бараа, үйлчилгээнд худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлд худалдах, өөртөө хэрэглэх зорилгоор өрхөд үйлдвэрлэж байгаа бараа, үйлчилгээг хамруулна. Энэ нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүнийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзнэ.

### Эдийн засгийн бус үйл ажиллагаа

Хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олохгүй үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол цай бэлтгэх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;
- Өндөр настан, өвчтөн асрах;
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах

#### **Ажиллагч**

Ажиллагч гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

#### **Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт**

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 5-11 насны, хөнгөн ажлыг 7 хоногт 14-өөс дээш цагаар хийж байгаа 12-14 насны, 7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж буй 15-17 насны бүх хүүхдийг хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй гэдэгт хамруулна.

#### **Хөдөлмөр эрхлэлтийн статус**

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн хүний ажиллаж байгаа байгууллага, бусад хүмүүстэй харьцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагаар тодорхойлогдоно

#### **Цалин хөлстэй ажиллагч**

Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэн

#### **Ажил олгогч**

Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлага

#### **Хувиараа хөдөлмөр эрхлэгч**

Дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар ажилтан авч ажиллуулдаггүй (харин богино хугацаагаар түр авч ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэн

#### **Нөхөрлөл, хоршооны гишүүн**

Үйлдвэрлэл, үйлчилгээний нөхөрлөл, хоршоонд өөрийн эд хөрөнгө, хөдөлмөрөө сайн дураар нэгтгэж гишүүнээр элссэн, үйлдвэрлэл, борлуулалт зэрэг байгууллагын бусад ажлын зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон гишүүдийн дунд ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэхэд бусад гишүүдтэй адил тэгш оролцдог иргэн

#### **Мал аж ахуй эрхлэгч**

Жилийн дөрвөн улирлын туршид өөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэн

#### **Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч**

Мал аж ахуйгаас бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцон, хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэн

#### **Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч**

Тэдний талаар зохих мэдээлэл хангалтгүй эсхүл дээр дурьдсан статусын аль нэгэнд хамаарах боломжгүй иргэн

#### **Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхэд**

Сүүлийн долоо хоногт өрхөөс гадуур цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд нэгээс дээш цагаар оролцсон, хөдөлмөр эрхлэлтийн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчоос бусад аль нэг статуст хамрагдаж буй 5-17 насны хүүхэд.



### **Ажилгүй иргэн**

Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

- а/ "ажилгүй байсан" гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;
- б/ "ажил хийхэд бэлэн" гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;
- в/ "ажил идэвхтэй хайж байгаа" гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

### **Байнгын болон тухайн үе**

Энэхүү судалгаанд "тухайн үеийн" болон "байнгын" гэсэн хугацааг хэрэглэсэн. Тухайн үе гэдэгт судалгаа явагдаж байгаа үеийн өмнөх долоо хоног, өөрөөр хэлбэл сүүлийн долоо хоног, байнгын гэдэгт судалгаа явагдаж байгаа үеийн өмнөх 12 сар, өөрөөр хэлбэл сүүлийн 12 сар гэсэн хугацааг авсан болно.

#### **Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)**

Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

#### **Эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам**

Урт хугацаагаар буюу сүүлийн арван хоёр сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

#### **Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам**

Сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан нь тодорхойлогдох ажиллагч болон ажилгүй иргэдийг хамруулна.

#### **Эдийн засгийн идэвхгүй хүн ам**

Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа зургаан сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам гэж хоёр ангилна.

#### **Эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам**

Урт хугацаагаар буюу сүүлийн арван хоёр сарын хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагаагаараа эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогдохгүй (ажиллагч болон ажилгүй иргэнд хамаарахгүй) хүн амыг, тухайлбал: оюутан, сурагч, гэрийн ажилтай болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хүн амыг хамруулна.

#### **Эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам**

Сүүлийн долоо хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй иргэдийн алинд ч хамаарахгүй хүн амыг хамруулна.

#### **Эдийн засгийн үйл ажиллагааны салбар**

Тухайн хүний ажиллаж байгаа ажлын байр, үйлдвэрийн газар, байгууллагын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно. Олон Улсын Стандарт Ангилал 4-т нийцүүлэн боловсруулсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг ашигласан.

#### **Ажил мэргэжил**

Цалин, хөлс, орлого олох зорилгоор тухайн хүний хийж гүйцэтгэж буй эдийн засгийн үйл ажиллагааны ажил, мэргэжлийн төрлийг ажил, мэргэжил гэнэ. Хэрвээ тухайн хүн ажилгүй байгаа бол

эрхлэхэд бэлэн байгаа ажил, мэргэжлийн төрлийг тухайн хүний ажил, мэргэжил гэж үзнэ.

#### **Үндсэн үйл ажиллагаа**

Тухайн хүн хоёр болон түүнээс дээш төрлийн ажлыг хөлсөөр болон хувиараа эрхэлж байгаа бол тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан эсхүл хамгийн их орлого олсон ажлыг хэлнэ.

#### **Үндсэн ажил**

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхэлдэг бол түүнийг үндсэн ажилд тооцно.

#### **Давхар ажил**

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлаас бусад ажлыг давхар ажил гэж тодорхойлно.

#### **Цалин хөлс**

Мөнгөн болон биет хэлбэрээр авч байгаа хөлс, урамшуулал, гарын мөнгө, ашиг орлогын хувь, илүү цаг ажилласны мөнгө, ажил олгогчоос хангаж байгаа хоол хүнс, байрыг цалин хөлсөд хамааруулна.

#### **Бичиг үсгийн мэдлэг**

Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзнэ. Харин аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг бичиг үсэг мэддэггүй гэж үзнэ. Мөн уншдаг боловч бичиж чаддаггүй, өөрөөр хэлбэл уншиж, ойлгох, бичих чадварын аль нэгийг эзэмшээгүй тохиолдолд бичиг үсэг мэддэггүй гэж үзнэ.

#### **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд (ХХТХ)**

- Боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаанууд;
- Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл тийм үйл ажиллагаанд ашиглах, элсүүлэх, эсвэл тийм үйл ажиллагаанд оролцохыг санал болгох;
- Хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг олон улсын холбогдох гэрээнүүдэд заагдсан хууль бус үйл ажиллагаанд оролцохыг санал болгох;
- Мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хохирол учруулахуйц ажлыг хамааруулна.

#### **Аюултай ажил**

Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий (аюултай салбар, ажил мэргэжил) аливаа ажил, үйл ажиллагааг хэлнэ. Уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар ажиллаж байгаа бол аюултай ажил эрхэлж байна гэж үзнэ.

#### **Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт**

Монгол Улсын хэмжээнд НХХ-ийн (хуучин нэрээр) сайдын 2008 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 107 тоот тушаалаар батлагдсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдөн ажиллаж байна.

Энэхүү жагсаалт нь дараах 4 үндсэн бүлгээс бүрдэнэ. Үүнд:

1. Насанд хүрээгүй хүний эрүүл мэнд, амь нас, ёс суртахуун, аюулгүй байдал, хөгжилд нийтлэг аюултай ажлын байр, ажил мэргэжил
2. Ажлын байрны орчин нөхцөлтэй холбоотой хориглох ажлын байр, ажил мэргэжил
3. Үйлдвэрлэлийн явцын аюултай холбоотой хориглох ажлын байр, ажил мэргэжил
4. Бусад хориглох ажил мэргэжил



**БҮЛЭГ**

**ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН  
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

### 3.1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Энэ бүлэгт АХС+ХХС-ны дөрвөн улирлын турш (2011 оны 7 дугаар сараас 2012 оны 6 дугаар сарыг дуусталх) нийт 1068 нэгжийн 12816 өрхөөс цуглуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэн тооцсон судалгааны үр дүнг танилцуулж байна.

ХХС нь ОУХБ-аас гаргасан нийтлэг ойлголт, тодорхойлолт, арга зүйн дагуу хийгдэж байгаа 3 дахь түүвэр судалгаа юм. ҮСХ-ноос судалгааны тоо мэдээ, үр дүнг улирал тус бүрээр болон бүтэн жилээр нэгтгэн боловсруулдаг. Өөрөөр хэлбэл энэ тайлан нь улирал бүрээр болон дөрвөн улирлаар нэгтгэн боловсруулсан тоо мэдээ, үр дүнд үндэслэсэн бөгөөд тайланд зөвхөн үндсэн үр дүнг харуулсан хүснэгтүүдийг оруулсан болно.

### 3.2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2011-2012 оны АХС+ХХС-гаар хүн амын тоо, насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, сургууль завсардалтын шалтгаан, өрхийн ам бүлийн тоо гэх мэт хүн ам зүйн холбогдолтой үндсэн үзүүлэлтүүдийг хот, хөдөөгөөр, бүс нутгаар боловсруулав. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийг эдгээр ангиллаар тооцон боловсруулахад түүврийн нийт хэмжээг хангалттай гэж үзэж, дөрвөн улирлын нэгдсэн тоонд үндэслэн дэлгэрэнгүй хүснэгтүүдийн мэдээллийг байршлаар болон бүс, аймаг, нийслэлээр тооцон гаргав.

### 3.3. ХҮН АМЫН ТОО, БАЙРШИЛ, БҮС НУТГААР

Судалгаанд дотуур байр, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, эмнэлэг, сувилал зэрэг нийтийн байранд амьдрагчид, байнгын орон гэргүй хүн ам болон 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй болно.

Гэхдээ судалгааны хугацаанд өрхийн гишүүдээс хичнээн хүн 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгааг тодруулах зорилгоор судалгаанд хамрагдсан өрхүүдээс 6 сар ба түүнээс дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа өрхийн гишүүд байгаа эсэх, байгаа бол ямар шалтгаанаар өрхөөс тусдаа амьдарч байгааг асууж судлан, гарсан дүнг *Хүснэгт 3.1-д* үзүүлээ. Харин эдгээр хүмүүс дээр дурьдсаны дагуу судалгаанд хамрагдаагүй болохыг анхааралдаа авна уу.

Судалгааны дүнгээр тухайн өрхийн гишүүн боловч 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа нийт 202.542 хүн байгаагийн 59.7 хувь нь хөдөөгийн, 40.3 хувь нь хотын хүн ам байна. Эдгээр өрхийн гишүүдийн 30.4 хувь нь хангайн бүсэд, 23.6 хувь нь баруун бүсэд, 20.2 хувь нь төвийн бүсэд, 7.0 хувь нь зүүн бүсэд, 18.8 хувь нь нийслэл хотын өрхүүдэд харъяалалтай бөгөөд тэдгээрийн 64.0 хувь буюу 129.700 нь сургууль, курст суралцаж, 24.5 хувь буюу 49.600 нь ажил эрхэлж байгаа учраас өрхөөс гадуур 6 сараас дээш хугацаагаар амьдарч байна.

*Хүснэгт 3.1. Өрхөөс гадуур 6 сараас дээш хугацаагаар байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөөгөөр, бүсээр*

Хот, хөдөө/ бүс	Өрхийн тоо	Өрхийн гишүүдийн тоо	Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	Үүнээс		
				Суралцаж байгаа	Ажиллаж байгаа	Бусад
Хот	51913	165251	81704	41329	26365	14010
Хөдөө	67654	227228	120838	88323	23224	9292
Төв	24445	77072	40974	28614	8375	3985
Зүүн	8982	35467	14148	10563	2313	1272
Баруун	26816	102040	47725	34938	7848	4939
Хангай	36130	109575	61541	44252	13742	3547
Улаанбаатар	23194	68325	38154	11285	17310	9559
<b>Дүн</b>	<b>119567</b>	<b>392479</b>	<b>202542</b>	<b>129652</b>	<b>49588</b>	<b>23302</b>

Судалгааны үр дүнг өрхөөс гадуур амьдарч байгаа цэрэг, хоригдол, дотуур байр болон нийтийн байранд амьдарч байгаа мөн 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг оруулахгүйгээр судалгаанд хамрагдсан хүн амын тоонд үндэслэн боловсруулсан.

Хүснэгт 3.2-д судалгаанд хамрагдсан өрх, хүн амын тоог хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр харуулав. Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 59.0 хувь нь хот, суурин газарт амьдарч байна.

Хүснэгт 3.2. Судалгаанд хамрагдсан өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр, хүйсээр

Байршил/ Бүс	Өрх		Өрхийн ам бүлийн дундаж тоо	Хүн амын тоо		
	Тоо	%		Бүгд	Хүйсээр, %	
				Эрэгтэй	Эмэгтэй	
Хот	418775	59.3	3.5	1454932	48.2	51.8
Хөдөө	286843	40.7	3.5	1009076	50.4	49.6
Төв	121036	17.2	3.3	404025	50.1	49.9
Зүүн	55657	7.9	3.6	200211	48.8	51.2
Баруун	99431	14.1	4.0	400982	51.0	49.0
Хангай	158368	22.4	3.3	520416	48.7	51.3
Улаанбаатар	271126	38.4	3.5	938374	48.2	51.8
<b>Улсын дүн</b>	<b>705618</b>	<b>100.0</b>	<b>3.5</b>	<b>2464008</b>	<b>49.1</b>	<b>50.9</b>

Хүн амын байршлыг бүс нутгаар авч үзвэл 38.1 хувь нь нийслэл хотод, 21.1 хувь нь хангайн бүсэд, 16.4 хувь нь төвийн бүсэд, 16.3 хувь нь баруун бүсэд, 8.1 хувь нь зүүн бүсэд амьдарч байна.

### 3.4. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын насны бүтцийг ХАОСТ болон АХС-ны дүнгээр Зураг 3.1-д харуулав.

Зураг 3.1. Хүн амын насны бүтэц, ХАОСТ, АХС-ны дүнгээр



Хүн амын насны бүтцийг Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого болон АХС+ХХС явуулсан онуудаар харуулав. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 69.0 хувийг 15-64 насны хүн ам, 3.7 хувийг 65, түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. Ажиллах хүчний судалгаагаар нийт хүн амын 67.9 хувийг 15-64 насны хүн ам, 4.1 хувийг 65, түүнээс дээш насны хүн ам тус тус эзэлж байна.

### 3.5. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ

Хөдөлмөрийн насны бус хүн амын нийгэмд үзүүлэх ачааллыг хүн ам зүйн ачаалал гэж үздэг. Хүн ам зүйн ачааллыг 15 хүртэлх насны хүүхэд болон 65 ба түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг 15-64 насны хүн амын тоонд харьцуулж тодорхойлох бөгөөд судалгааны дүнгээр хөдөлмөрийн насны 100 хүн тутамд хөдөлмөрийн насны бус 47.2 хүн ногдож байна. Хүснэгт 3.3-д Хүн ам зүйн ачааллыг байршил, бүс нутгаар харуулсан бөгөөд хөдөлмөрийн насны хүн амд ногдох ачаалал улсын дунджаас хот, суурин газар болон Улаанбаатар хотод 4 хүнээр цөөн, хангай болон төвийн бүсэд улсын дундажтай ойролцоо, харин хөдөөд 4 хүнээр, баруун бүсэд хамгийн олон буюу 8 хүнээр их байна. Эндээс харахад баруун бүсэд хүн ам зүйн ачаалал хамгийн өндөр гарчээ.

Хүснэгт 3.3. Хүн ам зүйн ачаалал, хот, хөдөө, бүсээр

Хүн ам зүйн ачаалал	Бүгд	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
<b>Залуу насны (0-14)</b>	41.2	38.2	45.7	42.3	44.1	50.9	41.0	36.4
<b>Ахимаг насны (65+)</b>	6.0	6.2	5.7	6.7	6.3	4.2	6.0	6.3
Улсын дундаж	<b>47.2</b>	<b>44.4</b>	<b>51.4</b>	<b>49.0</b>	<b>50.4</b>	<b>55.1</b>	<b>47.0</b>	<b>42.7</b>

Дээр дурьдсанчлан энэхүү тооцоонд сургууль, курст суралцах, ажиллах зорилгоор өрхөөс гадуур б сараас дээш хугацаагаар амьдарч байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй болно.

### 3.6. ӨРХИЙН БҮТЭЦ

Хүснэгт 3.4-д нийт өрхийн тоог ам бүлийн тоо болон хот, хөдөө, бүс нутгаар харуулав.

Хүснэгт 3.4. Өрхийн тоо, ам бүлийн тоогоор, байршлаар, бүсээр, %

Өрхийн ам бүлийн тоо	Улсын дүн	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
1	10.4	10.5	10.2	11.5	9.7	6.7	11.1	11.0
2	17.1	16.6	18.0	19.0	14.5	12.8	20.2	16.7
3	23.7	24.8	22.2	24.5	22.8	18.9	25.2	24.5
4	24.9	25.7	23.7	24.0	25.0	24.5	24.7	25.6
5	14.4	13.5	15.8	14.2	19.6	18.3	12.5	13.2
6	6.4	5.7	6.9	4.9	5.7	11.3	4.7	5.8
7	1.9	1.9	2.1	1.3	1.6	4.7	1.1	1.8
8+	1.2	1.3	1.1	0.6	1.1	2.8	0.5	1.4
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Түр эзгүй байгаа хүнийг оруулаагүй өрхийн ам бүлийн дундаж тоо</b>	<b>3.5</b>	<b>3.5</b>	<b>3.5</b>	<b>3.3</b>	<b>3.6</b>	<b>4.0</b>	<b>3.3</b>	<b>3.5</b>

Судалгааны дүнгээр өрхийн ам бүлийн тоонд өрхийн түр эзгүй байсан гишүүдийг оруулаагүйгээс шалтгаалж өрхийн ам бүлийн дундаж тоо нь доогуур гарсан.

Нийт өрхийн 10.4 хувь нь нэг ам бүлтэй өрх, харин 3.1 хувийг 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрх эзэлж байна. Баруун бүсийн өрхийн ам бүлийн дундаж тоо 4.0 байгаа нь улсын дундаж болон бусад бүс нутгаас өндөр байгаагийн зэрэгцээ энэ бүсийн нийт өрхийн 7.5 хувийг 7 ба түүнээс дээш ам бүлтэй өрх эзэлж байна.



### 3.7. ЭМЭГТЭЙ ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХ

Судалгаагаар нийт өрхийн 21.3 хувь, хотын өрхийн 24.7 хувь, хөдөөгийн өрхийн 16.4 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувийн жинг ам бүлийн тоо болон хот, хөдөөгөөр Хүснэгт 3.5-д харуулав. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд гол төлөв цөөхөн ам бүлтэй байгаагаас өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь хэмжээ багасч байна. Тухайлбал, нэг ам бүлтэй өрхийн 46.8 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байхад, 2-3 ам бүлтэй өрхийн 54.3 хувь, 4-6 ам бүлтэй өрхийн 35.7 хувь, 7-гоос дээш ам бүлтэй өрхийн 31.7 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

*Хүснэгт 3.5 Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор, хот, хөдөөгөөр*

Өрхийн ам бүлийн тоо	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх		
	Бүгд	Хот	Хөдөө
1	46.8	46.0	48.1
2	33.9	39.2	26.8
3	20.4	24.7	13.4
4	11.6	14.2	7.5
5	11.0	13.6	7.8
6	13.1	18.7	6.3
7	13.0	19.7	4.2
8+	18.7	23.1	11.0
<b>Улсын дундаж</b>	<b>21.3</b>	<b>24.7</b>	<b>16.4</b>

### 3.8. БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Судалгаагаар хүн амын эзэмшсэн боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, сургууль завсардалтын шалтгаан, бичиг үсгийн мэдлэгийн талаарх мэдээллийг цуглуулсан.

15 ба түүнээс дээш насны хүн амын эзэмшсэн боловсролын түвшинг Хүснэгт 3.6-д харуулав. Хүн амын 1.1 хувийг магистр, 18.8 хувийг дээд/бакалавр, 6.4 хувийг дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд, 6.7 хувийг мэргэжлийн анхан шатны, 31.6 хувийг бүрэн дунд, 22.0 хувийг суурь, 7.0 хувийг бага, 6.4 хувийг боловсролгүй хүмүүс эзэлж байна. Хүснэгтээс харахад хот, хөдөөгийн алинд ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзэмшсэн боловсролын түвшин бараг ойролцоо, гэхдээ дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролоос дээш боловсролтой эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Хүснэгт 3.6-аас харахад эрэгтэйчүүдийн 7.5 хувь, эмэгтэйчүүдийн 5.5 хувь нь боловсролгүй, эрэгтэйчүүдийн 7.0 хувь, эмэгтэйчүүдийн 6.9 хувь нь бага боловсролтой байна. Хөдөөгийн хүн амын 10.3-14.4 хувь нь боловсролгүй, 11.3-11.7 хувь нь бага боловсрол эзэмшсэн байна. Хотын хүн амын 24.6-29.5 хувь нь, хөдөөгийн хүн амын 7.0-11.0 хувь нь бакалаврын болон магистрийн зэрэг эзэмшсэн байна. Хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд хөдөөд доогуур байна.

*Хүснэгт 3.6. 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, боловсролын түвшингээр, хүйсээр, хот, хөдөөгөөр, %*

Боловсролын түвшин	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Боловсролгүй	6.4	7.5	5.5	2.7	2.5	14.4	10.3
Бага	7.0	7.0	6.9	3.7	4.2	11.7	11.3
Суурь	22.0	23.9	20.2	16.0	13.5	35.4	30.7
Бүрэн дунд	31.6	32.5	30.7	39.8	34.5	21.9	24.6
Мэргэжлийн анхан шатны	6.7	7.0	6.4	7.5	6.9	6.3	5.6
Дипломын дээд, тусгай мэргэжлийн дунд	6.4	4.7	8.0	5.7	8.9	3.3	6.4
Дээд/бакалавр	18.8	16.4	21.1	23.1	27.5	6.8	10.8
Магистр ба түүнээс дээш	1.1	0.9	1.3	1.5	2.0	0.2	0.2
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>15 ба түүнээс дээш насны хүн амын тоо</b>	<b>1774329</b>	<b>853347</b>	<b>920983</b>	<b>505041</b>	<b>564795</b>	<b>348306</b>	<b>356188</b>

### 3.9 СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТЫН ШАЛТГААН

Судалгааны тархаалтын дүнгээр 6-18 насны хүн амын 96.0 хувь нь, үүнээс хөвгүүдийн 94.6 хувь, охидын 97.4 хувь нь сургуульд суралцаж байна. Сургуулийн насанд хүрсэн боловч сургуульд оройтож орж байгаа нь сургуульд хамрагдалтын түвшинг бууруулахад нөлөөлж байгааг Хүснэгт 3.7-оос үзэж болно. Хот, хөдөөгийн алинд ч охидын сургуульд хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс дээгүүр байна. Хот, суурин газарт сургуулийн бага ангид охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын түвшин бараг адил байснаа 13 наснаас эхлэн өөрчлөгдөж эхэлжээ. Хөдөө орон нутагт анх сургуульд орохоос эхлэн сургууль төгсөх хүртэлх бүх шатанд охидын сургуульд хамрагдалтын түвшин хөвгүүдийнхээс өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн өсвөр насны охидын сургуульд хамрагдалтын түвшин мөн насны хөвгүүдийнхээс нилээд дээгүүр байгаа нь бусад хөгжиж буй орнуудаас ялгаатай дүр зургийг харуулж байна.


Хүснэгт 3.7. 6-18 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр

Бүтэн нас	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	%	%	%	%	%	%	%	%	%
6	81.6	78.3	85.0	83.4	80.4	86.4	79.3	75.6	83.1
7	98.2	98.7	97.5	98.8	98.6	98.9	97.4	98.8	95.7
8	98.9	97.7	100.0	99.2	98.4	100.0	98.4	97.1	100.0
9	99.1	98.8	99.3	99.8	100.0	99.6	98.2	97.3	98.9
10	99.2	98.6	100.0	99.3	98.7	100.0	99.1	98.4	100.0
11	98.1	97.7	98.6	99.3	99.3	99.4	96.8	96.0	97.6
12	99.0	98.5	99.4	99.8	100.0	99.7	98.1	97.0	99.1
13	97.2	95.6	98.8	99.7	99.5	100.0	94.4	91.3	97.7
14	97.4	96.0	98.9	98.6	97.6	99.7	96.0	94.5	98.0
15	95.9	93.2	98.4	98.1	97.5	98.6	93.4	88.8	98.2
16	95.4	93.7	97.0	97.7	97.0	98.5	92.4	89.3	95.3
17	93.3	90.1	96.6	97.2	95.9	98.3	88.5	83.7	94.4
18	94.5	93.1	96.1	98.3	98.6	98.0	88.9	85.8	92.9
<b>6-18 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь</b>	<b>96.0</b>	<b>94.6</b>	<b>97.4</b>	<b>97.7</b>	<b>97.1</b>	<b>98.3</b>	<b>94.0</b>	<b>91.8</b>	<b>96.4</b>
Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо	561015	282807	278209	155056	156604	311660	127750	121605	249355
<b>6-18 насны нийт хүүхдийн тоо</b>	<b>584169</b>	<b>297911</b>	<b>286258</b>	<b>160247</b>	<b>161752</b>	<b>321999</b>	<b>137664</b>	<b>124506</b>	<b>262169</b>

Хөдөө орон нутагт мал аж ахуйн ажилд туслах зорилгоор хөвгүүд сургууль завсардаж, мөн боловсрол эзэмшсэн залуучуудад ажил олдохгүй байгаа зэрэг нь сургуульд хамрагдалтын түвшинд нөлөөлж байгаа юм. Хот, суурин газарт 15-17 настай хөвгүүдийн 90-ээс дээш хувь нь сургуульдаа үргэлжлүүлэн суралцаж байхад хөдөө орон нутагт энэ үзүүлэлт харьцангуй доогуур байгаа нь хөвгүүдийн сургууль завсардалт их байгаатай холбоотой.



Зураг 3.2 Сургуулиас завсардсан хүний тоо, шалтгаанаар



Сургуулиас завсардсан хүн амыг шалтгаанаар нь авч үзвэл 3.7 хувь нь өвчтэй, 8.3 хувь нь гэрийн ажилд туслах, 9.6 хувь нь эцэг, эх нь сургуулиас гаргасан, 10.0 хувь нь сурлага муу сурах сонирхолгүй, 10.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 23.5 хувь нь сурах нас хүрээгүй, 24.8 хувь нь мал маллахаар, 9.6 хувь нь бусад шалтгаанаар сургуулиас завсардсан хүүхдүүд байна.

### 3.10 БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИН

Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны хүн амын бичиг үсэгт тайлагдалтыг тодорхойлохын тулд “энгийн захиа уншиж, бичиж чадах уу” гэж асууж, энгийн бичиг захиаг уншиж, бичиж чадаж байвал бичиг үсэгт тайлагдсанд тооцсон болно. Харин зөвхөн өөрийнхөө нэрийг унших эсвэл тоо уншиж чаддаг боловч бичиж чаддаггүй бол тэр хүнийг бичиг үсэгт тайлагдсанд тооцоогүй.

Хүснэгт 3.8. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, хот, хөдөө, бүсээр, хүйсээр

Хот, хөдөө/бүс	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хот	98.9	99.0	98.8
Хөдөө	97.4	97.5	97.4
Төв	98.3	98.4	98.2
Зүүн	97.1	97.0	97.2
Баруун	97.2	97.6	96.7
Хангай	98.0	98.0	98.0
Улаанбаатар	99.2	99.2	99.2
Улсын дүн	<b>98.3</b>	<b>98.4</b>	<b>98.2</b>

Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийг 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын дунд энгийн бичиг, захиа уншиж, бичиж чаддаг хүний эзлэх хувиар тодорхойлов. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин 98.3 хувь байсан бол энэ удаагийн судалгаагаар хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин ижил түвшинд байна. Хүснэгт 3.8-аас харахад хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин хөдөөд 97.4 хувь байхад хотод үүнээс 1.5 пунктээр дээгүүр буюу 98.9 хувьтай байна.

## Хүснэгт 3.9. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, насны бүлгээр, хот, хөдөөгөөр, хүйсээр

Насны бүлэг	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15 – 24	98.5	98.3	98.7	99.2	99.0	99.4	97.4	97.3	97.5
25 – 34	98.0	97.7	98.3	98.6	98.5	98.8	97.0	96.4	97.6
35 – 44	99.1	98.9	99.3	99.5	99.4	99.6	98.6	98.3	98.8
45 – 54	99.0	99.0	98.9	99.6	99.7	99.5	98.1	98.1	98.1
55 – 64	98.7	98.6	98.7	98.9	99.4	98.6	98.2	97.5	98.8
65+	93.0	96.8	90.2	94.3	97.0	92.3	90.9	96.5	86.7
<b>Дүн</b>	<b>98.3</b>	<b>98.4</b>	<b>98.2</b>	<b>98.9</b>	<b>99.0</b>	<b>98.8</b>	<b>97.4</b>	<b>97.5</b>	<b>97.4</b>

Эрэгтэй, эмэгтэй 64 хүртэлх насны хүн амын бичиг үсэгт тайлагдалтын түвшин 98-аас дээш хувьтай байна.



IV

БҮЛЭГ

АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД, ТЭДНИЙ  
ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ,  
СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

#### 4.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

ХХС-гаар 5-17 насны хүүхдийн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоог тодорхойлох зорилгыг тавьсан. Тайлангийн энэ хэсэгт 5-17 насны хүүхдийн тоо насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, тэдгээрийн өрх, гэр бүлийн байдал, орон сууцны нөхцөл, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, сургуульд хамрагдаагүй шалтгаан, ажил эрхэлж буй хүүхдийн нийгэм эдийн засгийн байдал, хүүхдүүдэд чөлөөт цаг гардаг эсэх гээд ажил эрхэлж буй болон нийт хүүхэдтэй холбоотой бүхий л мэдээллийг гүнзгийрүүлэн судлахыг зорилоо.

#### 4.2. 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШИЛ, БҮСЭЭР

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 34.1 хувь буюу 840.9 мянга нь 0-17 насны хүүхэд байна. Эдгээр хүүхдийг хүйсээр авч үзэхэд 432.3 мянга нь хөвгүүд, 408.6 мянга нь охид, хүйсийн харьцаа 105.8 байгаа бөгөөд улсын дундажтай харьцуулахад 9.3 пунктээр илүү байна.

0-17 насны нийт хүүхдийн 55.7 хувь буюу 468.1 мянга нь хот, суурин газарт, 44.3 хувь буюу 372.8 мянга нь хөдөө, орон нутагт амьдарч байна.

*Хүснэгт 4.1 Хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр*

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Нийт хүн ам</b>	<b>2 464 008</b>	<b>1 210 117</b>	<b>1 253 891</b>	<b>1 454 932</b>	<b>701 088</b>	<b>753 844</b>	<b>1 009 076</b>	<b>509 029</b>	<b>500 047</b>
<b>0-17 насны хүүхэд</b>	<b>840 896</b>	<b>432 292</b>	<b>408 604</b>	<b>468 054</b>	<b>236 527</b>	<b>231 527</b>	<b>372 842</b>	<b>195 765</b>	<b>177 077</b>
0 - 4	251 820	131 614	120 206	147 157	76 017	71 140	104 663	55 597	49 066
5 - 9	201 840	102 276	99 564	111 954	55 416	56 538	89 886	46 860	43 026
10 - 11	91 630	48 058	43 572	51 112	26 190	24 922	40 518	21 868	18 650
12 - 14	144 390	74 823	69 567	74 875	38 425	36 450	69 515	36 398	33 117
15 - 17	151 216	75 521	75 695	82 956	40 479	42 477	68 260	35 042	33 218
<b>5 - 17 насны хүүхэд</b>	<b>589 076</b>	<b>300 678</b>	<b>288 398</b>	<b>320 897</b>	<b>160 510</b>	<b>160 387</b>	<b>268 179</b>	<b>140 168</b>	<b>128 011</b>

0-17 насны нийт хүүхдийн 70.1 хувь буюу 589.1 мянга нь 5-17 насны хүүхэд байгаагийн 51.0 хувь буюу 300.7 мянга нь хөвгүүд, 49.0 хувь буюу 288.4 мянга нь охид байна. 5-17 насны нийт хүүхдийн 54.5 хувь буюу 320.9 мянга нь хот, суурин газарт, 45.5 хувь буюу 268.2 мянга нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Харин насны бүлгээр авч үзвэл 5-17 насны нийт хүүхдийн 34.3 хувь буюу 201.9 мянга нь 5-9 настай, 15.5 хувь буюу 91.6 мянга нь 10-11 настай, 24.5 хувь буюу 144.4 мянга нь 12-14 настай, 25.7 хувь буюу 151.2 мянга нь 15-17 настай хүүхдүүд байна (Хүснэгт 4.2).

*Хүснэгт 4.2 5-17 насны хүүхдийн нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр, хувиар*

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Хүн амын тоо</b>	<b>2 464 008</b>	<b>1 210 117</b>	<b>1 253 891</b>	<b>1 454 932</b>	<b>701 088</b>	<b>753 844</b>	<b>1 009 076</b>	<b>509 029</b>	<b>500 047</b>
<b>5-17 насны хүүхэд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
5 - 9	34.3	34.0	34.5	34.9	34.5	35.3	33.5	33.4	33.6
10 - 11	15.5	16.0	15.1	15.9	16.3	15.5	15.1	15.6	14.6
12 - 14	24.5	24.9	24.1	23.3	24.0	22.7	25.9	26.0	25.9
15 - 17	25.7	25.1	26.3	25.9	25.2	26.5	25.5	25.0	25.9

Судалгаагаар 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн тоог, ямар шалтгаанаар өрхөөс гадуур амьдарч байгаагаар нь тооцож гаргасан. Нийт 55.4 мянган хүүхэд өрхөөс гадуур амьдарч байгаа нь судалгаанд хамрагдсан энэ насны 589.1 мянган хүүхдийн 9.4 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 4.3 5-17 насны өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн тоо, шалтгаан, хот, хөдөөгөөр

Шалтгаан	Бүгд	Үүнээс:	
		Хот	Хөдөө
<b>Бүгд</b>	<b>55 448</b>	<b>11 465</b>	<b>43 983</b>
Суралцаж байгаа	45 362	5 079	40 283
Ажиллаж хийж байгаа	3 437	1 304	2 133
Бусад	6 649	5 082	1 567
Бүгдэд эзлэх хувь			
Суралцаж байгаа	100.0	11.2	88.8
Ажиллаж хийж байгаа	100.0	37.9	62.1
Бусад	100.0	76.4	23.6
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>20.7</b>	<b>79.3</b>
Дүнд эзлэх хувь			
Суралцаж байгаа	81.8	44.3	91.6
Ажиллаж хийж байгаа	6.2	11.4	4.8
Бусад	12.0	44.3	3.6
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Хүснэгт 4.3-аас харахад 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн дийлэнх нь буюу 79.3 хувь нь хөдөө, орон нутгийн хүүхдүүд байгаа бөгөөд тэдний 91.6 хувь нь сурч, боловсрохын тулд өрхөөсөө гадуур амьдарч байна. Хөдөөд өрхөөс гадуур амьдарч байгаа хүүхдийн тоо ийнхүү өндөр байгаа нь сургууль хүрэлцэхгүй, хол байршдаг, мөн сургалтын чанартай ч холбоотой байж болох талтай. Хот, суурин газрын хүүхдийн өрхөөс гадуур амьдарч байгаа үндсэн шалтгаан нь мөн суралцахтай холбоотой байгаа бөгөөд энэ шалтгаан нь 44.3 хувьтай байна. Өрхөөс гадуур амьдарч буй хот, суурин газрын хүүхдийн 11.4 хувь нь ажиллаж, харин 44.3 хувь нь сурч, ажиллахаас бусад өөр шалтгаанаар өрхөөс гадуур амьдарч байгааг гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй байна.

Судалгаанд хамрагдсан нийт 5-17 насны хүүхдийн 1.7 хувь буюу 9.9 мянга нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагийн 56.4 хувь нь хөвгүүд, 43.6 хувь нь охид байна. Эдгээр хүүхдийн 67.0 хувь нь төрөлхийн, 33.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байгааг давхардсан дүнгээр дараах зургаар харууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй гурван хүүхдийн нэг нь хэл яриа, тулах эрхтэн болон сэтгэцийн хөгжлийн аль нэгэн бэрхшээлтэй хүүхэд байна.


Зураг 4.1 5-17 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр



### 4.3. 5-17 НАСНЫ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 16.5 хувь буюу 97.3 мянга нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байна. Зүүн бүс болон Улаанбаатар хотод эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч буй хүүхдийн хувь улсын дунджаас 0.8-7.5 пунктээр илүү байна. Хот, хөдөөгийн хувьд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн харьцаа нилээд зөрүүтэй гарчээ (Зураг 4.2). Хотод 5-17 насны хүүхэдтэй таван өрх тутмын нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байхад хөдөөд арван өрхийн нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна.

Зураг 4.2 Өрхийн тэргүүлэгчийн бүтэц, хот, хөдөөгөөр



5-17 насны хүүхдийг өрхийн ам бүлийн тоогоор нь авч үзэхэд дийлэнх нь буюу 44.4 хувь нь 3-4 ам бүлтэй, 43.0 хувь нь 5-6 ам бүлтэй өрхөд амьдарч байна. Энэ харьцаа нь хот, хөдөө болон бүсийн хувьд ерөнхийдөө ойролцоо байна.

Нөгөө талаас Улаанбаатар хот, төвийн болон хангайн бүсийн 5-17 насны хүүхдийн 3.9-4.6 хувь нь 1-2 ам бүлтэй, 48.4-50.2 хувь нь 3-4 ам бүлтэй айлын хүүхэд байгаа ба 7-8 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн хувь энэ бүсэд 4.8-5.9 хувь, 9-өөс дээш ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн тоо 0.2-2.0 хувьтай гарсан байна. Эндээс харахад цөөхөн ам бүлтэй өрх Улаанбаатар хот болон төв, хангайн бүсэд нилээд хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.4 5-17 насны хүүхэд, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоогоор, хувиар

Байршил, бүс	Бүгд	Өрхийн тэргүүлэгчээр		Өрхийн ам бүлийн тоо				
		Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	< 3	3 - 4	5 - 6	7 - 8	9 +
Хот	100.0	79.4	20.6	4.2	49.4	38.0	6.6	1.8
Хөдөө	100.0	88.3	11.7	2.5	38.4	49.0	8.6	1.5
<b>Бүс</b>								
Баруун	100.0	91.0	9.0	1.4	28.6	50.1	16.2	3.7
Хангайн	100.0	85.0	15.0	3.9	48.4	42.7	4.8	0.2
Төвийн	100.0	84.3	15.7	3.9	48.5	42.3	4.8	0.5
Зүүн	100.0	82.9	17.1	2.0	43.0	49.1	4.6	1.3
Улаанбаатар	100.0	77.2	22.8	4.6	50.2	37.3	5.9	2.0
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>83.5</b>	<b>16.5</b>	<b>3.4</b>	<b>44.4</b>	<b>43.0</b>	<b>7.5</b>	<b>1.7</b>

Харин баруун бүсийн хувьд 1-2 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн тоо бага (1.4 хувь), харин 9-өөс дээш ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн нийт дүнд эзлэх хувь 3.7 байгаа нь бусад бүсүүдээс илүү олон ам бүлтэй өрхөд амьдарч байгааг харуулж байна.

5-17 насны хүүхэдтэй эмэгтэй тэргүүлэгчтэй арван өрхийн долоо нь хот, суурин газарт амьдарч байна.

## Хүснэгт 4.4.а 5-17 насны хүүхэд, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоогоор, хот, хөдөө, бүсээр, хувиар


Байршил, бүс	Бүгд	Өрхийн тэргүүлэгчээр		Өрхийн ам бүлийн тоо				
		Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	< 3	3 - 4	5 - 6	7 - 8	9 +
Хот	54.5	51.8	67.8	66.2	60.6	48.1	48.1	59.1
Хөдөө	45.5	48.2	32.2	33.8	39.4	51.9	51.9	40.9
<b>Бүс</b>								
Баруун	21.0	23.0	11.3	8.5	13.6	24.4	45.4	46.6
Хангайн	21.8	22.2	19.8	24.8	23.8	21.7	13.8	2.5
Төвийн	16.8	16.9	16.0	18.9	18.3	16.5	10.8	5.6
Зүүн	8.5	8.4	8.8	5.0	8.2	9.7	5.2	6.4
Улаанбаатар	31.9	29.5	44.1	42.8	36.1	27.7	24.8	38.9
<b>Бүгд</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Гурав хүртэлх ам бүлтэй 5-17 насны хүүхэдтэй таван өрхийн хоёр нь Улаанбаатар хотод, нэг нь баруун бүсэд байгаа бол 7-гоос дээш ам бүлтэй бараг хоёр өрхийн нэг нь баруун бүсэд амьдарч байна.


## 4.4. 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН АМЬДАРЧ БУЙ ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, АХУЙН НӨХЦӨЛ

Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 45.7 хувь буюу 268.9 мянга нь гэрт, 33.8 хувь буюу 199.2 мянга нь сууцны тусдаа байшинд, 17.5 хувь буюу 102.9 мянга нь орон сууцны байшинд амьдарч байна. 5-17 насны хүүхдийн амьдарч буй өрхийн ахуйн нөхцлийн үзүүлэлт болон цахилгаан, усан хангамжийг дараах зургуудаар харууллаа.

Зураг 4.3 5-17 насны хүүхэдтэй өрх, амьдарч буй сууцны төрлөөр




Зураг 4.4 5-17 насны хүүхэдтэй өрх, амьдарч буй сууцны эзэмшлийн хэлбэрээр




Нийт 5-17 насны хүүхдийн 97.9 хувь нь гэртээ цахилгаан хангамжтай байгаагийн 78.1 хувь нь төвлөрсөн системд холбогдсон байна.

Зураг 4.5 5-17 насны хүүхэдтэй өрх, цахилгааны эх үүсвэрээр



Зураг 4.6 5-17 насны хүүхэдтэй өрх, усан хангамжийн эх үүсвэрээр



Мөн эдгээр хүүхдийн өрхийн ундны усны эх үүсвэрийг авч үзэхэд 33.2 хувь нь хамгаалагдсан худгаас, 24.5 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас, 13.9 хувь нь зөөврийн худгаас усаа авдаг гэсэн байна. Эндээс гол анхаарал татаж буй нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас ус авдаг өрхийн хувь нилээд өндөр байгаад анхаарах нь зүйтэй.

#### 4.5. 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, СУРГУУЛЬД СУРАЛЦААГҮЙ ШАЛТГААН

Судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдийг 2011-2012 онд сургууль, курст суралцаж буй эсэх мөн сургууль, курст хамрагдаж буй хүүхдүүдийн суралцаж байгаа анги, сургуулийг насны бүлэг, хот, хөдөөгөөр тооцсон дүнг гаргаж Хүснэгт 4.5, 4.5.а, б -д үзүүллээ.

Хүснэгт 4.5 5-17 насны хүүхдийн тоо, сургуульд суралцаж буй байдал, хүйс, насны бүлгээр

Насны бүлэг /хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль курст сураагүй байгаа хүүхдийн тоо	Сургуулийн өмнөх/цэцэрлэг	Дунд сургууль			Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөр	Техник мэргэжлийн анхан шатны сургууль	Тусгай мэргэжлийн дунд/бүрэн бус дээд сургууль	Дээд
				Бага анги /1-5/	Дунд анги /6-9/	Ахлах анги /10-12/				
<b>Нийт хүүхэд</b>	<b>589 076</b>	<b>69 152</b>	<b>59</b>	<b>239 368</b>	<b>178 979</b>	<b>89 759</b>	<b>387</b>	<b>4 839</b>	<b>1 519</b>	<b>5 014</b>
5 - 9	201 840	49 538	59	151 207	859	125	0	0	52	0
10 - 11	91 630	1 247	0	73 929	16 117	220	60	57	0	0
12 - 14	144 390	3 393	0	12 278	124 384	4 131	83	121	0	0
15 - 17	151 216	14 974	0	1 954	37 619	85 283	244	4 661	1 467	5 014
<b>Хөвгүүд</b>	<b>300 678</b>	<b>40 723</b>	<b>59</b>	<b>121 117</b>	<b>90 454</b>	<b>41 649</b>	<b>273</b>	<b>2 751</b>	<b>1 162</b>	<b>2 490</b>
5 - 9	102 276	26 609	59	74 935	563	58	0	0	52	0
10 - 11	48 058	911	0	38 944	8 090	113	0	0	0	0
12 - 14	74 823	2 612	0	6 241	63 817	2 023	83	47	0	0
15 - 17	75 521	10 591	0	997	17 984	39 455	190	2 704	1 110	2 490
<b>Охид</b>	<b>288 398</b>	<b>28 429</b>	<b>0</b>	<b>118 251</b>	<b>88 525</b>	<b>48 110</b>	<b>114</b>	<b>2 088</b>	<b>357</b>	<b>2 524</b>
5 - 9	99 564	22 929	0	76 272	296	67	0	0	0	0
10 - 11	43 572	336	0	34 985	8 027	107	60	57	0	0
12 - 14	69 567	781	0	6 037	60 567	2 108	0	74	0	0
15 - 17	75 695	4 383	0	957	19 635	45 828	54	1 957	357	2 524

Нийт 5-17 насны хүүхдийн дийлэнх буюу 86.2 хувь нь ерөнхий боловсролын сургуульд сурдаг, 0.9 хувь нь дээд сургууль, 0.8 хувь нь техник мэргэжлийн анхан шатны сургууль, 0.3 хувь нь тусгай мэргэжлийн дунд болон дээд сургуульд сурч байна.



Харин 5-17 насны нийт хүүхдийн 11.7 хувь буюу 69.1 мянга нь судалгааны хугацаа буюу 2011-2012 оны хооронд ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаагийн дийлэнх нь буюу 71.6 хувь нь 5-9 насны хүүхэд байгаа бөгөөд энэ нь сургуульд орох насны доод хязгаар 6 байгаатай холбоотой юм.

*Хүснэгт 4.5.а 5-17 насны хүүхдийн насны бүтэц, сургуульд суралцаж буй байдал, хүйс, насны бүлгээр, хувиар*

Насны бүлэг / хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль курст сураагүй байгаа хүүхэд	Сургуулийн өмнөх/цэцэрлэг	Дунд сургууль			Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөр	Техник мэргэжлийн анхан шатны сургууль	Техник мэргэжлийн дунд/бүрэн бус дээд сургууль	Дээд
				Бага анги /1-5/	Дунд анги /6-9/	Ахлах анги /10-12/				
<b>Нийт хүүхэд</b>	<b>100.0</b>	<b>11.7</b>	<b>0.1</b>	<b>40.5</b>	<b>30.4</b>	<b>15.2</b>	<b>0.1</b>	<b>0.8</b>	<b>0.3</b>	<b>0.9</b>
5 - 9	100.0	24.5	0.1	74.9	0.4	0.1	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	1.4	0.0	80.6	17.6	0.2	0.1	0.1	0.0	0.0
12 - 14	100.0	2.3	0.0	8.5	86.1	2.9	0.1	0.1	0.0	0.0
15 - 17	100.0	9.9	0.0	1.2	24.9	56.4	0.2	3.1	1.0	3.3
<b>Хөвгүүд</b>	<b>100.0</b>	<b>13.5</b>	<b>0.1</b>	<b>40.2</b>	<b>30.1</b>	<b>13.9</b>	<b>0.1</b>	<b>0.9</b>	<b>0.4</b>	<b>0.8</b>
5 - 9	100.0	26.0	0.1	73.1	0.6	0.1	0.0	0.0	0.1	0.0
10 - 11	100.0	1.9	0.0	81.1	16.8	0.2	0.0	0.0	0.0	0.0
12 - 14	100.0	3.5	0.0	8.3	85.3	2.7	0.1	0.1	0.0	0.0
15 - 17	100.0	14.0	0.0	1.3	23.8	52.2	0.3	3.6	1.5	3.3
<b>Охид</b>	<b>100.0</b>	<b>9.9</b>	<b>0.0</b>	<b>41.0</b>	<b>30.7</b>	<b>16.7</b>	<b>0.0</b>	<b>0.7</b>	<b>0.1</b>	<b>0.9</b>
5 - 9	100.0	23.0	0.0	76.6	0.3	0.1	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	0.8	0.0	80.4	18.4	0.2	0.1	0.1	0.0	0.0
12 - 14	100.0	1.1	0.0	8.7	87.1	3.0	0.0	0.1	0.0	0.0
15 - 17	100.0	5.8	0.0	1.3	25.9	60.5	0.1	2.6	0.5	3.3

Хүүхдийн сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр авч үзэхэд ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаа хүүхдүүд хот, суурин газрын хувьд нийт хүүхдийн 9.8 хувийг эзэлж байхад хөдөө, орон нутгийн хувьд 14.1 хувьтай байна. Мөн насны бүлгээр авч үзэхэд хотод 15-17 насныхны 5.0 хувь, хөдөөд 15.9 хувь нь ямар нэг сургууль курсэд суралцаагүй байна. Иймд хөдөөгийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин хангалтгүй хэвээр байгааг анхаарлаас гаргахгүй байх хэрэгтэй.

*Хүснэгт 4.5.б 5-17 насны хүүхдийн насны бүтэц, сургуульд суралцаж буй байдал, хот, хөдөөгөөр, хувиар*

Насны бүлэг / хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль курст сураагүй байгаа хүүхэд	Сургуулийн өмнөх/цэцэрлэг	Дунд сургууль			Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөр	Техник мэргэжлийн анхан шатны сургууль	Техник мэргэжлийн дунд/бүрэн бус дээд сургууль	Дээд
				Бага анги /1-5/	Дунд анги /6-9/	Ахлах анги /10-12/				
<b>Хот</b>	<b>100.0</b>	<b>9.8</b>	<b>0.0</b>	<b>41.5</b>	<b>29.3</b>	<b>16.6</b>	<b>0.0</b>	<b>1.1</b>	<b>0.4</b>	<b>1.3</b>
5 - 9	100.0	23.6	0.0	75.9	0.4	0.1	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	0.7	0.0	81.2	17.7	0.3	0.0	0.1	0.0	0.0
12 - 14	100.0	0.7	0.0	7.4	88.0	3.7	0.0	0.2	0.0	0.0
15 - 17	100.0	5.0	0.0	1.3	22.6	60.5	0.1	3.9	1.4	5.2
<b>Хөдөө</b>	<b>100.0</b>	<b>14.1</b>	<b>0.0</b>	<b>39.6</b>	<b>31.7</b>	<b>13.6</b>	<b>0.1</b>	<b>0.5</b>	<b>0.1</b>	<b>0.3</b>
5 - 9	100.0	25.7	0.1	73.7	0.5	0.0	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	2.2	0.0	80.0	17.5	0.2	0.1	0.0	0.0	0.0
12 - 14	100.0	4.1	0.0	9.7	84.1	2.0	0.1	0.0	0.0	0.0
15 - 17	100.0	15.9	0.0	1.3	27.6	51.4	0.3	2.0	0.5	1.0

Ямар нэгэн сургууль, курст суралцаагүй байгаа нийт 69.2 мянган хүүхдийн 8.9 хувь буюу 6.1 мянга нь сургуульд сураад төгссөн хүүхдүүд байгаа бөгөөд үлдсэн 63.0 мянган хүүхдийн сургууль, курст суралцаагүй шалтгааныг Хүснэгт 4.6-д харуулав.

Хүснэгт 4.6 5-17 насны хүүхдийн тоо, сургууль, курст суралцаагүй шалтгаан, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг, хүйс	Сургууль, курст сураагүй байгаа шалтгаан													
	Бүгд	Сурах нас хүрээгүй	Сургууль хол	Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй	Сургалтын төлбөр төлж чадаагүй	Сурлага муу, сурах сонирхолгүй	Өрхийн орлогод нэмэр болох	Шилжин суурьшсан	Дотуур байр хүрэлцээгүй	Гэрийн ажилд туслахаар	Мал маллахаар	Эцэг, эх сургуулиас гаргасан	Өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй	Бусад
<b>Нийт</b>	<b>62 992</b>	<b>44 821</b>	<b>1 786</b>	<b>1 300</b>	<b>101</b>	<b>2 389</b>	<b>373</b>	<b>104</b>	<b>48</b>	<b>1 096</b>	<b>2 959</b>	<b>1 220</b>	<b>5 655</b>	<b>1 140</b>
5 - 9	49 538	44 821	1 587	324	47	243	0	104	0	154	585	91	1 174	408
10 - 11	1 247	0	48	110	0	159	0	0	48	51	0	0	831	0
12 - 14	3 169	0	57	219	0	510	116	0	0	119	408	478	1 112	150
15 - 17	9 038	0	94	647	54	1 477	257	0	0	772	1 966	651	2 538	582
<b>Хөвгүүд</b>	<b>36 692</b>	<b>24 068</b>	<b>965</b>	<b>802</b>	<b>54</b>	<b>2 247</b>	<b>316</b>	<b>0</b>	<b>48</b>	<b>601</b>	<b>2 524</b>	<b>1 171</b>	<b>3 297</b>	<b>599</b>
5 - 9	26 609	24 068	766	197	0	243	0	0	0	106	401	91	664	73
10 - 11	911	0	48	110	0	159	0	0	48	51	0	0	495	0
12 - 14	2 443	0	57	112	0	510	116	0	0	47	408	478	565	150
15 - 17	6 729	0	94	383	54	1 335	200	0	0	397	1 715	602	1 573	376
<b>Охид</b>	<b>26 300</b>	<b>20 753</b>	<b>821</b>	<b>498</b>	<b>47</b>	<b>142</b>	<b>57</b>	<b>104</b>	<b>0</b>	<b>495</b>	<b>435</b>	<b>49</b>	<b>2 358</b>	<b>541</b>
5 - 9	22 929	20 753	821	127	47	0	0	104	0	48	184	0	510	335
10 - 11	336	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	336	0
12 - 14	726	0	0	107	0	0	0	0	0	72	0	0	547	0
15 - 17	2 309	0	0	264	0	142	57	0	0	375	251	49	965	206

Судалгааны дүнгээр сургуульд суралцаагүй байгаа нийт хүүхдийн 63.4 хувь буюу 39.9 мянга нь 5 настай хүүхдүүд байгаа тул сургуульд хамрагдах 6-17 насны хүүхдийн сургуульд хамрагдаагүй шалтгааныг Хүснэгт 4.7-д харууллаа. Хүснэгтээс харахад сургуульд суралцаагүй байгаа 6-17 насны 23.1 мянган хүүхдийн 19.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 11.3 хувь нь мал маллахаар, 10.1 хувь нь сурлага муу, сурах сонирхолгүй, 5.3 хувь нь хичээлийн хэрэглэл, хувцас авах зардлыг гаргаж чадаагүйгээс, 7.9 хувь нь эцэг, эх нь сургуулиас гаргасан, 4.8 хувь нь гэрийн ажилд туслахаар, 4.7 хувь нь өвчтэй, 3.7 хувь нь сургууль хол байршдаг гэсэн шалтгаанаар сургуулиас завсардсан хүүхдүүд байна. Сурах нас хүрээгүйгээс гэсэн шалтгаанаас бусад шалтгаанууд дотор хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаан хамгийн өндөр хувь эзэлж байгаа нь анхаарал их татаж байна.

Хүснэгт 4.7 6-17 насны хүүхдийн тоо, сургууль, курст суралцаагүй шалтгаан, насны бүлгээр

6-17 насны хүүхэд-бүгд	Сургуульд сураагүй байгаа шалтгаан													
	Сурах нас хүрээгүй	Сургууль хол	Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй	Сургалтын төлбөр төлж чадаагүй	Сурлага муу/сурах сонирхолгүй	Өрхийн орлогод нэмэр болох	Дотуур байр хүрэлцээгүй	Гэрийн ажилд туслахаар	Мал маллахаар	Эцэг, эх сургуулиас гаргасан	Өвчтэй	Хөгжлийн бэрхшээлтэй	Бусад	
Бүгд	23070	6929	847	1218	54	2332	373	48	1095	2617	1130	1087	4373	967
6-9	9616	6929	648	242		185			154	244		46	933	235
10 - 11	1247		48	110		159		48	51			150	681	
12 - 14	3170		57	218		510	116		119	408	478	197	915	152
15 - 17	9037		94	648	54	1478	257		771	1965	652	694	1844	580
Бүгдэд эзлэх хувь														
Бүгд	100,0	30,0	3,7	5,3	0,2	10,1	1,6	0,2	4,8	11,3	4,9	4,7	19,0	4,2
6-9	100,0	72,1	6,7	2,5	0,0	1,9	0,0	0,0	1,6	2,5	0,0	0,5	9,7	2,4
10 - 11	100,0	0,0	3,8	8,8	0,0	12,8	0,0	3,8	4,1	0,0	0,0	12,0	54,6	0,0
12 - 14	100,0	0,0	1,8	6,9	0,0	16,1	3,7	0,0	3,8	12,9	15,1	6,2	28,9	4,8
15 - 17	100,0	0,0	1,0	7,2	0,6	16,4	2,8	0,0	8,5	21,8	7,2	7,7	20,4	6,4

#### 4.6 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Хүүхдийн эдийн засгийн идэвхийг тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн байдлаар тооцож болох бөгөөд энэ бүлэгт 5-17 насны хүүхдийн идэвхийг тухайн үеийн эдийн засгийн идэвхээр тооцон гаргаж байна. Иймд нийт хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн (түүнчлэн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд ч байж болно), зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон (эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн), зөвхөн сургуульд суралцсан, юунд ч оролцоогүй буюу эдийн засгийн идэвхгүй (өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүүхдүүдийг оруулна) гэсэн бүлгүүдэд хувааж, сургуульд суралцсан болон сургуульд сураагүй байдлаар ангилан насны бүлэг, хүйсээр тооцон гаргалаа. Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдээс сүүлийн 7 хоногийн байдлаар 88.3 хувь буюу 519.9 мянга нь сургуульд сурсан байна.

*Хүснэгт 4.8 Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр*

	Сургуульд суралцаж буй				Сургуульд сураагүй				
	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Зөвхөн сурсан	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Аль алинийг нь хийгээгүй	Бүгд
Нийт	589 076	78 992	326 631	114 300	519 923	14 976	18 049	36 128	69 153
5 - 9	201 839	14 827	73 620	63 853	152 300	2 850	12 987	33 702	49 539
10 - 11	91 630	13 207	58 600	18 575	90 382	417	107	724	1 248
12 - 14	144 390	26 536	95 920	18 541	140 997	2 409	524	460	3 393
15 - 17	151 217	24 422	98 491	13 331	136 244	9 300	4 431	1 242	14 973
Эрэгтэй	300 677	39 264	161 618	59 072	259 954	11 606	9 582	19 535	40 723
5 - 9	102 275	7 646	35 986	32 034	75 666	2 002	6 629	17 978	26 609
10 - 11	48 058	6 358	30 435	10 353	47 146	309	107	496	912
12 - 14	74 823	13 973	48 541	9 697	72 211	2 013	378	221	2 612
15 - 17	75 521	11 287	46 656	6 988	64 931	7 282	2 468	840	10 590
Эмэгтэй	288 399	39 728	165 013	55 228	259 969	3 370	8 467	16 593	28 430
5 - 9	99 564	7 181	37 634	31 819	76 634	848	6 358	15 724	22 930
10 - 11	43 572	6 849	28 165	8 222	43 236	108	0	228	336
12 - 14	69 567	12 563	47 379	8 844	68 786	396	146	239	781
15 - 17	75 696	13 135	51 835	6 343	71 313	2 018	1 963	402	4 383

Сургуульд сурч байгаа хүүхдийн 15.2 хувь нь сурахын хажуугаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, 62.8 хувь нь эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон, 22.0 хувь нь зөвхөн сурч, эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлээгүй, гэрийн ажил хийхэд ч оролцоогүй байна.

Хүснэгт 4.8а. Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан болон сураагүй 5-17 насны хүүхэд, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар

	Сургуульд суралцаж буй				Сургуульд сураагүй				
	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Зөвхөн сурсан	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Аль алинийг нь хийгээгүй	Бүгд
Нийт	589 076	15.2	62.8	22.0	100.0	21.7	26.1	52.2	100.0
5 - 9	201 839	9.7	48.4	41.9	100.0	5.8	26.2	68.0	100.0
10 - 11	91 630	14.6	64.8	20.6	100.0	33.4	8.6	58.0	100.0
12 - 14	144 390	18.8	68.0	13.2	100.0	71.0	15.4	13.6	100.0
15 - 17	151 217	17.9	72.3	9.8	100.0	62.1	29.6	8.3	100.0
Эрэгтэй	300 677	15.1	62.2	22.7	100.0	28.5	23.5	48.0	100.0
5 - 9	102 275	10.1	47.6	42.3	100.0	7.5	24.9	67.6	100.0
10 - 11	48 058	13.5	64.5	22.0	100.0	33.9	11.7	54.4	100.0
12 - 14	74 823	19.4	67.2	13.4	100.0	77.1	14.5	8.4	100.0
15 - 17	75 521	17.4	71.8	10.8	100.0	68.8	23.3	7.9	100.0
Эмэгтэй	288 399	15.3	63.5	21.2	100.0	11.8	29.8	58.4	100.0
5 - 9	99 564	9.4	49.1	41.5	100.0	3.7	27.7	68.6	100.0
10 - 11	43 572	15.8	65.2	19.0	100.0	32.1	0.0	67.9	100.0
12 - 14	69 567	18.3	68.9	12.8	100.0	50.7	18.7	30.6	100.0
15 - 17	75 696	18.4	72.7	8.9	100.0	46.0	44.8	9.2	100.0

Нийт хүүхдийн 11.7 хувийг сургуульд сураагүй хүүхэд эзэлж байгаа бөгөөд эдгээр хүүхдийн тал нь буюу 52.2 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдоггүй, гэрийн ажил ч хийдэггүй хүүхэд байхад зөвхөн гэрийн ажилд оролцдог хүүхэд 26.1 хувьтай байна. Харин сургуульд сураагүй таван хүүхдийн нэг нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн байна. Хүснэгт 4.9-өөс харахад эдийн засгийн идэвхтэй хүүхэд хөдөө, орон нутагт зонхилж байгаа бөгөөд энэ нь манай орны онцлог болох мал аж ахуй эрхлэлттэй холбоотой юм. Өрхийн ам бүлийн хувьд ерөнхийдөө гурваас зургаан ам бүлтэй айлын хүүхдүүд дийлэнх нь байгаа бөгөөд мөн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн арван хүүхэд тутмын нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хүүхдүүд байна.

Хүснэгт 4.9 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхи, өрхийн тэргүүлэгч, өрхийн ам бүлийн тоо, хот, хөдөөгөөр

	Сургуульд суралцаж буй				Сургуульд сураагүй				
	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Зөвхөн сурсан	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Аль алинийг нь хийгээгүй	Бүгд
Бүгд	589 076	78 992	326 631	114 300	519 923	14 976	18 049	36 128	69 153
< 3	20 179	1 196	13 711	3 444	18 351	494	542	792	1 828
3 - 4	261 400	25 588	150 765	51 966	228 319	5 702	8 089	19 290	33 081
5 - 6	253 315	43 269	133 495	50 888	227 652	5 800	7 202	12 661	25 663
7 - 8	44 351	7 685	23 208	6 777	37 670	2 303	1 876	2 502	6 681
9 +	9 831	1 254	5 452	1 225	7 931	677	340	883	1 900
Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	491 813	72 535	264 911	95 649	433 095	13 003	14 711	31 004	58 718
Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	97 264	6 457	61 720	18 651	86 828	1 973	3 339	5 124	10 436
Хот	320 896	16 536	210 671	62 238	289 445	1 359	10 173	19 919	31 451
Хөдөө	268 179	62 456	115 960	52 062	230 478	13 617	7 876	16 208	37 701

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийг өрхийн ам бүлийн тоогоор нь авч үзэхэд нийт 1-2 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн 8.4 хувь нь, 3-4 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн 12.0 хувь нь, 5-6 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн 19.4 хувь нь, 7-8 ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн 22.5 хувь нь, 9 ба түүнээс дээш ам бүлтэй өрхөд амьдардаг хүүхдийн 19.6 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

#### 4.7 АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, БАЙРШИЛ, БҮСЭЭР


Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 15.9 хувь буюу 93968 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж байна. Эдгээр хүүхдийн 50870 буюу 54.1 хувь нь эрэгтэй, 43098 буюу 45.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 4.10 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Хөвгүүд	Охид	Бүгд	Хөвгүүд	Охид	Бүгд	Хөвгүүд	Охид
5-9	17 677	9 648	8 029	1 783	626	1 157	15 894	9 022	6 872
10 - 11	13 624	6 667	6 957	2 521	1 211	1 310	11 103	5 456	5 647
12 - 14	28 945	15 986	12 959	5 403	2 899	2 504	23 542	13 087	10 455
15 - 17	33 722	18 569	15 153	8 188	4 390	3 798	25 534	14 179	11 355
<b>Бүгд</b>	<b>93 968</b>	<b>50 870</b>	<b>43 098</b>	<b>17 895</b>	<b>9 126</b>	<b>8 769</b>	<b>76 073</b>	<b>41 744</b>	<b>34 329</b>

Судалгааны дүнгээр эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй нийт хүүхдийн 19.0 хувь буюу 17.9 мянга нь хот, суурин газарт, 81.0 хувь буюу 76.0 мянга нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Насны бүлгээр авч үзвэл 5-9 насны 17.7 мянга (18.8 хувь), 10-11 насны 13.6 мянга (14.5 хувь), 12-14 насны 28.9 мянга (30.8 хувь), 15-17 насны 33.7 мянган (35.9 хувь) хүүхэд байна.


Зураг 4.7 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн насны бүтэц, хувиар



Хүйсийн хувьд насны бүлгээр авч үзэхэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 10-11 насны охидын нийт дүнд эзлэх хувь нь хөвгүүдийнхээс 2.1 пунктээр илүү, харин бусад насны бүлгүүдэд хөвгүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.


Нийт ажил эрхэлсэн хүүхдийн 36.3 мянга (38.6 хувь) нь баруун бүсэд, 25.8 мянга (27.4 хувь) нь хангайн бүсэд, 18.3 мянга (19.5 хувь) нь төвийн бүсэд, 8.4 мянга (9.0 хувь) нь зүүн бүсэд, 5.1 мянга (5.5 хувь) нь Улаанбаатар хотод байна.

Зураг 4.8 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, бүсээр




5-17 насны ажил эрхэлж буй нийт хүүхдийн 1.3 хувь буюу 1.2 мянга нь хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй хүүхдүүд байгаа бөгөөд тэдний 67.0 хувь нь хөвгүүд, 33.0 хувь нь охид байна. Эдгээр хүүхдийн 63.4 хувь нь төрөлхийн, 36.6 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна.

Зураг 4.9 5-17 насны ажил эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр



Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 92.0 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилтын салбарт, 4.3 хувь нь боловсруулах үйлдвэрт, 3.6 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажил эрхэлж байна.

Зураг 4.10 5-17 насны ажил эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар



#### 4.8 АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Судалгааны тархаалтын тооцоогоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил эрхэлж байгаа хүүхдүүд улсын хэмжээний нийт өрхийн 8.6 хувьд нь амьдарч байна. Хүснэгт 4.11-ээс харахад ажил эрхэлж буй хүүхдийн 9.0 хувь буюу 8.4 мянга нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байна. Энэ байдал хангайн, зүүн болон төвийн бүсүүдэд ерөнхийдөө хадгалагдаж байна. Харин Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 17.4 хувь байхад баруун бүсэд хамгийн бага буюу 6.3 хувьтай байна.


Хүснэгт 4.11. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхийн ам бүлийн тоогоор, хувиар

Байршил, бүс, аймаг	Өрхийн тэргүүлэгчээр		Өрхийн ам бүлийн тоо					Бүгд
	Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	< 3	3 - 4	5 - 6	7 - 8	9 +	
Хот	84.1	15.9	0.9	37.7	49.0	11.2	1.2	100.0
Хөдөө	92.7	7.3	2.0	32.3	53.0	10.5	2.2	100.0
<b>Бүс</b>								
Баруун	93.7	6.3	1.1	22.3	54.1	18.3	4.2	100.0
Хангайн	90.3	9.7	2.4	35.6	58.8	3.2	0.0	100.0
Төв	89.7	10.3	3.3	43.3	44.9	7.3	1.2	100.0
Зүүн	89.9	10.1	0.6	45.6	47.0	6.8	0.0	100.0
Улаанбаатар	82.6	17.4	0.0	44.1	41.0	11.5	3.4	100.0
<b>Дүн</b>	<b>91.0</b>	<b>9.0</b>	<b>1.8</b>	<b>33.3</b>	<b>52.2</b>	<b>10.6</b>	<b>2.1</b>	<b>100.0</b>

Хот, хөдөөгийн хувьд 5-17 насны хүүхэд нь ажил эрхэлж буй өрх толгойлсон эмэгтэйчүүдийн харьцаа нилээд зөрөөтэй (8.6 пунктээр) байна. Хотод арван өрх тутмын найм нь эмэгтэй тэргүүлэгчтэй байхад хөдөөд арван өрхийн бараг нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна.

Ер нь 3-6 ам бүлтэй өрхөөс хүүхэд нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох буюу ажил эрхлэх байдал нь бусад өрхөөс илүү өндөр байгаа нь дараах зургаас харагдаж байна.

Зураг 4.11 Ажил эрхэлж буй хүүхэд, ам бүлийн тоо, хүйсээр, хот, хөдөөгөөр, хувиар




#### 4.9. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН ГЭР БҮЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ


Энэ хэсэгт ажил эрхэлж буй хүүхдийн нийгэм, эдийн засгийн байдлыг харуулахын тулд тэдгээр хүүхдийн амьдарч буй өрхийн орон байр, сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, өрхийн сарын дундаж орлого зэргийг тусгалаа.



Зураг 4.12 Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, сууцны төрлөөр, %




Зураг 4.13 Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, сууцны эзэмшлийн хэлбэрээр, %




Ажил эрхэлж буй 5-17 насны хүүхдүүдийн 70.5 хувь буюу 66.2 мянга нь гэрт, 24.4 хувь буюу 22.9 мянга нь сууцны тусдаа байшинд, 2.7 хувь буюу 2.5 мянга нь орон сууцны байшинд, 2.2 хувь буюу 2.1 мянга нь бие даасан тохилог сууцанд амьдарч байна.

Харин хүүхдийн амьдарч буй өрхийн сууцны эзэмшлийн хэлбэрээр авч үзвэл 98.3 хувь буюу 92.4 мянга нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг байна. 5-17 насны хүүхдийн амьдарч буй сууцны нөхцлийн үзүүлэлт болох цахилгаан болон усан хангамжийг дараах зургуудаар харууллаа. Нийт 5-17 насны хүүхдүүдийн 95.4 хувь нь гэртээ цахилгаан хангамжтай байна.

Зураг 4.14 Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, цахилгааны эх үүсвэрээр, хувиар




Зураг 4.15 Ажил эрхэлж буй хүүхэдтэй өрх, усан хангамжийн эх үүсвэрээр, хувиар



Харин ажил эрхэлж буй нийт хүүхдийг өрхийн сарын дундаж орлогынх нь хувьд авч үзвэл дийлэнх нь буюу арван хүүхэд тутмын дөрөв нь сард 200.1-400.0 мянган төгрөгийн орлоготой өрхөд амьдарч байна.


Зураг 4.16 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, өрхийн орлогын түвшингээр



Ажил эрхэлж буй нийт хүүхдийн 16.8 хувь нь 400.1-600.0 мянган төгрөгийн орлоготой өрхөд, 14.0 хувь нь 140.1-200.0 мянган төгрөгийн орлоготой өрхөд амьдарч байна. Харин арван хүүхдийн нэг нь 600.1-800.0 мянган төгрөгийн орлоготой өрхөд амьдарч байгаа бол 140.0 хүртлэх мянган төгрөгийн орлоготой өрхөд нийт хүүхдийн 7.8 хувь буюу 7.3 мянган хүүхэд амьдарч байна.

Ажил эрхэлж буй хүүхдийг өөрийг нь оруулаад тухайн өрхөд хэдэн хүн ажил эрхэлж байгааг дараах зургаар харуулж байна. Дөрөв ба түүнээс дээш хүн ажил эрхэлдэг өрхөд 5-17 насны ажил эрхэлж буй нийт хүүхдийн 66.8 хувь нь, 3 хүн нь ажил эрхэлдэг өрхөд 26.8 хувь нь, 2 хүн ажил эрхэлдэг өрхөд 5.7 хувь нь амьдарч байна.

Зураг 4.17 Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, өрхөд ажил эрхэлж буй хүний тоогоор, хувиар



Харин нийт хүүхдийн 0.7 хувь буюу 13-17 насны 628 хүүхэд ажил эрхэлж өрхийн орлогыг ганцаараа бүрдүүлж байна. Эдгээр хүүхдийг өрхийн ам бүлийн тоогоор нь авч үзвэл 45.1 хувь нь 3 хүртэлх ам бүлтэй, 34.5 хувь нь 3-4 ам бүлтэй, 20.4 хувь нь 5-6 ам бүлтэй өрхөд амьдардаг байна. Мөн өрхийн тэргүүлэгчээр нь авч үзэхэд өрхийн орлогыг ганцаараа бүрдүүлж байгаа арван хүүхдийн зургаа нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд, дөрөв нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байна.

#### 4.10. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ 6-17 НАСНЫ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй 5-17 насны нийт хүүхдийн 1.6 хувь буюу 1537 хүүхэд нь 5 настай байгаа бөгөөд ажил эрхэлж буй хүүхдийн боловсролын түвшинг сургуульд хамрагдах насны бүлгээр буюу 6-17 насны бүлгээр тооцож Хүснэгт 4.12 –т харуулав.

Эдгээр ажил эрхэлж буй хүүхдийг боловсролын түвшнээр нь авч үзэхэд нийт хүүхдийн 32.5 хувь буюу 30.0 мянга нь боловсролгүй хүүхэд байна.

Хүснэгт 4.12 6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, боловсролын түвшин, хүйсээр, хот, хөдөөгөөр, хувиар

	Бүгд			Байршил			
	Бүгд	Хөвгүүд	Охид	Хот		Хөдөө	
				Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид
Боловсролгүй	32.5	34.6	30.0	16.8	23.9	38.6	31.6
Бага	38.9	38.2	39.7	38.7	31.8	38.0	41.8
Суурь	26.5	26.0	27.2	41.3	36.0	22.5	24.9
Бүрэн дунд	1.9	1.2	2.7	2.5	7.2	0.9	1.6
Техникийн болон мэргэжлийн	0.2	0.1	0.4	0.7	1.1	0.0	0.1
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Эдгээр ажил эрхэлж буй хүүхдүүдийг боловсролын түвшин болон насны бүлгээр нь авч үзэхэд нийт боловсролгүй хүүхдүүдийн 76.8 хувь нь 6-11 насных байгаа нь бага ангийн хүүхдүүд байгаатай холбоотой юм. Харин нийт боловсролгүй хүүхдийн 12.8 хувь нь 12-14 настай, 10.4 хувь нь 15-17 настай хүүхдүүд байна.

Судалгааны дүнгээр 6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин 97.6 хувьтай байна.

## Хүснэгт 4.13 6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр

Насны бүлэг	Улсын дүн			Хот		Хөдөө	
	Бүгд	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид
6 - 9	93.5	91.0	96.3	89.6	95.4	91.1	96.5
10 - 11	99.3	98.5	100.0	100.0	100.0	98.1	100.0
12 - 14	97.9	96.2	100.0	97.9	100.0	95.8	100.0
15 - 17	98.6	98.0	99.4	98.7	100.0	97.8	99.2
Улсын дундаж	97.6	96.3	99.1	98.0	99.4	95.9	99.0

Ажил эрхэлж буй 6-17 насны нийт хүүхдүүдийг судалгааны хугацаанд буюу 2011-2012 онд сургууль, курст суралцаж буй эсэх мөн сургууль, курст хамрагдаж буй хүүхдийн суралцаж байгаа анги, сургууль зэргийг насны бүлэг, хот, хөдөөгөөр тооцсон дүнг гаргаж Хүснэгт 4.14, 4.14а-д үзүүлээ.

Нийт 6-17 насны ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх буюу 84.1 хувь нь ерөнхий боловсролын сургуульд сурдаг, 0.7 хувь нь техник мэргэжлийн анхан шатны сургуульд, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөр болон дээд сургуульд тус тус 3.0 хувь нь сурч байна.

## Хүснэгт 4.14 6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, насны бүлэг, хот, хөдөөгөөр

Насны бүлэг / хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль курст сураагүй байгаа хүүхдийн тоо	Дунд сургууль			Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөр	Техник мэргэжлийн анхан шатны сургууль	Дээд
			Бага анги /1-5/	Дунд анги /6-9/	Ахлах анги /10-12/			
<b>6-17 насны нийт хүүхэд</b>	<b>92 431</b>	<b>13 486</b>	<b>29 136</b>	<b>32 718</b>	<b>15 935</b>	<b>245</b>	<b>647</b>	<b>264</b>
6 - 9	16 139	1 360	14 729	50	0	0	0	0
10 - 11	13 624	416	10 787	2 361	0	60	0	0
12 - 14	28 946	2 409	3 203	22 848	439	47	0	0
15 - 17	33 722	9 301	417	7 459	15 496	138	647	264
<b>Хот</b>	<b>17 894</b>	<b>1 359</b>	<b>4 083</b>	<b>6 634</b>	<b>5 306</b>	<b>0</b>	<b>392</b>	<b>120</b>
6 - 9	1 783	118	1 665	0	0	0	0	0
10 - 11	2 521	0	1 829	692	0	0	0	0
12 - 14	5 403	126	477	4 715	85	0	0	0
15 - 17	8 187	1 115	112	1 227	5 221	0	392	120
<b>Хөдөө</b>	<b>74 537</b>	<b>12 127</b>	<b>25 053</b>	<b>26 084</b>	<b>10 629</b>	<b>245</b>	<b>255</b>	<b>144</b>
6 - 9	14 356	1 242	13 064	50	0	0	0	0
10 - 11	11 103	416	8 958	1 669	0	60	0	0
12 - 14	23 543	2 283	2 726	18 133	354	47	0	0
15 - 17	25 535	8 186	305	6 232	10 275	138	255	144

Харин нийт ажил эрхэлж буй 6-17 насны хүүхдийн 14.6 хувь буюу 13.5 мянга нь судалгааны хугацаа буюу 2011-2012 оны хооронд сургуульд сураагүй байгаагийн 27.6 хувь нь 15-17 насны хүүхэд байгаа бөгөөд Хүснэгт 4.15-д энэ насны хүүхдийн дийлэнх нь буюу 34.1 хувь нь мал маллахаар гэж хариулсан байна.

Хүснэгт 4.14а 6-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн сургуульд суралцаж буй байдал, хувиар

Насны бүлэг / хүйс	Нийт	Ямар нэгэн сургууль курст сураагүй байгаа хүүхдийн тоо	Дунд сургууль			Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөр	Техник мэргэжлийн анхан шатны сургууль	Дээд
			Бага анги /1-5/	Дунд анги /6-9/	Ахлах анги /10-12/			
<b>6-17 насны нийт хүүхэд</b>	<b>100.0</b>	<b>14.6</b>	<b>31.5</b>	<b>35.4</b>	<b>17.2</b>	<b>0.3</b>	<b>0.7</b>	<b>0.3</b>
6 - 9	100.0	8.4	91.3	0.3	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	3.1	79.2	17.3	0.0	0.4	0.0	0.0
12 - 14	100.0	8.3	11.1	78.9	1.5	0.2	0.0	0.0
15 - 17	100.0	27.6	1.2	22.1	46.0	0.4	1.9	0.8
<b>Хот</b>	<b>100.0</b>	<b>7.6</b>	<b>22.8</b>	<b>37.1</b>	<b>29.7</b>	<b>0.0</b>	<b>2.2</b>	<b>0.6</b>
6 - 9	100.0	6.6	93.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	0.0	72.6	27.4	0.0	0.0	0.0	0.0
12 - 14	100.0	2.3	8.8	87.3	1.6	0.0	0.0	0.0
15 - 17	100.0	13.6	1.4	15.0	63.8	0.0	4.8	1.4
<b>Хөдөө</b>	<b>100.0</b>	<b>16.3</b>	<b>33.6</b>	<b>35.0</b>	<b>14.3</b>	<b>0.3</b>	<b>0.3</b>	<b>0.2</b>
6 - 9	100.0	8.7	91.0	0.3	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	3.7	80.7	15.1	0.0	0.5	0.0	0.0
12 - 14	100.0	9.7	11.6	77.0	1.5	0.2	0.0	0.0
15 - 17	100.0	32.1	1.2	24.4	40.2	0.5	1.0	0.6


Хүүхдийн сургуульд хамрагдалтыг хот, хөдөөгөөр авч үзэхэд ямар нэгэн сургууль, курст сураагүй байгаа хүүхдүүд хот, суурин газрын хувьд нийт хүүхдийн 7.6 хувийг эзэлж байхад хөдөө, орон нутгийн хувьд 2 дахин их буюу 16.3 хувьтай байна. Мөн насны бүлгээр авч үзэхэд 15-17 насандаа хөдөөд амьдарч, ажил эрхлэн сургуульд сураагүй байгаа хүүхдийн нийт дүнд эзлэх хувь хот суурин газрынхаас 18.5 пунктээр илүү байна.

Хүснэгт 4.15 6-17 насны ажил эрхэлж буй сургууль, курст хамрагдаагүй хүүхэд, шалтгаанаар, хувиар

Насны бүлэг / хүйс	Бүгд	Сургууль, курст сураагүй байгаа шалтгаан											Бусад
		Сурах нас хүрээгүй	Сургууль хол	Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй	Сургалтын төлбөр төлж чадаагүй	Сурлага муу, сурах сонирхолгүй	Өрхийн орлогод нэмэр болох	Дотуур байр хүрэлцээгүй	Гэрийн ажилд туслах аар	Мал маллахаар	Эцэг, эх сургуулиас гаргасан	Өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй	
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>9.7</b>	<b>3.1</b>	<b>5.6</b>	<b>0.6</b>	<b>12.3</b>	<b>3.3</b>	<b>0.5</b>	<b>9.1</b>	<b>25.0</b>	<b>10.6</b>	<b>16.8</b>	<b>3.4</b>
6 - 9	100.0	69.0	7.1	3.3	0.0	4.6	0.0	0.0	7.4	8.6	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	0.0	11.5	0.0	0.0	38.2	0.0	11.5	0.0	0.0	0.0	38.8	0.0
12 - 14	100.0	0.0	2.6	7.5	0.0	17.5	5.2	0.0	5.3	16.5	16.7	21.9	6.8
15 - 17	100.0	0.0	1.7	5.8	1.0	10.2	3.5	0.0	11.6	34.1	11.5	17.4	3.2
<b>Хөвгүүд</b>	<b>100.0</b>	<b>8.6</b>	<b>3.9</b>	<b>4.3</b>	<b>0.7</b>	<b>15.5</b>	<b>4.1</b>	<b>0.6</b>	<b>5.8</b>	<b>26.8</b>	<b>12.8</b>	<b>13.2</b>	<b>3.7</b>
6 - 9	100.0	72.0	10.5	4.9	0.0	6.8	0.0	0.0	5.8	0.0	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	0.0	15.6	0.0	0.0	51.6	0.0	15.6	0.0	0.0	0.0	17.2	0.0
12 - 14	100.0	0.0	3.0	5.9	0.0	20.6	6.1	0.0	2.5	19.5	19.8	14.6	8.0
15 - 17	100.0	0.0	2.1	3.8	1.2	12.7	4.4	0.0	7.6	37.2	13.3	14.9	2.8
<b>Охид</b>	<b>100.0</b>	<b>13.8</b>	<b>0.0</b>	<b>10.4</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>21.5</b>	<b>18.2</b>	<b>2.4</b>	<b>31.2</b>	<b>2.5</b>
6 - 9	100.0	62.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	10.8	26.5	0.0	0.0	0.0
10 - 11	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	0.0
12 - 14	100.0	0.0	0.0	16.5	0.0	0.0	0.0	0.0	21.2	0.0	0.0	62.3	0.0
15 - 17	100.0	0.0	0.0	13.6	0.0	0.0	0.0	0.0	27.9	22.1	4.3	27.6	4.5

Нийт сургуульд сураагүй байгаа ажил эрхэлдэг 6-17 насны хүүхдийн 28.3 хувь буюу 3.8 мянга нь сургууль төгссөн хүүхдүүд байгаа бөгөөд бусад 9.7 мянган хүүхдийн сургууль, курст хамрагдаагүй шалтгааныг Хүснэгт 4.15-д харуулав. Тухайн насны ажил эрхэлж буй дөрвөн хүүхдийн нэг нь мал маллах шалтгаанаар сургуульд хамрагдаагүй байна. Сургуульд хамрагдаагүй ажил эрхэлж буй 6-17 насны арван хүүхдийн найм нь эрэгтэй, хоёр нь эмэгтэй хүүхэд байна.

Зураг 4.18 Ажил эрхэлж буй сургуульд хамрагдаагүй 6-17 насны хүүхдийн тоо, хүйс, сургуульд хамрагдаагүй шалтгаанаар



Ажил эрхэлж буй 6-17 насны хүүхдийн сургуульд хамрагдаагүй шалтгааныг хүйсээр нь авч үзэхэд зөвхөн хөвгүүд л сурлага муу, сурах сонирхолгүй, өрхийн орлогод нэмэр болох, сургууль хол, сургуулийн төлбөр төлж чадахгүй болон дотуур байр хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар сургуульд хамрагдаагүй байна. Мөн тэднийг мал маллахаар болон эцэг, эх нь сургуулиас гаргасан тохиолдол охидтой харьцуулахад харьцангуй их байна. Гэрийн ажилд туслахаар болон өвчтэй гэсэн шалтгаанаар сургуульд суралцаагүй хүүхдийн тоонд хүйсийн ялгаа бараг байхгүй байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүдийн тоо охидоос 2 дахин их байгаа нь Зураг 4.19-өөс харагдаж байна.

#### 4.11 АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ

Хүүхэд нийгэмд бие хүн болж төлөвшин хүмүүжих, өсч, хөгжихөд чөлөөт цаг ихээхэн чухал үүрэгтэй. Эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил хийж буй 5-17 насны хүүхэд өдөрт дунджаар хичнээн хэмжээний чөлөөт цаг өөртөө гаргаж байгаа талаар мэдээлэл цуглуулсан. Ажил эрхэлж буй бүх хүүхэд чөлөөт цаг гардаг гэж хариулсан бөгөөд ихэнх нь буюу 47.7 хувь буюу 47.8 мянга нь өдөрт 3-4 цаг гардаг гэсэн байна.

Хүснэгт 4.16 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн чөлөөт цаг, бүгдэд эзлэх хувиар

Насны бүлэг	Бүгд	Өдөрт өөртөө гаргаж буй чөлөөт цаг			
		1-2	3-4	5-6	7-8
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>19.0</b>	<b>47.7</b>	<b>24.3</b>	<b>9.0</b>
5 - 9	100.0	8.5	38.0	37.3	16.2
10 - 11	100.0	13.4	46.3	29.7	10.6
12 - 14	100.0	15.1	51.7	25.2	8.0
15 - 17	100.0	30.3	49.8	14.4	5.5
<b>Хөвгүүд</b>	<b>100.0</b>	<b>19.8</b>	<b>46.3</b>	<b>24.0</b>	<b>9.9</b>
5 - 9	100.0	9.0	41.6	32.1	17.3
10 - 11	100.0	14.9	43.6	30.3	11.2
12 - 14	100.0	15.5	49.2	25.5	9.8
15 - 17	100.0	30.7	47.3	16.2	5.8
<b>Охид</b>	<b>100.0</b>	<b>18.2</b>	<b>49.2</b>	<b>24.6</b>	<b>8.0</b>
5 - 9	100.0	7.7	33.7	43.6	15.0
10 - 11	100.0	12.1	48.9	29.1	9.9
12 - 14	100.0	14.7	54.6	24.8	5.9
15 - 17	100.0	29.8	52.9	12.1	5.2

Харин нийт хүүхдийн 24.3 хувь нь өдөрт 5-6 цаг, 19.0 хувь нь 1-2 цаг, 9.0 хувь нь 7-8 цагийг өдөрт чөлөөт цагтаа зарцуулдаг байна. Энэ үзүүлэлт хүйсийн хувьд ялгаатай бус, харин насны бүлгүүдээр ялгаатай харагдаж байна. Насны бүлэг дээшлэх тусам өдөрт гардаг чөлөөт цаг нь багасч байна. Ер нь бүх насныхны хувьд ихэвчлэн өдөрт 3-6 цагийг чөлөөт цагтаа зарцуулдаг байна.





**V**  
**БҮЛЭГ**

**АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН  
ТӨЛӨВ БАЙДАЛ**

### 5.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийн талаар дэлгэрэнгүй тооцсон дүнг энэ бүлэгт танилцуулж байна. Ажил эрхэлж буй хүүхэд гэдэг нь ажил болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамруулсан өргөн хүрээний ойлголт юм. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй, эсвэл өрхдөө ба бусдад хөлстэй болон хөлсгүй, байнгын болон түр зуурын ажил хийж буй, албан болон албан бус секторт ажиллаж буй хүүхдүүдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн гэж үзнэ. Мөн ажлын байртай ч гэсэн сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй хүүхэд ч гэсэн хамрагдах болно. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэдэг нь ажил эрхлэлтийг тооцох олон улсын жишиг ойлголт юм.

### 5.2 ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай орны эдийн засагт мал аж ахуй чухал үүрэг гүйцэтгэдэг учраас малчин өрхийн хүүхдүүд багаасаа мал аж ахуйн ажилд идэвхтэй оролцож эцэг, эхдээ тусалж байдаг нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо өндөр гарахад нөлөөлдөг юм. 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдлаар тодорхойлон дэд бүлгүүдэд, ангиллаар нарийвчлан гаргалаа.


Судалгааны дүнгээр 5-17 насны нийт хүүхдийн 15.9 хувь буюу 93968 хүүхэд тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж байна.

*Хүснэгт 5.1 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр*

Насны бүлэг/хүйс	Нийт хүүхэд	Ажил эрхэлж буй хүүхдийн тоо	Дүнд эзлэх хувь
<b>Нийт хүүхэд</b>	<b>589 076</b>	<b>93 968</b>	<b>15.9</b>
5-9	201 840	17 677	8.8
10-11	91 630	13 624	14.9
12-14	144 390	28 945	20.0
15-17	151 216	33 722	22.3
<b>Эрэгтэй</b>	<b>300 678</b>	<b>50 870</b>	<b>16.9</b>
5-9	102 275	9 648	9.4
10-11	48 057	6 667	13.9
12-14	74 821	15 986	21.4
15-17	75 525	18 569	24.6
<b>Эмэгтэй</b>	<b>288 398</b>	<b>43 098</b>	<b>14.9</b>
5-9	99 565	8 029	8.1
10-11	43 573	6 957	16.0
12-14	69 569	12 959	18.6
15-17	75 691	15 153	20.0

Хүснэгт 5.1 –ээс харахад 5-9 насны бүлэгт ажил эрхэлж буй хүүхдийн нийт дүнд эзлэх хувь 8.8, 10-11 насанд 14.9 хувь, 12-14 насанд 20.0 хувь, харин 15-17 насанд нэлээд өндөр 22.3 хувьтай байна.

*Зураг 5.1 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр*



2011-2012 оны ХХС-гаар гарсан дүнг 2006-2007 оны ХХС-тай харьцуулж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй хүүхдийн нийт дүнд эзлэх хувь өссөн байгаа бөгөөд энэ нь нэн ялангуяа 10-17 насны хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо буюу эдийн засгийн идэвх нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 5.2.1. Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, тухайн үеийн идэвхээр

Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоог ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цагаар тооцож үзэхэд тухайн үеийн байдлаар ажил хийж байгаа нийт 93968 хүүхдийн 19.3 хувь буюу 18113 нь ажлын байртай ч гэсэн сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй хүүхэд байна. Иймд энэ хэсэгт сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж буй 75855 хүүхдийн талаарх үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй тооцон оруулсан.

Хүснэгт 5.2-оос харахад сүүлийн 7 хоногт ажил хийсэн 75855 хүүхдийн 2.1 хувь буюу 1622 хүүхэд цалин хөлстэй ажил эрхэлсэн, дийлэнх хувийг эзэлж буй 74181 хүүхэд хувиараа хөдөлмөр эрхэлсэн болон мал аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцсон бол харин 52 хүүхэд цалин хөлстэй ажил хийхийн зэрэгцээ өрхийн бизнест ч гэсэн оролцсон байна. Нас болон хүйсийн бүтцээр харахад цалин хөлстэй ажил эрхэлсэн хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байна. Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх нь 15-17 насныхан байна.

*Хүснэгт 5.2 Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр*

Хүйс, насны бүлэг	Нийт хүүхэд	Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн	Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн тоо			Долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэндээ зарцуулсан цаг	
			Цалин хөлстэй ажил эрхэлсэн	ХХЭ, МААЭ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	Аль алинийг нь эрхэлсэн	Цалин хөлстэй ажил эрхэлсэн	ХХЭ, МААЭ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч
<b>Нийт хүүхэд</b>	<b>589076</b>	<b>75855</b>	<b>1622</b>	<b>74181</b>	<b>52</b>	<b>41.7</b>	<b>20.7</b>
<b>Эрэгтэй</b>	<b>300678</b>	<b>41906</b>	<b>1228</b>	<b>40626</b>	<b>52</b>	<b>42.9</b>	<b>23.8</b>
5-9	102275	7599	48	7,551	0	3.0	13.4
10-11	48057	5231	56	5,175	0	21.0	17.2
12-14	74821	13392	101	13,291	0	33.5	21.1
15-17	75525	15684	1,023	14,609	52	46.9	34.1
<b>Эмэгтэй</b>	<b>288398</b>	<b>33949</b>	<b>394</b>	<b>33555</b>	<b>0</b>	<b>37.8</b>	<b>21.4</b>
5-9	99565	5879	66	5,813	0	10.0	12.2
10-11	43573	5763	66	5,697	0	10.0	13.3
12-14	69569	10017	0	10,017	0	0.0	16.6
15-17	75691	12290	262	12028	0	51.9	21.4

ХХЭ: хувиараа хөдөлмөр эрхлэгч  
- МААЭ: мал аж ахуй эрхлэгч

Цалин хөлстэй ажил хийсэн 15-17 насны охид, хөвгүүд долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэндээ дунджаар 46.9-51.9 цагийг зарцуулж байгаа нь эдгээр хүүхдүүд Монгол Улсад мөрдөгдөж буй батлагдсан аргачлал<sup>1</sup>-ын дагуу хүүхдийн хөдөлмөр эрхэлж байна гэсэн үг юмаа.

<sup>1</sup> "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал", УСХ, НХХЯ, 2009 он

Хүснэгт 5.3 Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хот, хөдөөгөөр

Хүйс, насны бүлэг	Нийт хүүхэд	Сүүлийн 7 хоногт ажил хийсэн хүүхэд	Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн тоо			Долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэндээ зарцуулсан цаг		
			Цалин хөлстэй ажил эрхэлсэн	ХХЭ, МААЭ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	Аль алинийг нь эрхэлсэн	Цалин хөлстэй ажил эрхэлсэн	ХХЭ, МААЭ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	
<b>Нийт хүүхэд</b>	<b>589 076</b>	<b>75 855</b>	<b>1 622</b>	<b>74 181</b>	<b>52</b>	<b>41.7</b>	<b>20.7</b>	
<b>Хот</b>	<b>320 897</b>	<b>15 899</b>	<b>1 054</b>	<b>14 793</b>	<b>52</b>	<b>38.5</b>	<b>15.1</b>	
5-9	111 954	1 519	115	1 404	0	7.0	7.5	
10-11	51 111	2 228	66	2 162	0	10.0	11.5	
12-14	74 876	4 984	47	4 937	0	60.0	13.6	
15-17	82 956	7 168	826	6 290	52	43.9	19.3	
<b>Хөдөө</b>	<b>268 179</b>	<b>59 956</b>	<b>568</b>	<b>59 388</b>	<b>0</b>	<b>47.5</b>	<b>31.2</b>	
5-9	89 886	11 960	0	11 960	0	0	13.5	
10-11	40 519	8 767	56	8 711	0	21.0	16.1	
12-14	69 514	18 425	54	18 371	0	10.0	20.6	
15-17	68 260	20 804	458	20 346	0	55.2	31.2	

ХХЭ: хувиараа хөдөлмөр эрхлэгч  
 - МААЭ: мал аж ахуй эрхлэгч

Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн тоог насны бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажилдаа зарцуулсан дундаж цагаар тооцож хот, хөдөөгөөр Хүснэгт 5.3-т харуулав. Нийт ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх нь хөдөө орон нутагт (79.0 хувь) амьдарч байна. Харин цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхдийн ихэнх нь хот, суурин газарт байна. Хот, суурин газарт ажил эрхэлж буй хүүхдийн 6.6 хувийг цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд эзэлж байхад хөдөө орон нутагт энэ үзүүлэлт 0.9 хувьтай (59956 хүүхдийн 568 нь) байна. Мөн хөдөө орон нутагт ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцож буй хүүхдүүд байна.

**5.2.2. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар**

Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил эрхэлсэн хүүхдүүдийг насны бүлэг, хүйсээр ангилан эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар тооцож гаргасан.

Зураг 5.2 Ажил эрхэлсэн хүүхэд, эдийн засгийн үйд ажиллагааны салбарын ангиллаар, хувиар



Өөрөөр хэлбэл ажил эрхэлж буй арван хүүхдийн найм нь хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж байна гэсэн үг юм. Нийт хүүхдийн 11.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 3.0 хувь нь боловсруулах үйлдвэрт, 0.9 хувь нь зочид буудал, байр, сууцны болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 0.7 хувь нь барилгын салбарт ажиллаж байна.

Хүснэгт 5.4 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

	Нийт хүүхэд					Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	5-9	10-11	12-14	15-17	Бүгд	5-9	10-11	12-14	15-17	Бүгд	5-9	10-11	12-14	15-17
<b>Бүгд</b>	<b>93968</b>	<b>17677</b>	<b>13624</b>	<b>28945</b>	<b>33722</b>	<b>50870</b>	<b>9648</b>	<b>6667</b>	<b>15986</b>	<b>18569</b>	<b>43098</b>	<b>8029</b>	<b>6957</b>	<b>12959</b>	<b>15153</b>
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	76762	16523	11604	23570	25065	41280	9024	5537	13063	13656	35482	7499	6067	10507	11409
Уул уурхай, олборлолт	328	0	0	0	328	222	0	0	0	222	106	0	0	0	106
Боловсруулах үйлдвэрлэл	2845	53	345	740	1707	1510	0	103	360	1047	1335	53	242	380	660
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	54	0	0	0	54	54	0	0	0	54	0	0	0	0	0
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	218	0	42	176	0	218	0	42	176	0	0	0	0	0	0
Барилга	636	46	46	52	492	544	0	46	52	446	92	46	0	0	46
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	11084	870	1540	3917	4757	5962	537	892	2063	2470	5122	333	648	1854	2287
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	155	0	0	58	97	97	0	0	58	39	58	0	0	0	58
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	813	98	47	207	461	341	0	47	124	170	472	98	0	83	291
Мэдээлэл, холбоо	48	48	0	0	0	48	48	0	0	0	0	0	0	0	0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	133	0	0	0	133	133	0	0	0	133	0	0	0	0	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	149	0	0	44	105	52	0	0	0	52	97	0	0	44	53
Боловсрол	39	0	0	39	0	0	0	0	0	0	39	0	0	39	0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	138	0	0	52	86	42	0	0	0	42	96	0	0	52	44
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	155	0	0	0	155	55	0	0	0	55	100	0	0	0	100
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	411	39	0	90	282	312	39	0	90	183	99	0	0	0	99

Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй нийт хүүхдийн 21.5 хувь нь 5-9 настай, 15.1 хувь нь 10-11 настай, 30.7 хувь 12-14 настай, 32.7 хувь нь 15-17 настай хүүхдүүд байна. Ер нь бага насныхан хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, зочид буудал, байр, сууцны болон нийтийн хоолны үйлчилгээ, мэдээлэл холбоо, үйлчилгээний бусад үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 15-17 насныхан уул уурхай, олборлох үйлдвэр, цахилгаан, хий, уур, агааржуулалт, мэргэжлийн, шинжлэх ухааны болон техникийн үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагаа эрхэлсэн байна.


Хүснэгт 5.4.а 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Хүйс, насны бүлэг	Нийт хүүхэд					Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	5-9	10-11	12-14	15-17	Бүгд	5-9	10-11	12-14	15-17	Бүгд	5-9	10-11	12-14	15-17
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	18.8	14.5	30.8	35.9	<b>100.0</b>	19.0	13.1	31.4	36.5	<b>100.0</b>	18.6	16.1	30.1	35.2
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	<b>100.0</b>	21.5	15.1	30.7	32.7	<b>100.0</b>	21.9	13.4	31.6	33.1	<b>100.0</b>	21.1	17.1	29.6	32.2
Уул уурхай, олборлолт	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0
Боловсруулах үйлдвэрлэл	<b>100.0</b>	1.9	12.1	26.0	60.0	<b>100.0</b>	0.0	6.8	23.8	69.3	<b>100.0</b>	4.0	18.1	28.5	49.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>0.0</b>	0.0	0.0	0.0	0.0
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	<b>100.0</b>	0.0	19.3	80.7	0.0	<b>100.0</b>	0.0	19.3	80.7	0.0	<b>0.0</b>	0.0	0.0	0.0	0.0
Барилга	<b>100.0</b>	7.2	7.2	8.2	77.4	<b>100.0</b>	0.0	8.5	9.6	82.0	<b>100.0</b>	50.0	0.0	0.0	50.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	<b>100.0</b>	7.8	13.9	35.3	42.9	<b>100.0</b>	9.0	15.0	34.6	41.4	<b>100.0</b>	6.5	12.7	36.2	44.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	<b>100.0</b>	0.0	0.0	37.4	62.6	<b>100.0</b>	0.0	0.0	59.8	40.2	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	<b>100.0</b>	12.1	5.8	25.5	56.7	<b>100.0</b>	0.0	13.8	36.4	49.9	<b>100.0</b>	20.8	0.0	17.6	61.7
Мэдээлэл, холбоо	<b>100.0</b>	100.0	0.0	0.0	0.0	<b>100.0</b>	100.0	0.0	0.0	0.0	<b>0.0</b>	0.0	0.0	0.0	0.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>0.0</b>	0.0	0.0	0.0	0.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	<b>100.0</b>	0.0	0.0	29.5	70.5	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	45.4	54.6
Боловсрол	<b>100.0</b>	0.0	0.0	100.0	0.0	<b>0.0</b>	0.0	0.0	0.0	0.0	<b>100.0</b>	0.0	0.0	100.0	0.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	<b>100.0</b>	0.0	0.0	37.7	62.3	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	54.2	45.8
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	<b>100.0</b>	9.5	0.0	21.9	68.6	<b>100.0</b>	12.5	0.0	28.8	58.7	<b>100.0</b>	0.0	0.0	0.0	100.0

5.2.3. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

Ажил эрхэлж буй нийт хүүхдийн 65.9 хувь буюу 62.0 мянга нь мал аж ахуй эрхлэгч, 29.7 хувь буюу 28.0 мянга нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 2.5 хувь буюу 2.3 мянга нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.5 хувь буюу 1.4 мянга нь цалин хөлстэй ажиллагчид байна. Хүйсийн хувьд онцын их ялгаа ажиглагдсангүй.

Зураг 5.3 Ажил эрхэлсэн хүүхэд, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хувиар



#### 5.2.4. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар

Нийт ажил эрхэлсэн хүүхдийн 80.5 хувь буюу 75.6 мянга нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 12.3 хувь буюу 11.7 мянга нь худалдаа, үйлчилгээний төрлийн ажилтан, 3.6 хувь буюу 3.3 мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 2.9 хувь буюу 2.8 хувь нь энгийн ажил, мэргэжлээр, 0.1-0.3 хувь нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, мэргэжилтэн, техникч болон туслах гэсэн ажил мэргэжлийн ангилалд багтаж байна.


Хүснэгт 5.5 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар

Насны бүлэг /хүйс	Бүгд	Мэргэжил-тэн	Техникч болон туслах мэргэжилтэн	Худалдаа, үйлчилгээний ажилтан	ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил
<b>Нийт</b>	100.0	0.3	0.3	12.3	80.5	3.6	0.1	2.9
5-9	100.0	0.0	0.3	4.4	92.9	0.6	0.0	1.8
10-11	100.0	0.0	0.0	13.8	81.6	3.2	0.0	1.4
12-14	100.0	0.1	0.0	13.5	80.9	2.6	0.0	2.9
15-17	100.0	0.6	0.6	15.1	73.2	6.1	0.2	4.2
<b>Эрэгтэй</b>	100.0	0.3	0.5	11.1	80.4	3.3	0.1	4.3
5-9	100.0	0.0	0.5	5.0	93.1	0.0	0.0	1.4
10-11	100.0	0.0	0.0	14.9	80.5	2.3	0.0	2.3
12-14	100.0	0.0	0.0	12.1	81.1	2.1	0.0	4.7
15-17	100.0	0.9	1.1	12.0	73.2	6.4	0.3	6.1
<b>Эмэгтэй</b>	100.0	0.2	0.0	3.8	92.6	1.2	0.0	2.2
5-9	100.0	0.0	0.0	4.0	92.6	1.2	0.0	2.2
10-11	100.0	0.0	0.0	12.8	82.6	4.0	0.0	0.6
12-14	100.0	0.3	0.0	15.0	80.7	3.3	0.0	0.7
15-17	100.0	0.3	0.0	18.8	73.2	5.8	0.0	1.9

Хүйсээр харахад онцын ялгаа ажиглагдсангүй, харин насны бүлгээр авч үзвэл 5-9 насныхан ихэнхдээ хөдөө аж ахуйн холбогдолтой болон үйлчилгээний төрлийн ажил эрхэлжээ. Харин бусад төрлийн ажилд ахлах насны хүүхдүүд ихээр ажиллаж байна.



Зураг 5.4 Ажил эрхэлсэн хүүхэд, ажил мэргэжлийн ангилал, хот, хөдөөгөөр, хувиар



Ажил эрхэлж буй хөдөөгийн арван хүүхдийн ес нь хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж байгаа бол хот, суурин газрын ажил хийж буй бараг хоёр хүүхдийн нэг нь худалдаа, үйлчилгээний төрлийн ажлыг хийж байна.

### 5.2.5. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажилласан хугацаагаар


Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоог үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр Хүснэгт 5.6-д харуулав. Зарим хүүхэд харьцангуй бага наснаасаа эхлэн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож эхэлсэн байна. Тухайлбал, ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдийн 4.2 хувь нь арваас дээш жил ажиллажээ. Хүйсээр онцын ялгаа ажиглагдсангүй.

Хүснэгт 5.6 5-17 насны ажил эрхэлж буй хүүхэд, ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг/хүйс	Ажил эрхэлсэн хүүхдийн тоо	Ажилласан хугацаагаар						
		1 сараас бага	1-5 сар	6-11 сар	1-2 жил	3-4 жил	5-9 жил	10 ба түүнээс дээш жил
<b>Бүгд</b>	<b>93 968</b>	<b>10 306</b>	<b>25 949</b>	<b>6 695</b>	<b>25 368</b>	<b>15 467</b>	<b>8 518</b>	<b>1 665</b>
5-9	17 677	2 127	7 025	1 612	5 692	1 154	67	0
10-11	13 624	1 676	4 047	1 309	4 416	1 736	387	53
12-14	28 945	2 990	7 719	1 947	7 312	5 835	2 948	194
15-17	33 722	3 513	7 158	1 827	7 948	6 742	5 116	1 418
<b>Эрэгтэй</b>	<b>50 870</b>	<b>5 649</b>	<b>13 911</b>	<b>3 411</b>	<b>13 548</b>	<b>8 559</b>	<b>4 560</b>	<b>1 232</b>
5-9	9 648	1 124	3 669	1 073	3 072	710	0	0
10-11	6 667	1 079	2 171	443	1 942	934	98	0
12-14	15 986	1 645	4 446	977	4 246	2 776	1 748	148
15-17	18 569	1 801	3 625	918	4 288	4 139	2 714	1 084
<b>Эмэгтэй</b>	<b>43 098</b>	<b>4 657</b>	<b>12 038</b>	<b>3 284</b>	<b>11 820</b>	<b>6 908</b>	<b>3 958</b>	<b>433</b>
5-9	8 029	1 003	3 356	539	2 620	444	67	0
10-11	6 957	597	1 876	866	2 474	802	289	53
12-14	12 959	1 345	3 273	970	3 066	3 059	1 200	46
15-17	15 153	1 712	3 533	909	3 660	2 603	2 402	334

Ажил эрхэлж буй 5-17 насны арван хүүхдийн нэг нь 5 ба түүнээс дээш жил, хоёр нь 3-4 жил, гурав нь 1-2 жилийн хугацаатай ажиллаж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүд байна.

Зураг 5.5 Ажил эрхэлсэн хүүхэд, ажилласан хугацаагаар, хувиар



### 5.2.6. Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн сарын орлого

Ажил эрхэлж буй нийт хүүхдийн 2.0 хувь нь цалин хөлстэй ажил эрхэлсэн байна. Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн сарын орлогыг тооцон Хүснэгт 5.7-д үзүүлж байна.

Хүснэгт 5.7. 5-17 насны цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд, хүйс, олсон орлого, сургуульд хамрагдалтаар

Сүүлийн 7 хоногт олсон орлого, мян.төг (бэлэн мөнгө болон биет хэлбэрээр)	Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхэд					
	Тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Сургуульд сурдаг	Сургуульд сурдаггүй	Бүгд	Сургуульд сурдаг	Сургуульд сурдаггүй
<b>Нийт хүүхэд</b>	<b>1871</b>	<b>511</b>	<b>1360</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
50.0 хүртэл	373	217	156	19.9	42.5	11.5
50.0-79.0	113	0	113	6.0	0.0	8.3
80.0-109.0	446	148	298	23.8	29.0	21.9
140.0-169.0	394	48	346	21.1	9.4	25.4
170.0-199.0	166	0	166	8.9	0.0	12.2
200.0 ба түүнээс дээш	379	98	281	20.3	19.1	20.7
<b>Эрэгтэй</b>	<b>1582</b>	<b>378</b>	<b>1204</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
50.0 хүртэл	287	131	156	18.1	34.7	13.0
50.0-79.0	113	0	113	7.1	0.0	9.4
80.0-109.0	298	101	197	18.9	26.7	16.4
140.0-169.0	394	48	346	24.9	12.7	28.7
170.0-199.0	111	0	111	7.0	0.0	9.2
200.0 ба түүнээс дээш	379	98	281	24.0	25.9	23.3
<b>Эмэгтэй</b>	<b>289</b>	<b>133</b>	<b>156</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
50.0 хүртэл	86	86	0	29.8	64.7	0.0
50.0-79.0	0	0	0	0.0	0.0	0.0
80.0-109.0	148	47	101	51.2	35.3	64.7
140.0-169.0	0	0	0	0.0	0.0	0.0
170.0-199.0	55	0	55	19.0	0.0	35.3
200.0 ба түүнээс дээш	0	0	0	0.0	0.0	0.0

Цалин хөлстэй ажил эрхэлж буй арван хүүхдийн гурав нь сургуульд сурдаг, долоо нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна.

Сургуульд сурахын зэрэгцээ цалин хөлс, орлоготой ажил хийдэг бараг хоёр хүүхдийн нэг нь сард 50.0 мянга хүртэлх, харин сургуульд сурдаггүй дөрвөн хүүхдийн нэг нь 140.0-169.0 мянган төгрөгийн цалин хөлс, орлоготой ажилласан байна.

Хүйсийн хувьд онцын ялгаагүй бөгөөд гагцхүү сарын орлого нь өндөр буюу 200.0 мянгаас дээш төгрөгний орлоготой хүүхдүүд нь дандаа хөвгүүд байна.

### 5.3 . Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд

5-17 насны нийт хүүхдийн 70.9 хувь буюу 417.7 мянган хүүхэд эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон буюу гэрийн ажил хийсэн байна. Хүүхдүүдийн эдийн засгийн бус ажиллагааг насны бүлэг, хүйсээр тооцсон дүнг Хүснэгт 5.8, 5.8а –д харуулав.

Энэ удаагийн ХХС-ны гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагааны төрөлд манай орны онцлог шинж байдлыг харуулсан “Нүүх, ачаалах, гэр барих үйл ажиллагаа”-г шинээр нэмж оруулснаараа өмнөх судалгаануудаас ялгаатай бөгөөд судалгааны дүнгээр энэ үйл ажиллагаанд нийт хүүхдийн 1.4 хувь нь оролцсон гэсэн дүн гарчээ.

Ер нь ихэнх хүүхдүүд ямар нэгэн хэмжээгээр гэрийнхээ ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцож тусалж байна. Хүүхэд хэд хэдэн төрлийн гэрийн ажил хийсэн байж болохыг тэмдэглэх хэрэгтэй. Хүснэгт 5.8.а-гаас харахад хамгийн олон хүүхэд хоол цай бэлтгэх, аяга таваг цэвэрлэх (75.8 хувь), гэр, хашаа цэвэрлэх (68.0 хувь), ус авах (53.7 хувь), хувцас угаах, индүүдэх (46.6 хувь), түлээ, түлш бэлтгэх (37.9 хувь), гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр явах (28.0) ажлыг хийж байна. Гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоо насны бүлэг, хүйсээр нэлээд ялгаатай байна. Хоол унд бэлтгэх, аяга таваг цэвэрлэх, гэр, хашаа цэвэрлэх, хувцас угаах, индүүдэх ажлыг хийсэн охидын эзлэх хувь хөвгүүдийнхээс өндөр байна.

Хүснэгт 5.8 Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр

Насны бүлэг/ хүйс	Гэрийн ажил хийх буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа											Олон нийтийн болон сайн дурын ажилд цалин хөлсгүйгээр оролцох		
	Нийт оролцсон хүүхэд	Хоол цай бэлтгэх, аяга таваг цэвэрлэх	Гэр, хашаа цэвэрлэх	Хувиас угаах, индүүдэх	Сууц, эд хогшил сэргээн засварлах	Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах	Ус авах	Түлээ түлш бэлтгэх	Өндөр настан, өвчтөн асрах	Хүүхэд асрах		Ашиг олох зорилгоор бус мал, гэрийн тэжээвэр амьтан тэжээх	Нүүх, ачаалах, гэр барих үйл ажиллагаа
<b>Бүгд</b>	<b>417713</b>	<b>316687</b>	<b>284034</b>	<b>194816</b>	<b>20766</b>	<b>116802</b>	<b>15432</b>	<b>224443</b>	<b>158406</b>	<b>7862</b>	<b>57863</b>	<b>22685</b>	<b>5771</b>	<b>11307</b>
Үүнээс:	5-9	98308	55105	17477	1383	15940	1505	36275	27762	1051	17531	3580	863	1886
	10-11	69059	50156	46250	23720	17247	1235	36424	24718	1057	11054	3860	921	1477
	12-14	119737	93168	85957	61946	35788	4304	71983	49027	2234	14927	7119	1677	3636
	15-17	130609	105301	96722	91673	47827	8388	79761	56899	3520	14351	8126	2310	4308
<b>Эрэгтэй</b>	<b>210033</b>	<b>140347</b>	<b>121406</b>	<b>80700</b>	<b>15414</b>	<b>53945</b>	<b>4911</b>	<b>134752</b>	<b>95919</b>	<b>3347</b>	<b>25393</b>	<b>11942</b>	<b>3171</b>	<b>5410</b>
	5-9	48548	30620	23366	7078	8604	656	22708	16690	600	7282	1882	402	1118
	10-11	35930	22941	20694	10346	9188	570	22326	15184	449	5865	2181	387	490
	12-14	61724	41805	37351	25503	16454	1391	44226	31515	969	6402	3384	794	1835
	15-17	63831	44981	39995	37773	19699	2294	45492	32530	1329	5844	4495	1588	1967
<b>Эмэгтэй</b>	<b>207680</b>	<b>176340</b>	<b>162628</b>	<b>114116</b>	<b>5352</b>	<b>62857</b>	<b>10521</b>	<b>89691</b>	<b>62487</b>	<b>4515</b>	<b>32470</b>	<b>10743</b>	<b>2600</b>	<b>5897</b>
	5-9	49760	37442	31739	10399	7336	849	13567	11072	451	10249	1698	461	768
	10-11	33129	27215	25556	13374	8059	665	14098	9534	608	5189	1679	534	987
	12-14	58013	51363	48606	36443	19334	2913	27757	17512	1265	8525	3735	883	1801
	15-17	66778	60320	56727	53900	28128	6094	34269	24369	2191	8507	3631	722	2341

Хүснэгт 5.8.а Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хийсэн ажлын төрлөөр, хувиар

Насны бүлэг/ хүйс	Нийт оролцсон хүүхэд	Хоол цай бэлтгэх, аяга таваг цэвэрлэх	Гэр, хашаа цэвэрлэх	Хувцас угаах, индүүдэх	Сууц, эд хогшил сэргээн засварлах	Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	Хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах	Ус авах	Түлээ Түлш бэлтгэх	Өндөр настан, өвчтөн асрах	Хүүхэд асрах	Ашиг олох зорилгоор бус мал, гэрийн тэжээвэр амьтан тэжээх	Нүүх, ачаалах, гэр барих үйл ажиллагаа	Олон нийтийн болон сайн дурын ажилд цалин хөлсгүйгээр оролцох
<b>Бүгд</b>	<b>417713</b>	<b>75.8</b>	<b>68.0</b>	<b>46.6</b>	<b>5.0</b>	<b>28.0</b>	<b>3.7</b>	<b>53.7</b>	<b>37.9</b>	<b>1.9</b>	<b>13.9</b>	<b>5.4</b>	<b>1.4</b>	<b>2.7</b>
Үүнээс:														
5-9	98308	69.2	56.1	17.8	1.4	16.2	1.5	36.9	28.2	1.1	17.8	3.6	0.9	1.9
10-11	69059	72.6	67.0	34.3	3.1	25.0	1.8	52.7	35.8	1.5	16.0	5.6	1.3	2.1
12-14	119737	77.8	71.8	51.7	5.5	29.9	3.6	60.1	40.9	1.9	12.5	5.9	1.4	3.0
15-17	130609	80.6	74.1	70.2	8.1	36.6	6.4	61.1	43.6	2.7	11.0	6.2	1.8	3.3
<b>Эрэгтэй</b>	<b>210033</b>	<b>66.8</b>	<b>57.8</b>	<b>38.4</b>	<b>7.3</b>	<b>25.7</b>	<b>2.3</b>	<b>64.2</b>	<b>45.7</b>	<b>1.6</b>	<b>12.1</b>	<b>5.7</b>	<b>1.5</b>	<b>2.6</b>
5-9	48548	63.1	48.1	14.6	1.7	17.7	1.4	46.8	34.4	1.2	15.0	3.9	0.8	2.3
10-11	35930	63.8	57.6	28.8	4.3	25.6	1.6	62.1	42.3	1.2	16.3	6.1	1.1	1.4
12-14	61724	67.7	60.5	41.3	7.7	26.7	2.3	71.7	51.1	1.6	10.4	5.5	1.3	3.0
15-17	63831	70.5	62.7	59.2	12.9	30.9	3.6	71.3	51.0	2.1	9.2	7.0	2.5	3.1
<b>Эмэгтэй</b>	<b>207680</b>	<b>84.9</b>	<b>78.3</b>	<b>54.9</b>	<b>2.6</b>	<b>30.3</b>	<b>5.1</b>	<b>43.2</b>	<b>30.1</b>	<b>2.2</b>	<b>15.6</b>	<b>5.2</b>	<b>1.3</b>	<b>2.8</b>
5-9	49760	75.2	63.8	20.9	1.1	14.7	1.7	27.3	22.3	0.9	20.6	3.4	0.9	1.5
10-11	33129	82.1	77.1	40.4	1.7	24.3	2.0	42.6	28.8	1.8	15.7	5.1	1.6	3.0
12-14	58013	88.5	83.8	62.8	3.3	33.3	5.0	47.8	30.2	2.2	14.7	6.4	1.5	3.1
15-17	66778	90.3	84.9	80.7	3.5	42.1	9.1	51.3	36.5	3.3	12.7	5.4	1.1	3.5

Долоо хоногт хүүхдүүдийн гэрийн ажил хийхэд зарцуулж буй цагийг насны бүлэг, хүйсээр авч үзэхэд: 5-17 насны арван хүүхдийн зургаа нь 10 хүртэлх цагийг, гурав нь 10-24 цагийг, нэг нь 25-аас дээш цагийг тус тус гэрийн ажил хийхэд зарцуулсан байна. Энэ үзүүлэлт хүйсээр ялгаатай байгаа бөгөөд гэрийн ажил хийхэд оролцож буй охидын 10.8 хувь, хөвгүүдийн зөвхөн 5.6 хувь нь долоо хоногт 25-аас илүү цагийг зарцуулжээ. Хүснэгтээс харахад 5-9 насны хүүхдүүд гэрийн ажилд нэлээд тусалсан байна. Гэхдээ ийм хүүхдүүдийн 81.4 хувь нь долоо хоногт 9 хүрэхгүй цагийг гэрийн ажилд туслахад зарцуулж байна. Насны бүлэг дээшлэх тусам гэрийн ажилд туслах цаг нь нэмэгдэж байна. Үүнд: 10-11 насны арван хүүхдийн гурав нь, 12-14 насны арван хүүхдийн дөрөв нь долоо хоногт 10-42 цагийг гэрийн ажилд туслахад зарцуулж байна.

*Хүснэгт 5.9 Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, 7 хоногт зарцуулсан цагаар*

Долоо хоногт зарцуулсан цаг/ хүйс	Гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд		Насны бүлгээр							
			5-9		10-11		12-14		15-17	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь		
<b>Нийт хүүхэд</b>	<b>417 713</b>	<b>100.0</b>	<b>98 308</b>	<b>69 059</b>	<b>119 737</b>	<b>130 609</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
5 хүртэл	131 607	31.5	57 204	26 144	28 045	20 214	58.2	37.9	23.4	15.4
5-9	111 667	26.7	22 794	21 384	34 875	32 614	23.2	31.0	29.1	25.0
10-14	69 307	16.6	10 465	11 261	23 045	24 536	10.6	16.3	19.2	18.8
15-24	70 864	17.0	6 030	7 675	23 093	34 066	6.1	11.1	19.3	26.1
25-34	22 465	5.4	1 410	1 648	7 071	12 336	1.4	2.4	5.9	9.4
35-42	6 786	1.6	239	488	2 109	3 950	0.2	0.7	1.8	3.0
43-48	1 512	0.4	50	159	508	795	0.1	0.2	0.4	0.6
49-55	1 837	0.4	63	228	565	981	0.1	0.3	0.5	0.8
56+	1 668	0.4	53	72	426	1 117	0.1	0.1	0.4	0.9
<b>Эрэгтэй</b>	<b>210 033</b>	<b>100.0</b>	<b>48 548</b>	<b>35 930</b>	<b>61 724</b>	<b>63 831</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
5 хүртэл	76 106	36.2	29 656	15 099	18 158	13 193	61.1	42.0	29.3	20.8
5-9	60 454	28.8	11 223	10 905	19 351	18 975	23.1	30.4	31.3	29.7
10-14	32 439	15.4	4 509	5 450	10 720	11 760	9.3	15.2	17.4	18.4
15-24	29 403	14.0	2 281	3 399	9 923	13 800	4.7	9.5	16.1	21.6
25-34	8 510	4.1	766	734	2 704	4 306	1.6	2.0	4.4	6.7
35-42	1 732	0.8	0	0	589	1 143	0.0	0.0	1.0	1.8
43-48	516	0.2	50	115	126	225	0.1	0.3	0.2	0.4
49-55	739	0.4	63	228	100	348	0.1	0.6	0.2	0.5
56+	134	0.1	0	0	53	81	0.0	0.0	0.1	0.1
<b>Эмэгтэй</b>	<b>207 680</b>	<b>100.0</b>	<b>49 760</b>	<b>33 129</b>	<b>58 013</b>	<b>66 778</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
5 хүртэл	55 501	26.7	27 548	11 045	9 887	7 021	55.3	33.4	17.1	10.6
5-9	51 213	24.7	11 571	10 479	15 524	13 639	23.3	31.6	26.8	20.4
10-14	36 868	17.8	5 956	5 811	12 325	12 776	12.0	17.5	21.2	19.1
15-24	41 461	20.0	3 749	4 276	13 170	20 266	7.5	12.9	22.7	30.3
25-34	13 955	6.7	644	914	4 367	8 030	1.3	2.8	7.5	12.0
35-42	5 054	2.4	239	488	1 520	2 807	0.5	1.5	2.6	4.2
43-48	996	0.5	0	44	382	570	0.0	0.1	0.7	0.9
49-55	1 098	0.5	0	0	465	633	0.0	0.0	0.8	0.9
56+	1 534	0.7	53	72	373	1 036	0.1	0.2	0.6	1.6

Долоо хоногт 43-аас дээш цагийг гэрийн ажил хийхэд зарцуулсан охидын тоо (3628) хөвгүүдийнхээс (1389) нилээд их байна. 10-14, 15-17 насныхан гэрийн ажил хийхэд нилээд олон цаг зарцуулж буй нь хүснэгтээс харагдаж байна. Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хөвгүүд илүүтэй хийж байна. Гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр явахын хувьд охид, хөвгүүдийн аль аль нь оролцож байна. Сууц, эд хогшил сэргээн засах, хувцас, бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах зэрэг зарим ур чадвар шаардсан ажлыг ахлах насны хүүхдүүд хийж байна.







VI

БҮЛЭГ

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, ТҮҮНИЙГ ЭРХЛЭХ  
БОЛСОН ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

## 6.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Монгол орон хүүхэд залуучуудын орон, нийт хүн амын бараг тал хувь нь 24 наснаас доош насныхан байдаг бөгөөд төрөөс хүүхдийн сайн сайхны төлөө, тэдний эрхийг хангахын тулд олон чухал арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсээр байна. Гэвч хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдүүд гэмт хэргийн золиос болох, хайр халамж, орон байр, хоол хүнс, хувцас хэрэгслээр дутагдах, хүнд хүчир хөдөлмөр эрхэлж, амь нас, эрүүл мэнд, ёс суртахуунаараа хохирох, сургууль завсардах явдал гарсаар л байна. Иймд хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд хүргэж буй шалтгаан, хөдөлмөр эрхэлснээр хүүхдэд учирч буй хор уршиг эергийг судлах шаардлагатай байгаа юм.

Өмнөх бүлэгт танилцуулсан үндсэн үр дүнг ашиглан хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээг тооцсоноос гадна хүүхдүүд эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан, түүний үр дагаврын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн дүнг энэ бүлэгт танилцуулж байна. Түүнчлэн ажил хөдөлмөр эрхлэхээ боливол өөрт нь болон өрхөд нь үзүүлэх нөлөөний талаар хүүхдүүдээс тодруулсан.

## 6.2 ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТООЦОО

Хүүхдийн хөдөлмөр нь ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд гэсэн ойлголтоос илүү нарийвчилсан ойлголт юм. ОУХБ-ын 138, 182 дугаар конвенцийн зөвлөмжийг үндэслэн хүүхдийн хөдөлмөрийг тооцох аргачлалыг Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд батлуулан улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

“Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт”-д эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 5-11 насны, хөнгөн ажлыг 7 хоногт 14 цагаас дээш цагаар хийж байгаа 12-14 насны, 7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж байгаа 15-17 насны бүх хүүхдийг тус тус хамруулна /“Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын 2.14 дүгээр заалт, ҮСХ, НХХЯ, 2009 он/.

Энэ батлагдсан аргачлалын дагуу тооцсон Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (Хүснэгт 6.1) болон Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулинд заасан заалтыг үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр (Хүснэгт 6.2)-ийн талаарх хоёр тооцоог энэ хэсэгт танилцуулж байна. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн энэхүү тооцоонуудад ашиглаж буй сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажилд зарцуулсан цаг болон хүүхдийн насны бүлэг ялгаатай байгаа учраас гарч буй үр дүн нь өөр өөр байгааг анхааралдаа авна уу.

**Батлагдсан аргачлалын дагуу тооцсон хүүхдийн хөдөлмөр:** Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийг сүүлийн долоо хоногт ажилласан цаг, насны бүлгийг харгалзан батлагдсан аргачлалын дагуу тооцсон хүүхдийн хөдөлмөрийн тооцоог дараагийн хүснэгтээр үзүүлж байна.

Хүснэгт 6.1. Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлэг, хүйсээр /батлагдсан аргачлалын дагуу/

7 хоногт зарцуулсан цаг/хүйс	Бүгд	Насны бүлэг		
		5-11	12 - 14	15 - 17
<b>Ажил эрхэлсэн нийт хүүхэд</b>	<b>75 855</b>	<b>24 474</b>	<b>23 409</b>	<b>27 972</b>
5 хүртэлх цаг	5 047	2 641	1 507	899
5-9	15 183	6 873	4 641	3 669
10-14	19 213	8 058	6 469	4 686
15-24	13 753	3 699	4 844	5 210
25-34	7 105	1 509	2 123	3 473
35-42	7 046	1 108	2 291	3 647
43-48	836	204	162	470
49-55	1 406	133	362	911
56 ба түүнээс дээш	6 266	249	1 010	5 007
<b>Үүнээс: Хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>41 654</b>	<b>24 474</b>	<b>10 792</b>	<b>6 388</b>
<b>Эрэгтэй</b>	<b>41 905</b>	<b>12 830</b>	<b>13 392</b>	<b>15 683</b>
5 хүртэлх цаг	2 348	1,366	808	174
5-9	7 368	3,485	2,502	1,381
10-14	9 318	3,854	3,370	2,094
15-24	7 531	2,092	2,610	2,829
25-34	3 973	1,009	1,268	1,696
35-42	4 655	590	1,501	2,564
43-48	687	105	162	420
49-55	874	80	221	573
56 ба түүнээс дээш	5 151	249	950	3,952
<b>Үүнээс: Хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>24 487</b>	<b>12 830</b>	<b>6 712</b>	<b>4 945</b>
<b>Эмэгтэй</b>	<b>33 950</b>	<b>11 644</b>	<b>10 017</b>	<b>12 289</b>
5 хүртэлх цаг	2 699	1 275	699	725
5-9	7 815	3 388	2,139	2,288
10-14	9 895	4 204	3,099	2,592
15-24	6 222	1 607	2,234	2,381
25-34	3 132	500	855	1,777
35-42	2 391	518	790	1,083
43-48	149	99	0	50
49-55	532	53	141	338
56 ба түүнээс дээш	1 115		60	1,055
<b>Үүнээс: Хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>17 167</b>	<b>11 644</b>	<b>4 080</b>	<b>1 443</b>

Хүснэгтийн тодруулсан хэсгийг харахад сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 75855 хүүхдийн 54.9 хувь нь буюу 41654 хүүхэд хөдөлмөр эрхэлж байна. Харин эдгээр хүүхдүүд дээр бүлэг 8-д тооцож гаргасан хүнд хортой ажлын нөхцөл бүхий эдийн засгийн салбарт ажиллаж байгаа боловч хүнд хортой бус ажлын нөхцөл бүхий салбарт хүнд хортой ажил хийж байгаа хүүхдийн тоог нэмбэл 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэж буй нийт 93968 хүүхдийн 46,3 хувь буюу 43545 (41654+1891) хүүхэд хөдөлмөр эрхэлж байна гэсэн дүн гарч байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 74 хувь нь (589076 хүүхдийн 43545 нь) хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй нийт хүүхдийн 60,2 хувь буюу 26210 (24487+1723) нь эрэгтэй, 39.8 хувь нь буюу 17335 (17167+168) нь эмэгтэй хүүхдүүд байна.

**Хөдөлмөрийн хуулийн заалтын дагуу тооцсон хүүхдийн хөдөлмөр:** Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулинд<sup>1</sup>:

- 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- Долоо хоногийн ажлын цаг нь 15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны ажилтанд 36 цаг хүртэл байна.

гэж заасныг үндэслэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийг насны бүлэг болон цагаар тооцож гаргасан үр дүнг Хүснэгт 6.2-т харууллаа.

*Хүснэгт 6.2. Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлэг, хүйсээр /хөдөлмөрийн хуулийн заалтын дагуу/*

7 хоногт зарцуулсан цаг/ Хүйс	Бүгд	Насны бүлэг		
		5-14	15	16-17
<b>Ажил эрхэлсэн нийт хүүхэд</b>	<b>75 855</b>	<b>47 883</b>	<b>8 597</b>	<b>19 375</b>
29 хүртэлх цаг	58 015	41 345	5 929	10 741
30-35	4 577	2 372	621	1 584
36 ба түүнээс дээш	13 263	4 166	2 047	7 050
<b>Үүнээс: хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>57 601</b>	<b>47 883</b>	<b>2 668</b>	<b>7 050</b>
<b>Эрэгтэй</b>	<b>41 905</b>	<b>26 223</b>	<b>4757</b>	<b>10926</b>
29 хүртэлх цаг	29 276	21 664	2 737	4 875
30-35	2 673	1 631	281	761
36 ба түүнээс дээш	9 957	2 928	1 739	5 290
<b>Үүнээс: хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>33 533</b>	<b>26 223</b>	<b>2 020</b>	<b>5 290</b>
<b>Эмэгтэй</b>	<b>33 950</b>	<b>21 661</b>	<b>3 840</b>	<b>8 449</b>
29 хүртэлх цаг	28 739	19 681	3 192	5 866
30-35	1 904	741	340	823
36 ба түүнээс дээш	3 306	1 238	308	1 760
<b>Үүнээс: хөдөлмөр эрхэлсэн</b>	<b>24 068</b>	<b>21 660</b>	<b>648</b>	<b>1 760</b>

Хөдөлмөрийн хуулинд заасан насны бүлэг болон ажиллах цагийн хязгаарыг харгалзан тооцоход эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдүүдээс хөдөлмөр эрхэлсэн хүүхэд 57601 /Хүснэгт 6.2/ байна. Энэ нь сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүүхдийн 75.9 хувьтай тэнцэж байна. Эдгээр хүүхдийн 58.2 хувь нь эрэгтэй, 41.8 хувь нь эмэгтэй хүүхдүүд байгаа нь өмнөх аргачлалаар тооцсон хүйсийн харьцаатай ойролцоо байна. Хөдөлмөр эрхэлсэн нийт хүүхдийн 83.1 хувь нь 5-14 насныхан, 4.6 хувь нь 15 насныхан, 12.2 хувь нь 16-17 насныхан байна.

Хөдөлмөрийн хуулийн заалтаар тооцсон хүүхдийн хөдөлмөрийн тооцоонд 5-14 насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүүхдийг хамруулсны зэрэгцээ 15-17 насны хүүхдүүдээс сүүлийн долоо хоногт 30 цагаас дээш ажилласан хүүхдүүдийг оруулж тооцсон нь өмнөх батлагдсан аргачлалаар тооцсон хүүхдийн хөдөлмөрийн дүнгээс өндөр гарахад нөлөөлсөн байна.

<sup>1</sup> Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 71.1, 109.2 болон 109.3 дахь заалтууд

Иймд цаашдаа улсын хэмжээнд мөрдөгдөж буй хүүхдийн хөдөлмөрийг тооцдог аргачлалыг ОУХБ-ын Хөдөлмөрийн статистикчдын 18-р бага хурлаас батлагдсан “Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн тухай” тогтоол болон Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн заалтуудтай нийцүүлэн боловсронгуй болгож, мөрдүүлэх ажил хийх хэрэгтэй байна.

Хүүхдийн хөдөлмөрийн судалгаанд хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч буй болон нийтийн байранд суугаа хүүхдүүдийг хамруулаагүй тул хүүхдийн хөдөлмөрийн талаарх дээрх тоо мэдээ нь Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийг бүрэн хамраагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнээс гадна өрхөд суурилсан судалгаа нь голдуу далд хэлбэрээр явагддаг тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг хамрах боломжгүй байдаг.

### 6.3 СУРГУУЛИАС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сүүлийн 7 хоногт 5-17 насны нийт 589076 хүүхдийн 93968 хүүхэд буюу 16.0 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, 344680 хүүхэд буюу 58.5 хувь нь зөвхөн гэрийн ажил хийхэд оролцож, 114300 хүүхэд буюу 19.4 хувь нь зөвхөн суралцаж, 6.1 хувь нь өмнөх 3 үйл ажиллагааны алинд нь ч оролцоогүй юу ч хийгээгүй байна. Хүснэгт 6.3-т нийт хүүхдүүдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдлыг насны бүлэг, хүйсээр ялган харуулав.


5-17 насны нийт хүүхдүүдээс суралцсан болон ямар нэгэн үйл ажиллагаа хийгээгүй хүүхдийн хувьд хүйсийн ялгаа бараг байхгүй байна.

*Хүснэгт 6.3. 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр*

	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Зөвхөн сурсан	Аль алинийг нь хийгээгүй	
<b>Бүгд</b>	<b>589 076</b>	<b>93 968</b>	<b>344 680</b>	<b>114 300</b>	<b>36 128</b>	
5 - 9	201 839	17 677	86 607	63 853	33 702	
10 - 11	91 630	13 624	58 707	18 575	724	
12 - 14	144 390	28 945	96 444	18 541	460	
15 - 17	151 217	33 722	102 922	13 331	1 242	
<b>Бүгд</b>	<b>300 677</b>	<b>50 870</b>	<b>171 200</b>	<b>59 072</b>	<b>19 535</b>	
Хөвгүүд	5 - 9	102 275	9 648	42 615	32 034	17 978
	10 - 11	48 058	6 667	30 542	10 353	496
	12 - 14	74 823	15 986	48 919	9 697	221
	15 - 17	75 521	18 569	49 124	6 988	840
<b>Бүгд</b>	<b>288 399</b>	<b>43 098</b>	<b>173 480</b>	<b>55 228</b>	<b>16 593</b>	
Охид	5 - 9	99 564	8 029	43 992	31 819	15 724
	10 - 11	43 572	6 957	28 165	8 222	228
	12 - 14	69 567	12 959	47 525	8 844	239
	15 - 17	75 696	15 153	53 798	6 343	402
Бүгдэд эзлэх хувиар						
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>16.0</b>	<b>58.5</b>	<b>19.4</b>	<b>6.1</b>	
5 - 9	100.0	8.8	42.9	31.6	16.7	
10 - 11	100.0	14.9	64.0	20.3	0.8	
12 - 14	100.0	20.0	66.8	12.8	0.4	
15 - 17	100.0	22.3	68.1	8.8	0.8	
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>16.9</b>	<b>56.9</b>	<b>19.6</b>	<b>6.6</b>	
Хөвгүүд	5 - 9	100.0	9.4	41.7	31.3	17.6
	10 - 11	100.0	13.9	63.6	21.5	1.0
	12 - 14	100.0	21.4	65.5	13.0	0.3
	15 - 17	100.0	24.6	65.0	9.3	1.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>14.9</b>	<b>60.2</b>	<b>19.1</b>	<b>5.8</b>	
Охид	5 - 9	100.0	8.1	44.1	32.0	15.8
	10 - 11	100.0	16.0	64.6	18.9	0.5
	12 - 14	100.0	18.6	68.3	12.8	0.3
	15 - 17	100.0	20.0	71.1	8.4	0.5

Харин эдийн засгийн үйл ажиллагааг хөвгүүдийн 16.9 хувь нь эрхэлж байхад охидын 14.9 хувь нь, гэрийн ажлыг хөвгүүдийн 56.9 хувь нь хийж байхад охидын 60.2 хувь нь хийж байна. Эндээс үзэхэд орлого олох эдийн засгийн үйл ажиллагааг хөвгүүд охидыг бодвол илүүтэйгээр эрхэлж байна. Насны бүлгээр харахад нас ахих тусам зөвхөн суралцаж буй хүүхдүүдийн тоо буурч харин эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцох нь ихэсч байна.

Зураг 6.1. Хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, хот, хөдөө, хувиар



Хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдлыг байршлаар харахад хотын хүүхдүүдийн ихэнх нь буюу 68.8 хувь нь зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон байхад хөдөөний хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 22.6 пунктээр бага байна. Харин эдийн засгийн үйл ажиллагааг хөдөөний хүүхдүүдийн 28.4 хувь, хотын хүүхдүүдийн 5.6 хувь нь эрхэлсэн байна. Зөвхөн сурсан болон аль алинийг нь хийгээгүй хүүхдүүдийн нийт дүндээ эзлэх хувь хот, хөдөөд бараг адилхан байна.

Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 11.7 хувь буюу 69153 хүүхэд сургуульд хамрагдаагүй байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдлыг Хүснэгт 6.4-т харуулав. Сургуульд хамрагдаагүй нийт хүүхдийн 71.6 хувь буюу 49539 нь 5-9 настай, 6.7 хувь буюу 4641 нь 10-14 настай, 21.7 хувь буюу 14973 нь 15-17 настай хүүхдүүд байна. Сургуульд суралцах ёстой 7-17 насны 21270 хүүхэд байгаа бөгөөд энэ нь сургуульд сураагүй нийт хүүхдийн 30.8 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Сургуульд сураагүй бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хүүхдийн 19.0 хувийг 5-9 насны хүүхэд эзэлж байгаа нь 10-14 насны хүүхдүүдийн эзлэх хувьтай ойролцоо буюу 0.1 пунктээр илүү байна. Өмнөх буюу 2006-2007 оны хүүхдийн хөдөлмөрийн судалгааны үр дүнгээр сургуульд сураагүй бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-9 насны хүүхдийн тоо 10-14 насныхнаас 2 дахин их байсантай харьцуулахад сүүлийн жилүүдэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон бага насны хүүхдийн тоо буурсан нь нилээд эерэг нааштай үр дүн гэж үзэж болохоор байна.


Хүснэгт 6.4. Сургуульд сураагүй хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, насны бүлэг, хүйсээр

	Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Аль алинийг нь хийгээгүй
<b>Бүгд</b>	<b>69 153</b>	<b>14 975</b>	<b>18 051</b>	<b>36 127</b>
5 - 6	47 883	2 428	12 302	33 153
7 - 9	1 656	422	685	549
10 - 14	4 641	2 825	633	1 183
15 - 17	14 973	9 300	4 431	1 242

	<b>Бүгд</b>	<b>40 724</b>	<b>11 606</b>	<b>9 583</b>	<b>19 535</b>
Хөвгүүд	5 - 6	25 690	1 746	6 235	17 709
	7 - 9	920	256	394	270
	10 - 14	3 524	2 322	486	716
	15 - 17	10 590	7 282	2 468	840
	<b>Бүгд</b>	<b>28 429</b>	<b>3 369</b>	<b>8 468</b>	<b>16 592</b>
Охид	5 - 6	22 193	682	6 067	15 444
	7 - 9	736	166	291	279
	10 - 14	1 117	503	147	467
	15 - 17	4 383	2 018	1 963	402
Дүнд эзлэх хувиар					
	<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
	5 - 6	69.2	16.2	68.2	91.8
	7 - 9	2.4	2.8	3.8	1.5
	10 - 14	6.7	18.9	3.5	3.3
	15 - 17	21.7	62.1	24.5	3.4
	<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Хөвгүүд	5 - 6	63.0	15.0	65.0	90.6
	7 - 9	2.3	2.2	4.1	1.4
	10 - 14	8.7	20.0	5.1	3.7
	15 - 17	26.0	62.8	25.8	4.3
	<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Охид	5 - 6	78.1	20.3	71.6	93.1
	7 - 9	2.6	4.9	3.4	1.7
	10 - 14	3.9	14.9	1.7	2.8
	15 - 17	15.4	59.9	23.3	2.4

Хүснэгт 6.4-өөс харахад гэрийн ажилд тусалж буй хүүхдийн дийлэнх нь (72.0 хувь) 5-9 насныхан байна. Хүйсээр ялган харвал сургуульд сураагүй бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт хүүхдийн 77.5 хувь нь хөвгүүд, 22.5 хувь нь охид байна.

Зураг 6.2. Сургуульд сураагүй хүүхдүүдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдал, хот, хөдөө, хувиар





Мөн байршлаар харьцуулан үзэхэд сургуульд сураагүй хүүхдийн эдийн засгийн идэвхийн харьцаа хот, хөдөөд ойролцоо байгаа боловч сургуульд сураагүй бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн 90.9 хувь нь хөдөө, орон нутгийн хүүхдүүд байна. Эндээс харахад хөдөөний хүүхдүүд эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхлэхийн тулд сургуульд сураагүй байх магадлал өндөр байна.

#### 6.4 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Судалгааны дүнгээр 5-17 насны нийт хүүхдийн 15.1 хувь буюу 89142 нь өрхийн бизнес, мал аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаанд оролцжээ. Үүний 47805 буюу 53.6 хувь нь хөвгүүд, 41337 нь буюу 46.4 хувь нь охид байна.

Хүснэгт 6.5-д өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг насны бүлэг, хот хөдөө, хүйсээр харуулав.

Өрхийн бизнес, үйлдвэрлэл үйлчилгээ, мал аж ахуйн ажилд тусалж буй хүүхдүүдийн 85.4 хувь нь сургуульд сурч байна. Энэ үзүүлэлтийг хот, хөдөөгөөр авч үзэхэд хотын хүүхдүүдийн 94.8 хувь нь, хөдөөгийн хүүхдүүдийн 83.3 хувь нь өрхийн аж ахуйд туслахын зэрэгцээ сургуульд суралцаж байна. Өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдүүдийн 18.9 хувь нь 5-9 насны, 46.1 хувь нь 10-14 насны, 35.0 хувь нь 15-17 насны хүүхдүүд байна. Хотын хүүхдүүдийн хувьд ихэвчлэн 15-17 насны хүүхдүүд өрхийн аж ахуйд тусалж байхад хөдөөгийн хүүхдийн хувьд 10-14 насныхан байна. Эндээс үзэхэд 5-17 насны хүүхдүүдийн өрхийн аж ахуйд оролцох оролцоо хөдөөд хотынхныг бодвол 4 дахин их байгаа нь харагдаж байна.


Хүснэгт 6.5. Өрхийн аж ахуйд тусалж буй хүүхэд, насны бүлэг, сургуульд хамрагдалт, хот, хөдөө, хүйсээр

		Бүгд	Сургуульд сурч буй эсэх, %		
			Бүгд	Тийм	Үгүй
<b>Бүгд</b>		<b>89 142</b>	<b>100.0</b>	<b>85.4</b>	<b>14.6</b>
5 - 9		16 837	100.0	85.7	14.3
10 - 11		13 198	100.0	96.8	3.2
12 - 14		27 891	100.0	92.1	7.9
15 - 17		31 216	100.0	74.5	25.5
<b>Бүгд</b>		<b>16 379</b>	<b>100.0</b>	<b>94.8</b>	<b>5.2</b>
Хот	5 - 9	1 669	100.0	93.0	7.0
	10 - 11	2 348	100.0	100.0	0.0
	12 - 14	5 148	100.0	97.6	2.4
	15 - 17	7 214	100.0	91.6	8.4
	<b>Бүгд</b>	<b>72 763</b>	<b>100.0</b>	<b>83.3</b>	<b>16.7</b>
Хөдөө	5 - 9	15 168	100.0	84.9	15.1
	10 - 11	10 850	100.0	96.2	3.8
	12 - 14	22 743	100.0	90.8	9.2
	15 - 17	24 002	100.0	69.3	30.7
Хүйс	Хөвгүүд	47 805	100.0	78.8	21.2
	Охид	41 337	100.0	93.0	7.0

Өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг насны бүлгээр Зураг 6.3-т харууллаа. Судалгааны дүнгээр 5-17 насны нийт 1857 хүүхэд өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж байгаагийн 83.7 хувь нь хөвгүүд, 16.3 хувь нь охид байна.



Зураг 6.3. Өрхийн аж ахуйдаа тусалж буй хүүхдийн сургуульд хамрагдалт, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар




Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг сургуульд суралцаж буй эсэх болон насны бүлэг, хот, хөдөөгөөр Хүснэгт 6.6-д үзүүлэв.

Хүснэгт 6.6. Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхэд, сургуульд суралцаж буй эсэх, насны бүлэг, хот, хөдөөгөөр

Насны бүлэг/ Байршил	Бүгд	Сургуульд суралцаж буй эсэх				
		Тоогоор		Хувиар		
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	
<b>Бүгд</b>	<b>1 857</b>	<b>1 215</b>	<b>642</b>	65.4	34.6	
5 - 9	48	48		100.0	0.0	
10 - 11	56	56		100.0	0.0	
12 - 14	220	159	61	72.3	27.7	
15 - 17	1 533	952	581	62.1	37.9	
Хот	Бүгд	<b>1 058</b>	<b>709</b>	<b>349</b>	67.0	33.0
	5-9	48	48		100.0	0.0
	12-14	100	39	61	39.0	61.0
	15 - 17	910	622	288	68.4	31.6
Хөдөө	Бүгд	<b>799</b>	<b>506</b>	<b>293</b>	63.3	36.7
	10-11	56	56		100.0	0.0
	12-14	120	120		100.0	0.0
	15 - 17	623	330	293	53.0	47.0

Эдгээр хүүхдүүдийн 2.6 хувь нь 5-9 насныхан, 3.0 хувь нь 10-11 насныхан, 11.8 хувь нь 12-14 насныхан, 82.6 хувь нь 15-17 насныхан байна. Байршлаар авч үзвэл хотын болон хөдөөний хүүхдүүдийн хувьд өрхөөс гадуур ажилласан хүүхдүүдийн дийлэнх нь 15-17 насныхан байна. Харин хөдөөд 5-9 насандаа өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхэд байхгүй бөгөөд өрхөөс гадуур ажилласан 48 хүүхэд бүгд хотын хүүхдүүд байна.

Зураг 6.4. Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхдийн тоо, сургуульд суралцаж буй эсэхээр, хот, хөдөө, хүйсээр



Дээр өгүүлсэнчлэн 10 хүрэхгүй насандаа өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж хариулсан хүүхдүүд нийт хүүхдүүдийн 2.6 хувийг (1857 хүүхдийн 48 нь) эзэлж байна. Энэ нь өмнөх буюу 2006-2007 оны ХХС-ны үр дүнтэй харьцуулахад 15.9 пунктээр буурсан маш сайн үр дүн юм.

Өрхөөс гадуур ажиллахын зэрэгцээ сургуульд суралцаж буй хотын хүүхэд хөдөөний хүүхдээс 3.7 пунктээр их байна.

Өрхөөс гадуур ажил хийж байгаа ч гэсэн охид хөвгүүдийг бодвол бүгд сургуульд суралцаж байна. Өрхөөс гадуур ажил хийж буй арван эрэгтэй хүүхдийн зургаа нь сурахын хажуугаар ажил хийж байна.

## 6.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ БОЛСОН ШАЛТГААН

### 6.5.1 Өрхийн бизнес, мал аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд туслах болсон шалтгаан

Энэ хэсэгт хүүхдүүдийн өрхийн бизнес, мал аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд туслах болсон шалтгааны талаар танилцуулах болно.

Судалгааны дүнгээс харахад 5-17 насны нийт хүүхдийн 15.1 хувь нь өрхийн бизнес, мал аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд тусалж байгаа бөгөөд туслах болсон шалтгааныг Хүснэгт 6.7-д насны бүлэг, хүйсээр харуулав. Эдгээр хүүхдийн дийлэнх нь буюу арван хүүхдийн ес нь эцэг, эхдээ туслах зорилгоор өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуйн ажилд оролцжээ.

Харин дараа нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах хүч дутагдсан (8.3 хувь), ажлын дадлага, туршлагатай болох (3.4 хувь), бусад (0.6 хувь) шалтгаанууд орж байна.


Эцэг эхийн шахалтаар өрхийн аж ахуйн ажилд оролцдог хүүхэд нийт хүүхдийн 0.5 хувийг эзэлж байгаа бөгөөд эцэг, эхийн шахалтаар өрхийн аж ахуйн ажилд оролцож буй арван хүүхдийн ес нь хотын хүүхдүүд байна.

Хүснэгт 6.7. Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд тусалж байгаа хүүхдүүдийн туслах болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр

		Бүгд	Ажлын дадлага, туршлагатай болох	Эцэг эхдээ туслах	Өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан	Эцэг, эхийн шахалтаар	Бусад
<b>Бүгд</b>		<b>89 142</b>	<b>3 014</b>	<b>77 694</b>	<b>7 431</b>	<b>454</b>	<b>549</b>
5 - 9		16 837	507	15 188	784	232	126
10 - 11		13 198	352	12 405	383	58	
12 - 14		27 891	1 077	24 668	1 945	115	86
15 - 17		31 216	1 078	25 433	4 319	49	337
	<b>Бүгд</b>	<b>47 805</b>	<b>2 071</b>	<b>40 568</b>	<b>4 324</b>	<b>395</b>	<b>447</b>
Хөвгүүд	5 - 9	9 114	396	8 113	369	173	63
	10 - 11	6 564	272	6 234		58	
	12 - 14	15 352	677	13 326	1 187	115	47
	15 - 17	16 775	726	12 895	2 768	49	337
	<b>Бүгд</b>	<b>41 337</b>	<b>943</b>	<b>37 126</b>	<b>3 107</b>	<b>59</b>	<b>102</b>
Охид	5 - 9	7 723	111	7 075	415	59	63
	10 - 11	6 634	80	6 171	383		
	12 - 14	12 539	400	11 342	758		39
	15 - 17	14 441	352	12 538	1 551		
Бүгдэд эзлэх хувиар							
<b>Бүгд</b>		<b>100.0</b>	<b>3.4</b>	<b>87.2</b>	<b>8.3</b>	<b>0.5</b>	<b>0.6</b>
5 - 9		100.0	3.0	90.2	4.7	1.4	0.7
10 - 11		100.0	2.7	94.0	2.9	0.4	0.0
12 - 14		100.0	3.9	88.4	7.0	0.4	0.3
15 - 17		100.0	3.5	81.5	13.8	0.2	1.1
	<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>4.3</b>	<b>84.9</b>	<b>9.0</b>	<b>0.8</b>	<b>0.9</b>
Хөвгүүд	5 - 9	100.0	4.3	89.0	4.0	1.9	0.7
	10 - 11	100.0	4.1	95.0	0.0	0.9	0.0
	12 - 14	100.0	4.4	86.8	7.7	0.7	0.3
	15 - 17	100.0	4.3	76.9	16.5	0.3	2.0
	<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>2.3</b>	<b>89.8</b>	<b>7.5</b>	<b>0.1</b>	<b>0.2</b>
Охид	5 - 9	100.0	1.4	91.6	5.4	0.8	0.8
	10 - 11	100.0	1.2	93.0	5.8	0.0	0.0
	12 - 14	100.0	3.2	90.5	6.0	0.0	0.3
	15 - 17	100.0	2.4	86.8	10.7	0.0	0.0


Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд тусалдаг гэж хариулсан хот, хөдөөгийн болон хөвгүүд, охидын тоо ойролцоо байна.

Зураг 6.5. Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд тусалж байгаа хүүхдүүдийн туслах болсон шалтгааны бүтэц, хувиар



Сургуульд суралцаж буй хүүхэд ажлын дадлага, туршлагатай болох болон эцэг, эхдээ туслахаар өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуйн ажилд нь тусалж байна.

Зураг 6.6. Өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуйдаа тусалж байгаа хүүхдийн ажилд туслах болсон шалтгаан, хувиар




Дийлэнх хүүхэд эцэг эхдээ туслахын тулд гэж хариулсан ба энэ хариултыг нийт дүнд эзлэх хувиар нь авч үзэхэд сургуульд суралцаж буй хүүхдийн хувьд 89.0 хувьтай, сургуульд сураагүй хүүхдийн хувьд 76.1 хувьтай байна. Дараа нь өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан гэсэн шалтгааныг сургуульд суралцаж буй хүүхдүүдийн 6.7 хувь, сургуульд сураагүй хүүхдүүдийн 17.9 хувь нь тус тус дурьджээ.

Сургуульд сураагүй байгаа хүүхдийн хувьд өрхийн аж ахуйд ажиллах хүч дутагдсан болон эцэг, эхийн шахалтаар өрхийн бизнес, мал аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд туслах болсон гэсэн шалтгаан сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийг бодвол харьцангуй өндөр хувьтай байна. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд тусладаг ч сургуульд сураагүй байгаа хүүхдийн дийлэнх нь буюу 93.5 хувь нь хөдөө, орон нутагт байна.

### 6.5.2 Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгаан

Өрхөөс гадуур ажиллаж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааныг насны бүлэг, хүйсээр Хүснэгт 6.8-д, харин өрхөөс гадуур ажил хийх болсон шалтгааны бүтцийг Зураг 6.7-д харуулав. Зургаас харахад өрхийн орлогод нэмэр болох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхэд хамгийн олон буюу 38.1 хувьтай байна. Ийм хариултыг сургуульд суралцаж буй хүүхдийн 37.1 хувь (1215 хүүхдийн 451 нь), харин сургуульд сураагүй хүүхдийн 39.9 хувь (642 хүүхдийн 256) нь өгчээ.

Зураг 6.7. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгааны бүтэц, хувиар




Хүүхэд өөрөө хүссэн учраас өрхөөс гадуур ажиллах болсон гэсэн хариултыг нийт хүүхдийн 20.2 хувь нь (1857 хүүхдийн 375), сургуульд суралцаж буй хүүхдийн 26.6 хувь нь (1215 хүүхдийн 323), сургуульд сураагүй хүүхдийн 8.1 хувь нь (642 хүүхдийн 52 нь) тус тус өгчээ. Нийт хүүхдийн 15.1 хувь нь өөрийгөө авч явах буюу эдийн засгийн хувьд бие даах зорилгоор өрхөөс гадуур ажил эрхэлж байгаа бөгөөд энэ нь сургуульд суралцаж буй хүүхдийн 9.7 хувь (1215 хүүхдийн 118), сургуульд сураагүй хүүхдийн 25.4 хувь (642 хүүхдийн 163 нь) байна. Ажлын дадлага туршлагатай болох (5.6 хувь), сургуульд сурахад гарах зардлыг олохын тулд (14.8 хувь) зарим хүүхэд ажил эрхэлж байна.

Хүснэгт 6.8. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг/ Хүйс	Бүгд	Шалтгаан					
		Ажлын дадлага, туршлагатай болох	Өрхийн орлогод нэмэр болох	Өөрийгөө авч явах/ эдийн засгийн хувьд бие даах	Сургуульд сурахад гарах зардлыг олох	Хүүхэд өөрөө хүссэн	Бусад
<b>Бүгд</b>	<b>1 857</b>	<b>104</b>	<b>707</b>	<b>281</b>	<b>275</b>	<b>375</b>	<b>115</b>
5 - 9	48					48	
10 - 11	56				56		
12 - 14	220		127		66	27	
15 - 17	1 533	104	580	281	153	300	115
<b>Бүгд</b>	<b>1 554</b>	<b>104</b>	<b>567</b>	<b>163</b>	<b>275</b>	<b>330</b>	<b>115</b>
Хөвгүүд	5 - 9	48	0	0	0	48	0
	10 - 11	56	0	0	56	0	0
	12 - 14	181	0	88	66	27	0
	15 - 17	1 269	104	479	163	153	255
<b>Бүгд</b>	<b>303</b>		<b>140</b>	<b>118</b>		<b>45</b>	
Охид	12 - 14	39	0	39	0	0	0
	15 - 17	264	0	101	118	45	0


Зураг 6.8-аас харахад өрхөөс гадуур ажиллаж байгаа шалтгаан хүйсээр ялгаатай байна. Тухайлбал, ажлын дадлага, туршлагатай болох, сургуульд сурахад гарах зардлыг олохын тулд ажил эрхэлсэн гэж хөвгүүдийн 24.4 хувь нь хариулсан байхад энэ шалтгаанаар ажил эрхэлсэн охид байхгүй байна. Ер нь охид өрхийн орлогод нэмэр болох, өөрийгөө авч явах буюу эдийн засгийн хувьд бие даах болон өөрөө хүссэн гэсэн гурван шалтгаанаар л өрхөөс гадуур ажил хийж байна.

Зураг 6.8. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгааны бүтэц, хүйсээр, хувиар



Өрхөөс гадуур ажиллаж буй хөвгүүдийн 36.5 хувь, охидын 46.2 хувь нь өөрийгөө авч явах буюу эдийн засгийн хувьд бие даах зорилгоор өрхөөс гадуур ажил хийж байна. Харин өөрөө хүсээд ажил хийж байгаа хөвгүүдийн нийт дүндээ эзлэх хувь охидынхоос 6.3 пунктээр илүү буюу 21.2 хувьтай байна.

Зураг 6.9. Өрхөөс гадуур ажиллах болсон шалтгааны бүтэц, хот, хөдөөгөөр, хувиар



Хүүхдүүдийн өрхөөс гадуур ажил хийх болсон шалтгаан хот, хөдөөгөөр их ялгаатай байгаа нь Зураг 6.9-өөс харагдаж байна. Хөдөөгийн хүүхдүүдийн өрхөөс гадуур ажиллах гол шалтгаан нь өрхийн орлогод нэмэр болох зорилготой байгаа (арван хүүхдийн долоо нь) бол хотын хүүхдүүдийн ердөө 14.7 хувь л ийм зорилготой байна. Хотын хүүхдүүдийн 32.9 хувь нь өөрөө хүсч хөдөлмөр эрхэлсэн байхад хөдөөгийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 3.4 хувьтай байна. Өөрөө хүсч мөн өөрийгөө авч явах буюу эдийн засгийн хувьд бие даах зорилгоор өрхөөс гадуур ажиллах болсон хотын хүүхдүүдийн хувь хөдөөгийн хүүхдүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаагаас харахад хотын хүүхдүүд эдийн засгийн хувьд бие даах сонирхол ихтэй байдаг нь харагдаж байна.

## 6.6 АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БОЛ ХҮҮХЭД БОЛОН ГЭР БҮЛД НЬ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хэрэв хүүхдүүд орлого олж буй ажлаа хийхээ боливол өөрт нь болон өрхөд нь ямар нөлөө үзүүлэх талаарх хүүхдүүдийн бодлыг дараах хүснэгтээр харуулж байна.

*Хүснэгт 6.9. Өрхөөс гадуур ажил эрхэлж буй хүүхдийн тоо, ажил эрхлэхгүй бол өөрт нь болон гэрт нь үзүүлэх нөлөө, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр*


		Бүгд	Өрхийн амьжиргааны түвшин доошилно	Өрх орлогын эх үүсвэргүй болно	Ажил, хөдөлмөрийн дадлага, туршлагагүй болно	Нөлөө үзүүлэхгүй
<b>Бүгд</b>		<b>1 857</b>	<b>628</b>	<b>216</b>	<b>110</b>	<b>903</b>
5 - 9		48				48
10 - 11		56	56			
12 - 14		220	100			120
15 - 17		1 533	472	216	110	735
Хүйс:	Хөвгүүд	1 554	589	114	110	741
	Охид	303	39	102		162
Байршил:	Хот	1 059	318	48	58	635
	Хөдөө	798	310	168	52	268
Бүгдэд эзлэх хувь						
<b>Бүгд</b>		<b>100.0</b>	<b>33.8</b>	<b>11.6</b>	<b>6.0</b>	<b>48.6</b>
5 - 9		100.0	0.0	0.0	0.0	100.0
10 - 11		100.0	100.0	0.0	0.0	0.0
12 - 14		100.0	45.5	0.0	0.0	54.5
15 - 17		100.0	30.8	14.1	7.2	47.9
Хүйс:	Хөвгүүд	100.0	37.9	7.3	7.1	47.7
	Охид	100.0	12.9	33.6	0.0	53.5
Байршил:	Хот	100.0	30.0	4.5	5.5	60.0
	Хөдөө	100.0	38.8	21.1	6.5	33.6

Өрхөөс гадуур хөдөлмөр эрхэлж буй нийт хүүхдийн 48.6 хувь нь ямар ч нөлөө үзүүлэхгүй, 33.8 хувь нь өрхийн амьжиргааны түвшин доошилно, 11.6 хувь нь өрх орлогын эх үүсвэргүй болно, 6.0 хувь нь ажил, хөдөлмөрийн дадлага, туршлагагүй болоход нөлөөлнө гэж хариулжээ.

Хүйсээр авч үзвэл хөвгүүдийн хувьд өрхийн амьжиргааны түвшин доошилно, ямар нэгэн нөлөөгүй гэсэн хариултууд зонхилж байхад харин охидын хувьд нөлөө үзүүлэхгүй, өрх орлогын эх үүсвэргүй болно гэж дийлэнх нь хариулжээ. Хөвгүүдийн 37.9 хувь нь өрхийн амьжиргаа доошилно гэсэн байхад ийм хариултыг охидын 12.9 хувь нь өгчээ. Харин ямар ч нөлөөгүй гэсэн хариултыг хөвгүүдийн 47.7 хувь нь, охидын 53.5 хувь нь өгчээ.

Ажил хийхээ болиход өөрт болон өрхөд үзүүлэх нөлөөг байршлаар хот, хөдөө Улаанбаатар хотоор харьцуулсныг Зураг 6.10-д үзүүлээ. Зургаас үзэхэд хотын хүүхдүүдийн ихэнх нь буюу 30.0 хувь нь өрхийн амьжиргааны түвшин доошилно, 60.0 хувь нь ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж хариулсан байхад хөдөөгийн хүүхдүүдийн 38.8 ба 33.6 хувь нь эдгээр хариултыг өгсөн байна. Нийслэл Улаанбаатар хотын хүүхдүүдийн 46.5 хувь нь өрхийн амьжиргааны түвшин доошилно гэж хариулсан байна.

Зураг 6.10. Ажил эрхлэхгүй бол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө, хот, хөдөө, Улаанбаатар хот, хувиар



Өрх орлогын ямар нэгэн эх үүсвэргүй болно гэсэн хариултыг хот, суурин газрын хүүхдүүдийн 4.5 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 21.0 хувь нь өгсөн байгаа нь эдгээр хүүхдүүд ганцаараа өрхийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж байгааг харуулж байна. Ийм хариултыг Улаанбаатар хотын хүүхдүүд өгөөгүй байгаагаас харахад эдгээр хүүхдүүд аймгийн төв болон хөдөө сум, багийн хүүхдүүд байна.





**VII**  
**БҮЛЭГ**

**АЖИЛ ХИЙЖ БУЙ ХҮҮХДИЙН АЖЛЫН БАЙР,  
АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦЛИЙН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ**

### 7.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Хүүхдийн хөдөлмөрийн талаар илүү өргөн хүрээнд судалж, хүүхдийн хөдөлмөрийг устгах төсөл, хөтөлбөр боловсруулах шаардлага байсаар байна. Хүүхдийн хөдөлмөрийг хүүхдийн нас, ажилласан цагаар нь тодорхойлохоос гадна хүүхэд ямар үүрэгтэй ажил гүйцэтгэж байгаа, ямар нөхцөлд ажиллаж байгаа болон тухайн хүүхдийн эрүүл мэнд, бие бялдарт нь ямар хор хохирол учруулж болохуйц байгаа зэргийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.


Ажлын байрны нөхцөл гэдэг нь хүүхэд эсвэл насанд хүрэгчдийн ажиллаж буй ажлын байрны орчин тойрон, нийгмийн бодит байдлыг хэлнэ<sup>1</sup>. Өөрөөр хэлбэл тодорхой ажлын байран дээрх хөдөлмөрлөх үйл явц, ажлын байрны байршил нөхцөл юм.

2011-2012 оны ХХС-гаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 5-17 насны хүүхдийн эрхэлж буй ажлын байр, ажлын байрны байршил, ажлын байрны нөхцлийн талаар тусгайлан судалж, гарсан үр дүнг танилцуулж байна.

### 7.2. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН АЖЛЫН БАЙРНЫ БАЙРШИЛ

Судалгааны тархаалтын тооцоогоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа буюу ажил эрхэлж буй 94.0 мянган хүүхдийн 72.7 мянга нь буюу 77.4 хувь нь малын бэлчээр/ тариалангийн талбайд, 5.4 мянга буюу 5.8 хувь нь өөрийн гэрт, тусгайлсан ажлын байргүй, 5.3 мянга буюу 5.7 хувь нь төвлөрсөн зах, үйлчилгээний төвд, 3.4 мянга буюу 3.7 хувь нь өөрийн гэрт, тусгайлсан ажлын байртай, 3.1 мянга буюу 3.3 хувь нь жижиг дэлгүүр, үйлчилгээ, засварын газар, ТҮЦ-д ажил эрхэлж байна (Зураг 7.1-ийг үзнэ үү).

Зураг 7.1 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 5-17 насны хүүхдийн ажлын байрны байршлын бүтэц, хувиар




<sup>1</sup> Хүүхдийн Хөдөлмөрийн Статистик Мэдээлэл, Мониторингийн Хөтөлбөр (Симпок) -Хүүхдийн хөдөлмөрийн байдлыг шуурхай үнэлэх судалгааны арга зүйн гарын авлага

Малын бэлчээр, тариалангийн талбай, өөрийн гэрт тусгайлсан ажлын байртай болон байргүй, жижиг дэлгүүр, үйлчилгээ, засварын газар, ТҮЦ, төвлөрсөн зах, үйлчилгээний төв болон гудамжинд бүх насны бүлгийн хүүхэд ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байхад тээврийн хэрэгсэлд 12-17 настай, ажил олгогчийн гэрт 12-14 настай, барилга, үйлдвэрийн газар, уурхайд зөвхөн 15-17 настай хүүхдүүд ажиллаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил хийж буй нийт хүүхдийг хүйсээр нь ажлын байрны байршлаар гаргаж Зураг 7.2 –т харууллаа. Үйлдвэрийн газар, хогийн цэг, гудамжинд, уурхайд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хөвгүүд олон байхад супермаркет, хүнсний дэлгүүр, төвлөрсөн зах, үйлчилгээний төвд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа охид хөвгүүдээс олон байна. Харин барилга дээр зөвхөн хөвгүүд (15-17 насны) ажиллаж байхад, ажил олгогчийн гэрт зөвхөн охид (12-14) ажиллаж байгаа дүн гарлаа.

Зураг 7.2 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн ажлын байрны байршил, хүйс, хувиар




Улаанбаатар хотод өрхөөс гадуур ажил эрхэлж буй таван хүүхдийн нэг нь төвлөрсөн зах, үйлчилгээний төвд ажиллаж байна.

### 7.3. АЖЛЫН БАЙРНЫ ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ

Ажлын байрны талаарх үнэлгээний асуултыг судалгаанд хамрагдсан өрхийн өрхөөс гадуур ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдээс асуусан болно. Судалгааны тархаалтын дүнгээр эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй нийт хүүхдийн 2.1 хувь буюу 1857 хүүхэд өрхөөс гадуур ажил эрхэлж байна гэсэн дүн гарсан. Эдгээр хүүхдүүдийн 86.9 хувь нь ажлын байрандаа сэтгэл ханамжтай гэж хариулсан байхад үлдсэн 13.1 хувь нь ажлын байр нь их тоосжилт/чийгтэй/, газар дор, хязгаарлагдмал орчинд ажилладаг, ариун цэврийн шаардлага хангаагүй газар ажиллаж байна гэдэг шалтгаанаар сэтгэл ханамжгүй гэж хариулсан байна.


Хотод өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн 84.3 хувь нь ажлын байран дээрээ сэтгэл ханамжтай байгаа бөгөөд хөдөөд энэ үзүүлэлт 90.4 хувь болж хотынхоос 6.1 пунктээр илүү байна.

Зураг 7.3 Өрхөөс гадуур ажил эрхэлж буй хүүхдийн ажлын байрны талаарх үнэлгээ, хувиар



Улсын хэмжээнд өрхөөс гадуур ажил эрхэлж буй хүүхдийн ажлын байрандаа сэтгэл ханамжгүй байгааг шалтгаанаар авч үзэхэд: 41.8 хувь нь газар дор, хязгаарлагдмал орчинд, 23.8 хувь нь их тоосжилт/ чийгтэй нөхцөлд, 23.4 хувь нь ариун цэврийн шаардлага хангаагүй газар, 11.1 хувь нь бусад нөхцөлд ажилладаг учраас сэтгэл ханамжгүй байдаг гэжээ.

Зураг 7.4 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн ажлын байрандаа сэтгэл ханамжгүй байгаа шалтгаан, хувиар




Хөдөөд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүүхдийн 34.6 хувь нь их тоосжилт/ чийгтэй, 34.1 хувь бусад, 31.3 хувь нь газар дор хязгаарлагдмал орчинд ажилладаг учраас эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй гэсэн бол хотын хүүхдийн 64.9 хувь нь газар дор, хязгаарлагдмал орчинд ажилладаг, үлдсэн 35.1 хувь нь ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд ажиллаж байна гэж хариулжээ.

Өрхөөс гадуур ажил эрхэлж буй 1.9 мянган хүүхдийн 6.5 хувь нь эрхэлж буй ажил дээрээ бие болон сэтгэл санаагаар дарамтлуулдаг гэж хариулсан байна. Хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдтэй харьцуулахад илүү бие болон сэтгэл санааны дарамтан дор ажилладаг байна (хотод 5.3 хувь, хөдөөд 8.0 хувь).

Бие болон сэтгэл санаагаар дарамтлуулдаг нийт хүүхдийн дийлэнх нь (давхардсан тоогоор) зодуулдаг, хөдөлмөрийн хөлсийг шударга бусаар тооцож олгодог гэсэн бол дараагийнх нь хэт их ажилладаг, загнуулдаг, хэл амаар доромжлуулдаг гэсэн байна.


Схем 7.1 Бие болон сэтгэл санааны дарамтад өртдөг хүүхдийн тоо (давхардсан тоогоор), дарамтын төрлөөр, хувиар



#### 7.4. ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, БАГАЖ, ХЭРЭГСЛЭЭР ХАНГАГДСАН БАЙДАЛ


Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хүүхдийн 41.1 хувь нь эрхэлж буй ажлын байран дээрээ хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэдэг бол, 58.9 хувь хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэлгүй ажиллаж байна.

Схем 7.2 Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэдэг эсэх



Хүүхдийг хийж буй ажил мэргэжлээр нь ангилбал техникч болон туслах/дэд мэргэжлийн ажил хийж байгаа хүүхэд бүгдээрээ үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил хийж байгаа хүүхдийн 58.3 хувь нь, энгийн ажил хийж байгаа хүүхдийн 54.7 хувь нь, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил хийж байгаа хүүхдийн 27.3 хувь нь, худалдаа, үйлчилгээний ажил хийж байгаа хүүхдийн 16.2 хувь нь хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэж байна.

Зураг 7.10 Хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэдэг хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар



Судалгааны дүнгээр зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгч, үйлчлэгч, туслагч, угаагч, гараар хаяглагч, боогч, савлагч, баглагч, нөөшлөгч, хайрцаглагч, хадагч, ачаа зөөгч болон гудамжин дах ажил, үйлчилгээний ажил хийж байгаа бүх хүүхэд бүгдээрээ хөдөлмөр хамгааллын ямар нэгэн хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэж байгаа бол барилга угсралтын туслах ажил хийж байгаа нийт хүүхдийн 46.7 хувь нь л хөдөлмөр хамгааллын ямар нэг хувцас, багаж, хэрэгсэл хэрэглэж байгаа дүн гарч байна.





VIII

БҮЛЭГ

ХҮНД ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ АЖИЛ  
ХИЙЖ БҮЙ ХҮҮХДҮҮД

### 8.1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг нь “Аюултай ажил” юм. ОУХБ-ын 190 дүгээр зөвлөмжид заасны дагуу аюултай ажилд хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил, газар дор, усны гүнд болон аюултай өндөрт эсвэл хэт давчуу орон зайд гүйцэтгэх ажил, аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах, хүнд ачааг гараар өргөж, зөөх, аюултай бодис, урвалж буюу процесст өртүүлэх эрүүл бус орчин, агаарын хэм, дуу чимээ, чичиргээн бүхий хүүхдийн эрүүл мэндэд хортой нөхцөлд хийж буй ажил, уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар ажиллах, ажил олгогчийн гэрт шалтгаангүйгээр хашигдан хийх ажлууд багтана.

Аюултай ажилд багтах ажлын байр, ажил мэргэжлийн жагсаалтыг улс орон бүр нийгмийн түншлэлийн гурван талаараа зөвшилцсөний үндсэн дээр үндэсний хэмжээнд тодорхойлох ёстой байдаг. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулинд насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон бөгөөд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах тухай заасны дагуу 2008 онд НХХ-ийн сайдын тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Энэ бүлэгт Монгол Улсад мөрдөгдөж буй “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хүнд хортой ажлын нөхцөл бүхий эдийн засгийн салбарт ажиллаж байгаа, хүнд хортой бус ажлын нөхцөл бүхий салбарт хүнд хортой ажил хийж байгаа, хүнд хортой бус ажлыг долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар хийж байгаа 15-17 насны хүүхэд, сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж буй 5-11 насны бүх хүүхэд, харин 14-өөс илүү цаг ажилласан 12-14 насны хүүхдүүдийг хамруулан хүнд хортой болон аюултай ажил хийж байгаа хүүхдийн тоог тооцож гаргалаа.

### 8.2. ХҮНД ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ АЖИЛ ХИЙЖ БҮЙ ХҮҮХЭД

Судалгааны тархаалтын тооцоогоор эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй 5-17 насны нийт 93968 хүүхдийн 11.1 хувь буюу 52772 хүүхэд хүнд хортой болон аюултай хэлбэрийн ажил эрхэлж байна (Хүснэгт 8.1). Аюултай ажил хийж буй таван хүүхдийн дөрөв нь эрэгтэй, нэг нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 8.1. Аюултай ажил хийж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр (батлагдсан аргачлалын дагуу)

Насны бүлэг/хүйс	Аюултай эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхэд <sup>a</sup>	Уртасгасан цагаар ажиллаж буй хүүхэд <sup>a</sup>	Хүнд, хортой ажлын нөхцөлд ажиллаж буй хүүхэд <sup>c</sup>	Аюултай ажил хийж буй хүүхэд <sup>d</sup>
<b>5-9 нас</b>				
Эрэгтэй	0	185	0	185
Эмэгтэй	0	52	0	52
Дүн	0	237	0	237
<b>10-11 нас</b>				
Эрэгтэй	109	250	56	415
Эмэгтэй	0	99	0	99
Дүн	109	349	56	514
<b>12-14 нас</b>				
Эрэгтэй	207	1333	120	1660
Эмэгтэй	67	201	0	268
Дүн	274	1534	120	1928
<b>15-17 нас</b>				
Эрэгтэй	390	4944	841	6175




Эмэгтэй	0	1443	101	1544
Дүн	390	6387	942	7719
<b>5-17 насны нийт хүүхэд</b>				
Эрэгтэй	706	6712	1017	8435
Эмэгтэй	67	1795	101	1963
<b>Дүн</b>	<b>773</b>	<b>8507</b>	<b>1118</b>	<b>10398</b>

Тайлбар:

- <sup>a</sup> Хуулиар хориглосон ажил мэргэжлийн ажил хийж буй хүүхдийн тоо
- <sup>b</sup> Долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж буй хүүхдийн тоо
- <sup>c</sup> Хуулиар хориглосон хүнд хортой нөхцөлтэй ажлын байранд ажиллаж буй хүүхдийн тоо
- <sup>d</sup> Ажлын байрны нөхцөл, хийж буй ажлын төрөл болон сүүлийн 7 хоногт ажилласан цагийг нь үндэслэн тооцсон аюултай ажил хийж буй хүүхдийн тоо


Хүнд хортой болон аюултай ажил хийж буй нийт хүүхдийн 7,3 хувь нь 5-11 настай, 18,5 хувь 12-14 настай, 74.2 хувь нь 15-17 настай хүүхдүүд байна. Насны бүтцийг дараах зурагт харууллаа.

Зураг 8.1. Аюултай ажил хийж буй хүүхдийн насны бүтэц, хувиар



Аюултай ажил эрхэлж буй хүүхдийг хүйс, насны бүлгээр нь авч үзэхэд энэхүү төрлийн ажлыг хөвгүүд түлхүү хийж байгаа бөгөөд нас ахих тутам нэмэгдэж, 15-17 насны аюултай ажил хийж буй таван хүүхдийн дөрөв нь хөвгүүд байна (Зураг 8.2).


Зураг 8.2 Аюултай ажил хийж буй хүүхдийн тоо, хүйс, насны бүлгээр



Судалгааны тархаалтын тооцоогоор аюултай ажил хийж буй нийт хүүхдийн 7.4 хувь буюу 773 хүүхэд нь Монгол Улсад мөрдөгдөж буй НХХ (хуучнаар)-ийн сайдын 2008 онд баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-нд буй ажил мэргэжлийн ажлыг хийж байна (Зурагт 8.3-ийг харна уу). Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажил хийж буй хоёр хүүхдийн нэг нь хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ямар нэгэн төрлийн ачаа зөөх ажлыг хийж байна.

Сүүлийн долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажилласан 5-17 насны арван хүүхдийн найм нь хөвгүүд байна.

### 8.3 Аюултай ажил хийж буй хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар





**IX**

**БҮЛЭГ**

**ХҮҮХДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН  
УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ**

### 9.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Судалгааны нэг зорилго нь ажил эрхэлж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоог байнгын болон тухайн үеийн аргачлалаар улирлын хэлбэлзлийг тусган үндэсний хэмжээнд болон хот, хөдөөгийн түвшинд судлан гаргах явдал юм. Энэ зорилгын хүрээнд түүврийн хэмжээг дөрвөн улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хийсэн юм. Нэг улиралд 3204 өрхийг түүвэрлэн хамруулж, нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн тооцоолж гаргасны зэрэгцээ хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх зарим гол үзүүлэлтүүдийг улирлаар гаргасан дүнг танилцуулж байна. Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны хугацаа нь цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй бөгөөд судалгааны эхний буюу 1 дүгээр улиралд 2011 оны 7-9 дүгээр сар, 2 дугаар улиралд 2011 оны 10-12 дугаар сар, 3 дугаар улиралд 2012 оны 1-3 дугаар сар, 4 дүгээр улиралд 2012 оны 4-6 дугаар сарууд хамрагдсан болно.

### 9.2 АЖИЛ ЭРХЭЛСЭН 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО

Судалгааны үр дүнд үндэслэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн 5-17 насны хүүхдийн тоог улирлаар тооцож гаргасан дүнг Хүснэгт 9.1-д харуулав.

Судалгаагаар хүүхдийн ажил эрхлэлт улирлаар хэлбэлзэж байгаа бөгөөд 4 дүгээр улирал буюу 4-6 сард хамгийн их буюу 142.3 мянган хүүхэд, 2 дугаар улирал буюу 10-12 сард хамгийн бага буюу 53.2 мянган хүүхэд ажил эрхэлсэн байна. Судалгааны 2 дугаар улирал (2011 оны 10-12 сар) нь ил задгай газар эсвэл гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн, хатуу ширүүн уур амьсгалтай өвлийн улирал байдаг, хоёрдугаарт, хүүхэд залуусын хичээл сургуульдаа суралцах үетэй холбоотойгоор хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхлэх боломж багасч ирдэг байж болох талтай юм. Харин 4 дүгээр улирал (2012 оны 4-6 сар)-д дулааны улиралд хийгдэж эхэлдэг улирлын чанартай ажлууд эхлэхийн зэрэгцээ хүүхдүүдийн сургуулийн амралтын цаг эхэлж өрхийнхөө мал аж ахуй, газар тариалан болон бусад үйлдвэрлэл үйлчилгээний ажилд туслахаас гадна бусад ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох нөхцөл сайн бүрдэж эхэлдэг болохоор энэ улирлын хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны оролцоог их болгоход нь нөлөөлсөн байна. Энэ улирлын эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдүүдийн оролцоог насны бүлгээр нь авч үзэхэд ерөнхийдөө жигд оролцсон байна гэж хэлж болохоор байна. Энэ байдал мөн 1 дүгээр улирал дээр хадгалагдаж байна.

Гэтэл 2 дугаар улиралд 15-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 40.0 хувьтай, 5-9 насныхан хамгийн бага буюу 7.6 хувьтай байна. 1-3 улирлын байдлаар 10-11 насны ажил эрхэлж буй охидын эзлэх хувь хөвгүүдийнхээс 0.4- 15.0 пунктээр ялгаатай байна.


Хүснэгт 9.1 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, дүнд эзлэх хувь, хүйсээр, улирлаар

Насны бүлэг/ хүйс	1-р улирал (7-9 сар)		2-р улирал (10-12 сар)		3-р улирал (1-3 сар)		4-р улирал (4-6 сар)	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>85 461</b>	<b>100,0</b>	<b>53 171</b>	<b>100,0</b>	<b>94 963</b>	<b>100,0</b>	<b>142 278</b>	<b>100,0</b>
5 - 9	15 105	17,7	4 017	7,6	18 417	19,4	33 170	23,3
10 - 11	10 689	12,5	10 035	18,9	14 137	14,9	19 636	13,8
12 - 14	27 000	31,6	17 835	33,5	26 241	27,6	44 702	31,4
15 - 17	32 667	38,2	21 284	40,0	36 168	38,1	44 770	31,5
<b>Хөвгүүд</b>	<b>48 540</b>	<b>100,0</b>	<b>30 573</b>	<b>100,0</b>	<b>46 947</b>	<b>100,0</b>	<b>77 419</b>	<b>100,0</b>
5 - 9	9 395	19,4	2 265	7,4	8 507	18,1	18 425	23,8
10 - 11	5 098	10,5	3 810	12,5	6 906	14,7	10 854	14,0
12 - 14	15 700	32,3	10 770	35,2	12 686	27,0	24 787	32,0
15 - 17	18 347	37,8	13 728	44,9	18 848	40,2	23 353	30,2

Охид	36 921	100,0	22 598	100,0	48 016	100,0	64 859	100,0
5 - 9	5 710	15,5	1 752	7,8	9 910	20,6	14 745	22,7
10 - 11	5 591	15,1	6 225	27,5	7 231	15,1	8 782	13,6
12 - 14	11 300	30,6	7 065	31,3	13 555	28,2	19 915	30,7
15 - 17	14 320	38,8	7 556	33,4	17 320	36,1	21 417	33,0


Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхлэлтийн улирлын хэлбэлзэл хот, хөдөөгөөр ялгаатай байгаа нь дараах зургаас харагдаж байна. Ажил эрхэлж буй нийт хүүхдийн дүнд хөдөө орон нутгийн хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны оролцоо буюу ажил эрхлэлтийн эзлэх хувь өндөр буюу улирлаар авч үзэхэд 66.8-84.1 –ийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд хамгийн их нь 4 дүгээр улиралд (84.1 хувь) байна. Гэтэл хот, суурин газрын хүүхдүүдийн хувьд 2 дугаар улиралд хамгийн их (33.2 хувь) ажил эрхэлсэн буюу эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон гэж гарсан байна.

Зураг 9.1 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, хот, хөдөөгөөр, улирлаар, хувиар



Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдүүдийг хүйсээр, улирлаар харьцуулж харахад зөвхөн 1 дүгээр улиралд хот, суурин газарт ажил эрхэлсэн хөвгүүдийн хувь өндөр байхад бусад улиралд хөдөө орон нутагт ажил эрхэлсэн хөвгүүдийн хувь өндөр байна. Мөн 1 дүгээр улиралд хөдөө орон нутагт ажил эрхэлсэн охидын хувь өндөр байхад бусад улирлуудад хот, суурин газарт ажил эрхэлсэн охидын хувь өндөр байна. Өөрөөр хэлбэл 1 дүгээр улиралд хотод ажил эрхэлсэн хөвгүүд, хөдөө орон нутагт ажил эрхэлсэн охидын хувь өндөр байна.

Зураг 9.2 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, хүйс, хот, хөдөөгөөр, улирлаар, хувиар



### 9.2.1. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Монгол орны жилийн дөрвөн улирлын онцлогоос шалтгаалан ажил эрхэлсэн хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбар янз бүр байгаа нь Хүснэгт 9.2-оос харагдаж байна.

Өвлийн улирал буюу 2 дугаар улирлаас бусад улиралд 5-17 насны ажил эрхэлсэн арван хүүхдийн найм нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, нэг нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажилласан байна.

*Хүснэгт 9.2 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар, улирлаар*

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	1 дүгээр улирал (7-9 сар)	2 дугаар улирал (10-12 сар)	3 дугаар улирал (1-3 сар)	4 дүгээр улирал (4-6 сар)
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	83,7	72,8	82,5	83,3
Уул уурхай, олборлолт	0,8	5,2	0,4	0,2
Боловсруулах үйлдвэрлэл	1,3	0,4	4,6	2,2
Барилга	1,6	17,4	0	2,2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	10,5	0,3	10,8	11,2
Бусад	2,1	3,9	1,7	0,9
<b>Дүн</b>	<b>100,0</b>	<b>100,0</b>	<b>100,0</b>	<b>100,0</b>

### 9.2.2. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

Судалгааны дүнгээс харахад мал аж ахуй эрхэлсэн хүүхэд аль ч улирлын хувьд хамгийн их хувийг эзэлж байгаа нь монгол орны онцлог шинж байдал буюу монголчууд эрт дээр үеэс таван хошуу малыг жилийн дөрвөн улиралд маллаж, ашиг, шимээр нь амьдарч ирсэн түүхэн уламжлалтай холбоотой. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч гэсэн статуст хамаарах ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо улирал бүрд харилцан адилгүй байна. 1 – 3 дугаар улиралд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй таван хүүхдийн бараг хоёр нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байсан бол 2, 4 дүгээр улиралд 3 болж нэмэгдсэн байна.


*Хүснэгт 9.3 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, дүнд эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн статусаар*

Хөдөлмөр эрхлэлтийн статус	1 дүгээр улирал (7-9 сар)	2 дугаар улирал (10-12 сар)	3 дугаар улирал (1-3 сар)	4 дүгээр улирал (4-6 сар)
Цалин хөлстэй ажиллагч	1,9	2,5	1,5	1,1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	3,1	1,3	2,1	3,1
Мал аж ахуй эрхлэгч	75,8	66,0	75,3	63,3
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	17,9	30,2	21,0	32,1
Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	1,3	0,0	0,0	0,4
<b>Дүн, %</b>	<b>100,0</b>	<b>100,0</b>	<b>100,0</b>	<b>100,0</b>

### 9.2.3. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдүүдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар

5-17 насны ажил эрхэлсэн нийт хүүхдийг ажил мэргэжлийн ангиллаар ангилж, 4 улирлаар харьцуулж харахад хөдөө аж ахуйн холбогдолтой ажил эрхэлж буй хүүхдүүд хамгийн их хувийг эзэлж байна. Харин 2 дугаар улирал буюу 10-12 сард худалдаа, үйлчилгээний ажил эрхэлж буй хүүхдийн хувь хамгийн их буюу 19.8 байна. Мөн судалгааны 1, 2 дугаар улирал буюу 7-12 сард энгийн ажил, мэргэжлийн ажил эрхэлсэн хүүхдийн тоо бусад улирлынхаас их байна.

Зураг 9.3 Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар, улирлаар, хувиар



### 3.3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ

Хүүхдийн хүсэл мөрөөдөл, зорилгодоо хүрэх замыг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг бол чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөж буйгаас ихээхэн шалтгаална. Энэ цаг хугацааг Монгол хүүхэд бүр өөр өөрийн өнгө төрхөөр өнгөрөөж байна. Судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдүүдээс хоногт зурагт үзэх, тоглох, амрах зэрэг чөлөөт цаг хэр зэрэг гардаг, өдөрт хичнээн цагийг чөлөөт цагт зарцуулсан талаарх мэдээллийг асууж, улирлаар тооцсон дүнг танилцуулж байна.


Судалгаанд хамрагдсан 5-17 насны бүх хүүхэд хоногт зурагт үзэх, тоглох, амрах зэрэг чөлөөт цаг гардаг гэж хариулжээ.

Хүснэгт 9.4 5-17 насны хүүхдийн тоо, чөлөөт цагийн интервалаар, улирлаар

	1 дүгээр улирал (7-9 сар)	2 дугаар улирал (10-12 сар)	3 дугаар улирал (1-3 сар)	4 дүгээр улирал (4-6 сар)
<b>Нийт хүүхдийн тоо</b>	<b>617 180</b>	<b>567 311</b>	<b>571 074</b>	<b>600 741</b>
Чөлөөт цаг гардаг хүүхэд	617 180	567 311	571 074	600 741
Үүнээс: цагаар				
1-2	55 705	75 734	67 300	73 057
3-4	212 808	273 012	235 760	232 515
5-6	204 686	162 836	184 840	194 248
7-8	143 981	55 729	83 174	100 921

Судалгааны дүнгээр хүүхдүүдийн чөлөөт цагт зарцуулдаг цагийн хэмжээ улирлаар хэлбэлзэж байгаа нь Зураг 9.4-өөс харагдаж байна.

Зураг 9.4 5-17 насны хүүхдийн чөлөөт цагтаа зарцуулж буй дундаж цаг, хувь, улирлаар



2 дугаар улирал буюу 10-12 сард судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдүүдийн 48.1 хувь нь өдөрт 3-4 цагийг чөлөөт цагтаа зарцуулдаг гэж хариулсан нь бусад улирлуудын 3-4 цагийг чөлөөт цагтаа зарцуулдаг хүүхдүүдийн хувиас 6.8-13.6 пунктээр илүү байна.





**X**

**БҮЛЭГ**

**ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН 2002-2003,  
2007-2008, 2011-2012 ОНЫ СУДАЛГААНЫ ҮР  
ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

### 10.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Монгол Улсын хэмжээнд анх удаа “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа/ХХС/”-г Ажиллах хүчний судалгаатай хамтатган 2002-2003 онд олон улсын жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Энэхүү судалгаа нь хүүхдийн хөдөлмөрийн талаар ОУХБ-аас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар анх удаа өргөн хэмжээний мэдээлэл цуглуулж, хүүхдийн эдийн засгийн идэвх, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаарх мэдээллийн сангийн эхлэлийг тавьсан юм. Үүнээс хойш ХХС-г Монгол Улсын хэмжээнд 3 дахь (2006-2007, 2011-2012 онд) удаагаа зохион байгуулан явууллаа. Энэ бүлэгт 2002-2003, 2006-2007, 2011-2012 оны ХХС-ны үр дүнг харьцуулан гаргаж байна.

### 10.2 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН 5-17 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО

Судалгаанд хамрагдсан нийт 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийг тухайн үеийн буюу сүүлийн 7 хоногийн идэвхийн байдлаар тооцож Хүснэгт 10.1-д үзүүлж байна.

Хүснэгт 10.1. 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвх, насны бүлэг, хүйсээр, судалгааны дүнгээр, хувиар

Насны бүлэг		Бүгд	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн	Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон	Зөвхөн сурсан	Аль алинийг нь хийгээгүй	
<b>Бүгд</b>	2002 - 2003	100.0	9.7	74.8	8.2	7.3	
	2006 - 2007	100.0	11.2	64.6	15.0	9.2	
	2011 - 2012	100.0	16.0	58.5	19.4	6.1	
Насны бүлэг	5 - 9	2002 - 2003	100.0	6.9	62.0	9.3	21.8
		2006 - 2007	100.0	8.5	47.0	19.5	25.0
		2011 - 2012	100.0	8.8	42.9	31.6	16.7
	10 - 14	2002 - 2003	100.0	7.0	82.9	9.6	0.5
		2006 - 2007	100.0	10.3	73.6	15.2	0.9
		2011 - 2012	100.0	18.0	65.7	15.7	0.6
	15 - 17	2002 - 2003	100.0	17.9	76.7	4.6	0.8
		2006 - 2007	100.0	15.6	73.5	9.4	1.5
		2011 - 2012	100.0	22.3	68.1	8.8	0.8
Хүйс	Хөвгүүд	2002 - 2003	100.0	11.6	71.6	8.7	8.1
		2006 - 2007	100.0	13.0	62.2	15.2	9.6
		2011 - 2012	100.0	16.9	56.9	19.6	6.6
	Охид	2002 - 2003	100.0	7.7	78.1	7.7	6.5
		2006 - 2007	100.0	9.3	67.3	14.8	8.6
		2011 - 2012	100.0	14.9	60.2	19.1	5.8


Нийт хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон, зөвхөн сурсан, аль алинийг нь хийгээгүй гэсэн ангилалд хувааж гурван судалгааны үр дүнгээр харьцуулан гаргалаа.

Гурван удаагийн судалгааны үр дүнгээс харахад сүүлийн жилүүдэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл 2002-2003 онд 5-17 насны нийт хүүхдийн 9.7 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байсан бол 2006-2007 онд 11.2 хувь, 2011-2012 онд 16.0 хувь болж өссөн байна.

Мөн насны бүлгээр харахад бараг бүх насны бүлэгт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн эзлэх хувь нэмэгджээ. Зөвхөн 15-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн эзлэх хувь 2002-2003 оноос 2006-2007 онд 2.3 пунктээр буурснаас бусад бүх тохиолдолд өссөн байна. Хүйсийн хувьд ч ялгаагүй сүүлийн жилүүдэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хөвгүүд, охидын тоо өсчээ.

Харин жил ирэх тусам зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо буурч зөвхөн сурсан хүүхдийн тоо өссөн байна. Тухайлбал, 2002-2003 оноос 2006-2007 онд зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд 10.2 пунктээр буурсан бол 2006-2007 оноос 2011-2012 онд 6.1 пунктээр буурсан байна. Мөн насны бүлэг болон хүйсийн хувьд ч гэсэн энэ хандлага ажиглагдаж байна.


Зураг 10.1. Хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдлын бүтэц, насны бүлэг, судалгааны дүнгээр



Гурван удаагийн судалгааны дүнгээс харахад 2011-2012 оны хувьд 15-17 насны зөвхөн сургуульд сурсан хүүхдийн эзлэх хувь өмнөх судалгааны дүнгээс 0.6 пунктээр буурсан байна. Харин бусад бүх тохиолдолд зөвхөн сургуульд сурсан буюу эдийн засгийн үйл ажиллагаа болон гэрийн ажил хийхэд оролцоогүй хүүхдийн эзлэх хувь сүүлийн жилүүдэд өссөн байна. Энэ нь мөн хүйсийн хувьд ч ялгаагүй өссөн дүнтэй байна.

2011-2012 онд зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхдийн нийт дүнд эзлэх хувь 58.5 хувь болж 2002-2003 оныхоос 16.3 пункт, 2006-2007 оныхоос 6.1 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 10.2. Сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхийн байдлын бүтэц, хүйсээр, судалгааны дүнгээр



Судалгааны онуудаар харахад бүхий л хугацаанд охидыг бодвол хөвгүүд илүүтэйгээр эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг байна /Зураг 10.2/. Тухайлбал, 2011-2012 онд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл нийт охидод эзлэх эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн охид 14.9 хувь байхад нийт хөвгүүдэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хөвгүүдийн эзлэх хувь 16.9 байна.

### 10.3 АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД


2011-2012 оны судалгааны дүнгээр 5-17 насны нийт хүүхдийн 16.0 хувь буюу 93968 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн байна. Энэ дүнг өмнөх хоёр судалгааны дүнтэй харьцуулахад 4.5-5.9 пунктээр өссөн нь сүүлийн жилүүдэд хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо ихэссэнтэй холбоотой. Гурван удаагийн судалгааны дүнг насны бүлгээр харьцуулан авч үзэхэд ажил эрхэлсэн 5-9 насны хүүхдүүдийн ажил эрхэлсэн нийт хүүхдийн дүнд эзлэх хувь 2006-2007 онд 25.4 хувь болж өссөн бол 2011-2012 онд 18.8 хувь болж буурсан байна. Харин 10-14 насныхны эзлэх хувь тогтмол өсч байгаа бол 15-17 насныхны эзлэх хувь тогтмол буурсан дүнтэй харагдаж байна /Хүснэгт 10.2/.

Хүснэгт 10.2. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн насны бүтэц, судалгааны дүнгээр

	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа			Бүтэц, хувиар		
	2002-2003	2006-2007	2011-2012	2002-2003	2006-2007	2011-2012
<b>Бүгд</b>	<b>68 580</b>	<b>71 330</b>	<b>93 968</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
5-9	15 320	18 116	17 677	22.3	25.4	18.8
10-14	21 407	25 016	42 569	31.2	35.1	45.3
15-17	31 853	28 198	33 722	46.4	39.5	35.9
<b>Хөвгүүд</b>	<b>41 874</b>	<b>43 037</b>	<b>50 870</b>	<b>61.1</b>	<b>60.3</b>	<b>54.1</b>
5-9	9 005	10 332	9 648	13.1	14.5	10.3
10-14	13 762	14 929	22 653	20.1	20.9	24.1
15-17	19 107	17 776	18 569	27.9	24.9	19.8
<b>Охид</b>	<b>26 706</b>	<b>28 293</b>	<b>43 098</b>	<b>38.9</b>	<b>39.7</b>	<b>45.9</b>
5-9	6 315	7 784	8 029	9.2	10.9	8.5
10-14	7 645	10 087	19 916	11.1	14.1	21.2
15-17	12 746	10 422	15 153	18.6	14.6	16.1

Харин нийт ажил эрхэлсэн хүүхдүүдийн дотор хөвгүүдийн эзлэх хувь буурч, охидын эзлэх хувь өссөн байна.

Зураг 10.3. Ажил эрхэлсэн хүүхдийн насны бүтэц, судалгааны дүнгээр



Зураг 10.3-аас харахад 2002-2003, 2006-2007 онд ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх хувийг 15-17 насныхан эзэлж байсан бол 2011-2012 онд дийлэнх хувийг 10-14 насныхан эзэлж байна.

## Хүснэгт 10.3. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, судалгааны дүнгээр

	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа			Бүтэц, хувиар		
	2002-2003	2006-2007	2011-2012	2002-2003	2006-2007	2011-2012
<b>Бүгд</b>	<b>68 581</b>	<b>71 331</b>	<b>93 968</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	62 880	63 428	76 762	91.7	88.9	81.7
Уул уурхай, олборлолт	552	689	328	0.8	1.0	0.3
Боловсруулах үйлдвэрлэл	701	1 028	2 845	1.0	1.4	3.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	...	57	54	...	0.1	0.1
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	...	...	218	...	...	0.2
Барилга	217	928	636	0.3	1.3	0.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3 148	3 651	11 084	4.6	5.1	11.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	185	328	155	0.3	0.5	0.2
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	353	833	813	0.5	1.2	0.9
Бусад	545	389	1 073	0.8	0.5	1.1

2011-2012 оны судалгааны дүнгээр ажил эрхэлсэн нийт хүүхдийн дийлэнх нь буюу 81.7 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа ба энэ нь өмнөх 2 судалгааны дүнтэй харьцуулахад буурсан дүнтэй харагдаж байна /Хүснэгт 10.3/. Судалгаануудын дүнг харьцуулж харвал боловсруулах үйлдвэрлэлийн салбар мөн бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ажиллагчдын эзлэх хувь тогтмол өссөн байна. Хүснэгт 10.4-өөс харахад 2011-2012 оны судалгааны дүн хөдөлмөр эрхлэлтийн статус нь өмнөх хоёр судалгааныхаас ялгаатай байгаа нь харагдаж байна. Энэ нь өөрийн орны онцлог, нөхцөл байдалтай нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн статус/өмнө нь байдал гэдэг байв/-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан аргачлал<sup>1</sup>-ыг мөрдөж байгаатай холбоотой. Тухайлбал, өмнөх 2002 оны батлагдсан аргачлалаар малчин өрхийн тэргүүлэгчийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн бусад гишүүдийг өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч гэсэн статус руу оруулж байсан нь мал аж ахуй эрхэлж буй хүний тоог тооцоход хүндрэлтэй, тодорхой бус байдал бий болгож байсан учраас мал аж ахуй эрхлэгч гэсэн шинэ статусыг бий болгосноороо хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчдоос салгах боломжийг бүрдүүлж өгсөн.

## Хүснэгт 10.4. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн статусын бүтэц, судалгааны дүнгээр

	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа			Бүтэц, хувиар		
	2002-2003	2006-2007	2011-2012	2002-2003	2006-2007	2011-2012
<b>Бүгд</b>	<b>68 580</b>	<b>71 330</b>	<b>93 968</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Цалин хөлстэй ажиллагч	1 154	1 131	1 441	1.7	1.6	1.5
Ажил олгогч	36	53	0	0.1	0.1	0.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5652	6 286	2 334	8.2	8.8	2.5
Мал аж ахуй эрхлэгч*	...	...	61 955	...	...	65.9
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	61 738	63 860	27 947	90.0	89.5	29.7
Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	...	...	291	...	...	0.3

<sup>1</sup> "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал", УСХ, НХХЯ, 2009 он

\* Жилийн дөрвөн улирлын туршид өөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэн, "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал", УСХ, НХХЯ, 2009 он


Гурван удаагийн ХХС-ны үр дүнгээс харахад нийт ажил эрхэлсэн хүүхдийн дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчдын эзлэх хувь ерөнхийдөө ижил 98 хувьтай байна.

Хүснэгт 10.5. Ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, судалгааны дүнгээр

	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа			Бүтэц, хувиар		
	2002-2003	2006-2007	2011-2012	2002-2003	2006-2007	2011-2012
<b>Бүгд</b>	<b>68 580</b>	<b>71 330</b>	<b>93 968</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн			248	0.0	0.0	0.3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	2 839	3 606	11 659	4.1	5.1	12.4
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	62 237	60 358	75 643	90.8	84.6	80.5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	1 105	2 486	3 356	1.6	3.5	3.6
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	239	166	51	0.3	0.2	0.1
Энгийн ажил, мэргэжил	1 869	4 118	2 758	2.7	5.8	2.9
Бусад	291	596	253	0.4	0.8	0.3

Судалгааны дүнгээс харахад сүүлийн жилүүдэд худалдаа, үйлчилгээний ажил хийсэн хүүхдийн тоо өссөн байна. Тухайлбал, 2011-2012 онд өмнөх 2006-2007 онтой харьцуулахад 7.3 пунктээр нэмэгджээ /Хүснэгт 10.5/. Харин хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж буй хүүхдийн нийт дүнд эзлэх хувь буурсаар байна.

Зураг 10.4. Ажил эрхэлсэн хүүхэд, ажил мэргэжлийн ангиллаар, судалгааны дүнгээр, хувиар



### 10.4 ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг сүүлийн долоо хоногт ажилласан цагаар нь тооцож гаргадаг бөгөөд энэхүү тооцооллын талаар тайлангийн 6 дугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулагдсан.


Судалгааны дүнгээр сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлсэн 75855 хүүхдийн 54.9 хувь нь хөдөлмөр эрхэлж, өмнөх хоёр удаагийн судалгааны дүнтэй харьцуулахад 4.2-7.0 пунктээр буурсан байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн тоо байнга өсч байгаа ч гэсэн тэднээс хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн тоо 2006-2007 онд өссөнөө буурах хандлагатай байна. Харин судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 7.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь 2006-2007 оны судалгааны дүнгээс 0.8 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 10.6. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагийг үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, хүйсээр, судалгааны дүнгээр

	Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа			Өсөлт/бууралтын хувь	
	2002-2003	2006-2007	2011-2012	2006-2007	2011-2012
	2002-2003	2006-2007	2006-2007	2006-2007	
Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн тоо	679049	621612	589076	91.5	94.8
Сүүлийн 7 хоногт:					
Ажил эрхэлсэн хүүхдийн тоо	65729	69678	75855	106.0	108.9
Хөвгүүд	40406	42173	41905	104.4	99.4
Охид	25323	27505	33950	108.6	123.4
Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо	38856	43159	41654	111.1	96.5
Хөвгүүд	25445	26746	24487	105.1	91.6
Охид	13411	16413	17167	122.4	104.6


Зураг 10.5-аас харахад хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүдийн дунд охидын эзлэх хувь өссөн харагдаж байна. Өөрөөр хэлбэл 2011-2012 онд хөдөлмөр эрхэлсэн нийт хүүхдийн 34.5 хувь нь охид байгаа нь өмнөх судалгааны онуудынхаас 3.2-6.7 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 10.5. Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн хүйсийн бүтэц, судалгааны дүнгээр



Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийг насны бүлгээр авч үзэхэд 2002-2003 онд гурван насны бүлэг дэх хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн эзлэх хувь харьцангуй ойролцоо байхад сүүлийн 2 судалгаанд 5-11 насны хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн тоо эрс өссөн байна. Тухайлбал, хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн дунд 5-11 насны хүүхэд 2006-2007 онд 61.5 хувь, 2011-2012 онд 58.8 хувь эзлэх болж өссөн байна.

Зураг 10.6. Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн насны бүтэц, судалгааны дүнгээр



Хөдөлмөр эрхэлсэн нийт хүүхдийн дунд 15-17 насны хүүхдийн эзлэх хувь байнга буурч ирсэн бөгөөд 2011-2012 онд 15.3 хувьтай байна /зураг 10.6/.

Зураг 10.7. Хөдөлмөр эрхэлсэн хүүхдийн насны бүтэц, хүйсээр, судалгааны дүнгээр



Харин хүйсээр энэ үзүүлэлт нилээд ялгаатай байна. Зураг 10.7-гоос харахад жил ирэх тусам хөдөлмөр эрхэлж буй охидын нас бага насны бүлэг рүү шилжиж байхад харин хөвгүүдийн хувьд өөр байна. Өөрөөр хэлбэл 2006-2007 онд хөдөлмөр эрхэлж буй 15-17 насны хөвгүүдийн эзлэх хувь 19.8 хувь байсан бол 2011-2012 онд 20.2 хувь болж өссөн байна.





**XI**

**БҮЛЭГ**

**ТҮҮВРИЙН АЛДАА**

## 11.1 НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Судалгааны түүвэрлэлтийн нэгж нь өрх юм. **Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ.**

Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг өрхийн гишүүнд тооцохгүй.

## 11.2 ТҮҮВЭРЛЭЛТ

Судалгааны бүлэглэлтийг засаг захиргааны нэгж буюу бүх аймаг, Улаанбаатар хотын дүүргүүд байхаар хийсэн. Энэ нь бодлого боловсруулагчдад хөдөлмөрийн статистикийн түлхүүр үзүүлэлтүүд, тухайлбал, ажилгүйдлийг аймаг, дүүргээр гаргаж өгөх боломжийг бүрдүүлэх юм. Улаанбаатар хотын хэмжээнд дүүргүүд түүврийн бүлэг болох бөгөөд хамгийн цөөн өрхтэй 2 дүүргийг нэг бүлэгт хамруулж нийт 8 бүлэг, аймаг тус бүрийг түүврийн нэг бүлэг хэмээн үзэж (21 аймаг) нийт 29 түүврийн бүлэг үүсгэсэн. Энд Улаанбаатар хотын дүүрэг, хорооны бүх хэсгүүд, аймгийн түвшинд сумын нийт багууд нь түүврийн анхан шатны нэгж (ТАШН) болох юм. Судалгаанд 12816 өрх хамрагдах бөгөөд улирал тутам 3204 өрх шинээр түүвэрлэгдэх болно. Судалгааны түүвэрлэлтийн хүрээ нь Монголын Улсын нийт өрх бөгөөд үүнд Хүн ам, өрхийн 2010 оны жилийн эцсийн тайлан, мэдээний үр дүнг ашигласан. Эхлээд түүврийн анхан шатны нэгжүүдийг аймаг, нийслэл сум, дүүргийн нэрсийн дагуу жагсааж ТАШН-ийн хувийн дугаар, нэгж бүрд тоологдсон өрхийн тоог жагсааж түүврийн хүрээг бэлтгэсэн.

Түүвэрт хичнээн өрх хамрагдах нь судалгааны санхүүжилтээс болон түүвэр судалгааны үр дүнгийн нарийвчлалаас ихээхэн хамаарна. Судалгаанд хамрагдсан 12816 өрхөөс авсан мэдээлэл нь Монгол Улсын нийт өрхүүдийг төлөөлөхдөө судалгааны асуулгаар цуглуулсан мэдээллийн бодит байдал үндэсний хэмжээнд 5 хувиас хэтрэхгүй алдааны магадлалтай ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5-аас хэтрэхгүй байхаар хийгдсэн болно.

### БҮЛЭГЛЭЛТ:

Улаанбаатар хотын хэмжээнд дүүрэг тус бүр түүврийн бүлэг болох бөгөөд хамгийн цөөн өрх, хүн амтай 2 дүүргийг нэгтгэн нэг бүлэг болгон нийт 8 бүлэг үүсгэсэн. Аймаг тус бүрийг нэг бүлэг хэмээн тооцож (21 аймаг) 21 бүлэг үүсгэсэн юм. Нийтдээ  $21+8=29$  бүлэгтэй.

**Бүлэг 1:** УБ хотын 1-р дүүргийн бүх хэсгүүд

**Бүлэг 2:** УБ хотын 2-р дүүргийн бүх хэсгүүд

.....

**Бүлэг 8:** УБ хотын 8, 9-р дүүргийн бүх хэсгүүд

**Бүлэг 9:** Архангай аймгийн бүх багууд

.....

**Бүлэг 29:** Говьсүмбэр аймгийн бүх багууд

Түүвэрлэлтийг хийхдээ 2 шатат түүврийн аргыг хэрэглэсэн.

**Эхний шатанд** ТАШН, хоёр дахь шатанд түүвэрлэгдсэн анхан шатны нэгж дэх өрхийг сонгосон. Түүвэрлэлтийн эхний шатанд судалгааны нэгж (баг, хорооны хэсэг) буюу түүврийн анхан шатны нэгжийг (ТАШН) түүвэрлэлтийн пропорциональ магадлалт системчилсэн түүврийн аргаар бүлэг тус бүрт түүвэрлэлт хийсэн. 5-17 насны хүүхэд нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа өрхийн хувийн жингээр тодорхойлогч үзүүлэлт болгон сонгож авсан.

Хэмжээнд пропорциональ магадлалт түүврийн аргаар анхан шатны нэгжийг сонгоход ТАШНтттр дэхь хүн амын тоо  $M_{hi}$ -г хэмжээний тодорхойлогч болгон ашигласан. Бүлэглэлт тус бүрээс хэмжээнд нь пропорциональ магадлалт системчилсэн түүврийн аргыг (ХПМСТ) түүвэрлэлт хийхэд ашигласан. Түүвэрлэлтийн үйл ажиллагааг дараах байдлаар үзүүлэв.

"h" бүлэг доторх 'i' ТАШН-ийн түүвэрлэгдэх магадлал дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$P_{hi}^{(i)} = \frac{a_h M_{hi}}{M_h}$$

Үүнд:

$a_h$  = бүлэг тус бүрээс авсан ТАШН-ийн тоо

$M_{hi}$  = 'i' ТАШН-д түүврийн хүрээнд тодорхойлогдсон хүн амын тоо

$M_h = \sum M_{hi}$  = бүлэг бүр дэх түүврийн хүрээгээр тогтоогдсон нийт хүн амын тоо

"h" бүлэг дэх ТАШН-үүдийг аймаг, сум, дүүргийн нэрийн дагуу жагсааж ТАШН-ийн түүвэрлэлтийг хийсэн ба тогтоогдсон хүн амын тоог хэмжээний үзүүлэлт  $M_{hi}$  болгож авсан юм. " $M_{hi}$ " өсөн нэмэгдэх утгуудыг тооцоолж уг утгуудыг ТАШН тус бүрийн харалдаа тавьсан болно. Түүврийн интервал  $I_{hi}$ -ийг дараах байдлаар тооцоолсон.

$$I_{hi} = \frac{M_h}{a_h} \quad \text{хамгийн ойр бүхэл тоонд шилжүүлнэ.}$$

" $R_h$ " санамсаргүй тоо нь 0-с хүртэлх дурын тоо байх ба үүнийг Excel программын санамсаргүй тооны функцийн тусламжтайгаар тодорхойлов. " $a_h$ " тодорхойлогч тоонуудын дарааллыг өмнөх сонгогдсон тоон дээр  $I_{hi}$ -г нэмж олсон болно.

$$R_h, (R_h + I_{h1}), (R_h + 2I_{h1}), (R_h + 3I_{h1}), \dots, (R_h + (j-1)I_{h1}), (R_h + (a_h - 1)I_{h1})$$

**Хоёр дахь шатанд** сонгогдсон ТАШН бүрээс түүвэр олонлогийг бүрдүүлэх өрхүүдийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгосон. ТАШН-үүдээс ирүүлсэн өрхийн жагсаалтад үндэслэн санамсаргүйгээр 12 өрхийг сонгож, судалгаанд хамруулсан.

## ТҮҮВРИЙН ЖИН

Түүврийн жин доорх томъёоны дагуу тодорхойлогдоно:

$$M_{srj} = \frac{P_s \times H_{srj}}{n_{sr} \times p_{sri} \times h_{srj}} \quad \text{- Дэд түүвэрлэлт тус бүр дэх түүврийн анхан шатны жинг тооцох томъёо}$$

$$M_{sij} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{sij}}{n_{sr} \times p_{sri} \times h_{sij}} \quad \text{- Дэд түүвэрлэлтийг нэгтгэсэн түүврийн анхан шатны нэгжийн жинг тооцох томъёо}$$

$$M_{tj} = \frac{1}{2} \times \frac{P_s \times H_{tj}}{n_{sr} \times p_{sri} \times h_{tj}} \quad \text{- t-р улирлын жингийн томъёо}$$

P, p, n, H & h-ийн утгууд:

- P – тухайн бүлгийн хэмжээ буюу бүлгийн нийт хүн амын тоо.
- p – тухайн анхан шатны нэгж дэх нийт хүн амын тоо
- n – тухайн дэд түүвэрлэтээр тоологдох түүврийн анхан шатны нэгжийн тоо
- H – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх өрхийн нийт тоо.

- $h$  – тухайн бүлгийн анхан шатны нэгжийн дэд түүвэрлэлт дэх түүвэрлэгдэх өрхийн тоо.

### Вариаци болон стандарт алдааны тооцоо

Судалгааны үр дүнгийн нарийвчлал, төлөөлөх чадварыг гаргах нь тооцооны зайлшгүй хэсэг юм.

Тухайн сонгож авсан  $y$  үзүүлэлтийн вариацийг тооцох томъёо:

$$\text{var}(y) = \sum [(1 - f_h) (a_h / a_h - 1) \sum (y_{hi}^2 - y_h^2 / a_h)]$$

Үүнд:

$f_h$  = “ $h$ ” бүлгийн түүврийн хувь

$a_h$  = “ $h$ ” бүлгээс түүвэрлэсэн ТАШН-ийн тоо

$y_{hi}$  =  $h$  бүлгийн  $i$  нэгжийн  $y$  үзүүлэлтийн утга

Судалгааны үр дүнгийн стандарт алдааны утга нь түүвэр хийснээс шалтгаалан ерөнхий олонлогийн бодит утга буюу параметрээс түүврийн утга хэр зэрэг хэлбэлзэж байгааг үзүүлнэ. Стандарт алдааг **se(y)** түүврийн үндсэн дээр тооцохдоо:

$$\text{se}(y) = \text{var}(y)^{1/2}$$

Харьцангуй стандарт алдаа буюу вариацийн коэффициент нь **cv**, түүврийн тооцооны утгын харьцангуй вариацийн утгыг илэрхийлэх ба өөрөөр хэлбэл түүврийн алдаа нь тооцооны утгатайгаа харьцуулахад ямархуу далайцтай байна гэдгийг үзүүлнэ. Вариацийн коэффициентийг доорхи аргаар тооцно.

$$\text{cv}(y) = \text{se}(y) / y.$$

Дундаж, харьцаа гэх мэт үзүүлэлтийн тооцооны утгын далайц, хэмжих нэгж нь өөр өөр байдгаас хамааран тухайн судлагдаж байгаа үзүүлэлтийн талаар хийгдсэн янз бүрийн судалгааны үр дүнгийн стандарт алдаануудыг шууд харьцуулах боломжгүй учраас **cv** буюу пропорциональ алдаа нь төлөөлөх чадварыг харьцуулах боломж олгодог. Түүврийн хэмжээ болон түүврийн арга нь түүврийн алдаа хэр зэрэг их, бага байхыг тодорхойлох бөгөөд зарим үзүүлэлтийн хувьд түүврийн алдаа өндөр байх боломжтой бөгөөд эдгээр тоог ашиглахдаа анхааралтай байх хэрэгтэй.

### 11.3 ТҮҮВРИЙН АЛДАА

Түүвэр судалгаа хийгдэж байгаатай уялдан дараах 2 төрлийн алдаа гарч байдаг. Үүнд:

- 1) түүвэрлэлтийн алдаа;
- 2) түүвэрлэлтийн бус алдаа;

Түүвэрлэлтийн бус алдаа нь тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үйл явцын үед гардаг. Энэхүү алдаанд судалгааны бэлтгэл үе шат, мэдээлэл цуглуулах үед хийсэн судлаачийн санамсаргүй болон санаатай хийсэн алдаа, боловсруулалтын шатанд гарсан алдааг хамруулж авч үздэг. Түүвэрлэлтийн бус алдаа нь түүврийн үр дүнгийн алдааны ихэнх хувийг эзэлдэг бөгөөд түүврийн дизайн болон түүвэр судалгааг явуулах үе шатуудаас хамаардаггүй бөгөөд түүнийг статистикийн аргаар тооцоолох боломж хомс байдаг. Харин түүвэрлэлтийн алдааг статистикийн аргаар тооцоолдог.

Нийт олонлогоос түүвэрлэн авсан ажиглалт дээр тулгуурлан үр дүнг тооцдогдоос шалтгаалан түүвэрлэлтийн алдаа гардаг. Түүвэрлэлтийн алдаа тухайн судалгааг хийхэд ашигласан түүврийн төрөл болон түүврийн хэмжээнээс хамаарна. Энэхүү алдааг боломжит түвшинд байлгах үүднээс түүврийн загвар болон түүврийн хэмжээг сонгосон.

Улсын хэмжээнд тодорхойлогдсон түүврийн анхан шатны нэгж бүрээс сонгогдсон өрхөөс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаас ямар хэмжээний хэлбэлзэлтэй

байгааг түүвэрлэлтийн алдаа илэрхийлнэ. Түүврийн загвар болон түүврийн хэмжээнд тулгуурлан алдааг тооцсон бөгөөд зарим нэг үзүүлэлтийн алдааны хязгаар өндөр байх нь түүврийн загварыг сонгох үе шатанд харагдаж байсан.

Судалгааны түүвэрлэлтийн алдааг дараах үзүүлэлтийн тусламжтайгаар тооцоолсон бөгөөд түүврийн алдааг илэрхийлэх гол үзүүлэлт нь вариацийн коэффициент болно. Үүнд:

- Ерөнхий олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэмжлэгдэх интервал
- Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо

Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд улсын түвшин, хот, хөдөө, хүйсээр, бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээнд гэсэн ангиллаар тооцсон.

## НИЙТ ХҮН АМ

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
<b>НИЙТ</b>	2,464,008	45,042	253.5	2,463,501	2,464,515	0.6
<b>ХОТ, ХӨДӨӨ</b>						
Хот	1,454,932	27,429	252.3	1,454,427	1,455,437	0.9
Хөдөө	1,009,676	17,613	232.7	1,009,211	1,010,141	1.3
<b>ХҮЙС</b>						
Эрэгтэй	1,210,117	22,121	153.4	1,209,810	1,210,424	0.7
Эмэгтэй	1,253,891	22,921	150.5	1,253,590	1,254,192	0.7
<b>БҮС</b>						
Баруун	404,025	7,791	111.2	403,803	404,247	1.4
Хангай	200,211	8,691	89.3	200,032	200,390	1.0
Төв	400,982	7,090	79.5	400,823	401,141	1.1
Зүүн	520,416	3,442	53.3	520,309	520,523	1.5
Улаанбаатар	938,374	18,028	161.0	938,052	938,696	0.9
<b>АЙМАГ</b>						
Архангай	88,003	1,452	37.2	87,929	88,077	2.6
Баян-Өлгий	102,802	2,125	35.3	102,731	102,873	1.7
Баянхонгор	73,414	1,358	35.9	73,342	73,486	2.6
Булган	56,535	967	36.4	56,462	56,608	3.8
Говь-Алтай	57,450	1,100	27.1	57,396	57,504	2.5
Дорноговь	51,933	954	25.1	51,883	51,983	2.6
Дорнод	70,337	1,334	34.9	70,267	70,407	2.6
Дундговь	45,627	813	17.9	45,591	45,663	2.2
Завхан	86,269	1,493	27.5	86,214	86,324	1.8
Өвөрхангай	102,258	1,569	31.7	102,195	102,321	2.0
Өмнөговь	46,500	910	34.0	46,432	46,568	3.7
Сүхбаатар	54,335	1,028	27.5	54,280	54,390	2.7
Сэлэнгэ	84,242	1,385	34.3	84,173	84,311	2.5
Төв	85,356	1,264	33.3	85,289	85,423	2.6
Увс	74,700	1,455	52.8	74,594	74,806	3.6
Ховд	79,762	1,618	45.6	79,671	79,853	2.8
Хөвсгөл	115,651	1,871	41.6	115,568	115,734	2.2
Хэнтий	75,540	1,080	28.0	75,484	75,596	2.6
Дархан-Уул	81,358	1,464	35.5	81,287	81,429	2.4
Улаанбаатар	938,374	18,028	161.0	938,052	938,696	0.9
Орхон	84,555	1,474	34.4	84,486	84,624	2.3
Говьсүмбэр	9,007	300	10.3	8,986	9,028	3.4

## АЖИЛЛАХ ХҮЧ

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
<b>НИЙТ</b>	1,140,126	20,699	178.5	1,139,769	1,140,483	0.9
<b>ХОТ, ХӨДӨӨ</b>						
Хот	606,776	11,386	130.1	606,516	607,036	1.1
Хөдөө	533,350	9,313	135.0	533,080	533,620	1.4
<b>ХҮЙС</b>						
Эрэгтэй	597,622	10,857	101.1	597,420	597,824	0.9
Эмэгтэй	542,504	9,842	102.0	542,300	542,708	1.0
<b>БҮС</b>						
Баруун	199,018	3,865	67.8	198,882	199,154	1.8
Хангай	265,569	4,435	81.9	265,405	265,733	1.8
Төв	201,067	3,497	66.3	200,934	201,200	1.9
Зүүн	91,932	1,586	49.4	91,833	92,031	3.1
Улаанбаатар	382,540	7,316	86.5	382,367	382,713	1.2
<b>АЙМАГ</b>						
Архангай	52,360	862	36.2	52,288	52,432	4.2
Баян-Өлгий	48,799	1,007	32.4	48,734	48,864	3.2
Баянхонгор	37,600	694	29.9	37,540	37,660	4.3
Булган	28,664	491	19.4	28,625	28,703	4.0
Говь-Алтай	30,562	585	22.3	30,517	30,607	3.8
Дорноговь	22,380	413	22.3	22,335	22,425	5.4
Дорнод	29,127	553	35.4	29,056	29,198	6.4
Дундговь	24,135	430	15.4	24,104	24,166	3.6
Завхан	39,975	693	18.4	39,938	40,012	2.7
Өвөрхангай	49,978	771	34.6	49,909	50,047	4.5
Өмнөговь	22,978	460	25.7	22,927	23,029	5.6
Сүхбаатар	28,485	541	20.8	28,443	28,527	3.8
Сэлэнгэ	43,230	711	25.3	43,179	43,281	3.6
Төв	48,582	713	32.8	48,516	48,648	4.6
Увс	40,728	791	28.3	40,671	40,785	3.6
Ховд	38,954	789	33.1	38,888	39,020	4.2
Хөвсгөл	58,103	942	38.2	58,027	58,179	4.1
Хэнтий	34,320	492	20.2	34,280	34,360	4.1
Дархан-Уул	36,279	651	17.1	36,245	36,313	2.6
Улаанбаатар	382,540	7,316	86.5	382,367	382,713	1.2
Орхон	38,864	675	30.7	38,803	38,925	4.5
Говьсүмбэр	3,483	119	14.6	3,454	3,512	12.3

## АЖИЛЛАГЧИД

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
<b>НИЙТ</b>	1,043,938	18,942	179.3	1043579	1044297	0.9
<b>ХОТ, ХӨДӨӨ</b>						
Хот	550,322	10322	119.7	550083	550561	1.2
Хөдөө	493,616	8620	139.0	493338	493894	1.6
<b>ХҮЙС</b>						
Эрэгтэй	546,378	9923	103.6	546171	546585	1.0
Эмэгтэй	497,560	9,019	99.4	497361	497759	1.1
<b>БҮС</b>						
Баруун	178,602	3,473	77.8	178446	178758	2.2
Хангай	242,061	4042	90.7	241880	242242	2.2
Төв	187,301	3247	70.1	187161	187441	2.2
Зүүн	80,122	1,383	47.8	80026	80218	3.5
Улаанбаатар	355,852	6,797	80.1	355692	356012	1.2
<b>АЙМАГ</b>						
Архангай	50,263	827	39.3	50184	50342	4.8
Баян-Өлгий	43,595	900	43.2	43509	43681	4.8
Баянхонгор	35,447	654	32.5	35382	35512	5.0
Булган	24,928	428	26.8	24874	24982	6.3
Говь-Алтай	26,526	508	28.4	26469	26583	5.6
Дорноговь	21,568	398	22.7	21523	21613	5.7
Дорнод	25,772	486	29.7	25713	25831	6.1
Дундговь	22,164	394	19.0	22126	22202	4.8
Завхан	35,253	613	24.8	35203	35303	4.0
Өвөрхангай	47,140	727	35.5	47069	47211	4.9
Өмнөговь	20,291	407	27.4	20236	20346	6.7
Сүхбаатар	25,033	476	24.6	24984	25082	5.2
Сэлэнгэ	41,835	688	27.6	41780	41890	4.0
Төв	46,286	678	34.9	46216	46356	5.1
Увс	37,068	719	32.5	37003	37133	4.5
Ховд	36,160	733	34.1	36092	36228	4.7
Хөвсгөл	50,478	821	42.0	50394	50562	5.1
Хэнтий	29,317	421	23.5	29270	29364	5.6
Дархан-Уул	31,857	570	19.6	31818	31896	3.4
Улаанбаатар	355,852	6,797	80.1	355692	356012	1.2
Орхон	33,805	585	32.1	33741	33869	5.5
Говьсүмбэр	3,300	112	15.5	3269	3331	13.8



## АЖИЛГҮЙ ИРГЭД

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
<b>НИЙТ</b>	96,188	1,757	55.1	96078	96298	3.1
<b>ХОТ, ХӨДӨӨ</b>						
Хот	56,454	1064	42.0	56370	56538	3.9
Хөдөө	39,734	693	35.9	39662	39806	5.2
<b>ХҮЙС</b>						
Эрэгтэй	51,244	934	27.2	51190	51298	2.9
Эмэгтэй	44,944	823	28.0	44888	45000	3.4
<b>БҮС</b>						
Баруун	20,416	392	27.0	20362	20470	6.9
Хангай	23,508	393	26.0	23456	23560	6.6
Төв	13,766	250	16.1	13734	13798	6.4
Зүүн	11,810	203	18.3	11773	11847	9.0
Улаанбаатар	26,688	519	29.5	26629	26747	5.7
<b>АЙМАГ</b>						
Архангай	2,097	35	5.5	2086	2108	15.7
Баян-Өлгий	5,204	107	13.3	5177	5231	12.4
Баянхонгор	2,153	40	6.1	2141	2165	15.3
Булган	3,736	63	8.5	3719	3753	13.5
Говь-Алтай	4,036	77	13.7	4009	4063	17.8
Дорноговь	812	15	2.2	808	816	14.7
Дорнод	3,355	67	14.2	3327	3383	21.2
Дундговь	1,971	36	4.5	1962	1980	12.5
Завхан	4,722	80	12.4	4697	4747	15.5
Өвөрхангай	2,838	44	8.1	2822	2854	18.4
Өмнөговь	2,687	53	8.6	2670	2704	16.2
Сүхбаатар	3,452	65	8.1	3436	3468	12.5
Сэлэнгэ	1,395	23	5.0	1385	1405	21.7
Төв	2,296	35	5.2	2286	2306	14.9
Увс	3,660	72	8.1	3644	3676	11.3
Ховд	2,794	56	11.8	2770	2818	21.1
Хөвсгөл	7,625	121	18.5	7588	7662	15.3
Хэнтий	5,003	71	8.8	4985	5021	12.4
Дархан-Уул	4,422	81	9.2	4404	4440	11.4
Улаанбаатар	26,688	519	29.5	26629	26747	5.7
Орхон	5,059	90	9.6	5040	5078	10.7
Говьсүмбэр	183	7	2.0	179	187	28.6

## ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮҮХЭД

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Дунджаас хазайх хазайлт	95% итгэмжлэгдэх интервал		Вариацийн коэффициент (стандарт алдаа)
				Доод	Дээд	
<b>НИЙТ</b>	93,968	1,713	85.1	93798	94138	5.0
<b>ХОТ, ХӨДӨӨ</b>						
Хот	17,895	337	21.6	17852	17938	6.4
Хөдөө	76,073	1376	74.5	75924	76222	5.4
<b>ХҮЙС</b>						
Эрэгтэй	50,870	932	43.6	50783	50957	4.7
Эмэгтэй	43,098	781	39.5	43019	43177	5.1
<b>БҮС</b>						
Баруун	36,294	715	59.1	36176	36412	8.3
Хангай	25,766	435	39.9	25686	25846	9.2
Төв	18,319	317	28.7	18262	18376	9.1
Зүүн	8,446	151	22.1	8402	8490	14.6
Улаанбаатар	5,143	95	6.7	5130	5156	7.1
<b>АЙМАГ</b>						
Архангай	10,012	164	22.0	9968	10056	13.4
Баян-Өлгий	10,235	210	32.6	10170	10300	15.5
Баянхонгор	5,081	96	19.0	5043	5119	19.8
Булган	1,871	33	6.5	1858	1884	19.7
Говь-Алтай	6,218	120	18.3	6181	6255	15.3
Дорноговь	968	18	3.7	961	975	20.6
Дорнод	2,497	49	9.6	2478	2516	19.6
Дундговь	5,261	85	12.3	5236	5286	14.5
Завхан	6,029	104	25.2	5979	6079	24.2
Өвөрхангай	4,979	78	15.1	4949	5009	19.4
Өмнөговь	2,836	61	12.6	2811	2861	20.7
Сүхбаатар	3,727	71	18.2	3691	3763	25.6
Сэлэнгэ	1,942	32	6.7	1929	1955	20.9
Төв	5,639	88	15.2	5609	5669	17.3
Увс	6,406	128	29.5	6347	6465	23.0
Ховд	7,407	153	24.5	7358	7456	16.0
Хөвсгөл	2,107	34	8.1	2091	2123	23.8
Хэнтий	2,222	31	7.4	2207	2237	23.9
Дархан-Уул	1,508	27	3.1	1502	1514	11.5
Улаанбаатар	5,143	95	6.7	5130	5156	7.1
Орхон	1,715	30	14.7	1686	1744	49.0
Говьсүмбэр	164	6	0.0	164	164	0.0

**Хүснэгт 1. 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, хот, хөдөө, бүс, аймаг, нийслэлээр, бүгдэд эзлэх хувиар**

		Хүйс				Бүгд	
		Эрэгтэй		Эмэгтэй			
		Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
Бүгд		51.0	300 678	49.0	288 398	100.0	589 076
5 - 9		50.7	102 276	49.3	99 564	100.0	201 840
10 - 11		52.4	48 057	47.6	43 572	100.0	91 629
12 - 14		51.8	74 824	48.2	69 567	100.0	144 391
15 - 17		49.9	75 521	50.1	75 695	100.0	151 216
Хот	5 - 9	49.5	55 416	50.5	56 538	100.0	111 954
	10 - 11	51.2	26 189	48.8	24 922	100.0	51 111
	12 - 14	51.3	38 426	48.7	36 450	100.0	74 876
	15 - 17	48.8	40 479	51.2	42 477	100.0	82 956
	Дүн	50.0	160 510	50.0	160 387	100.0	320 897
Хөдөө	5 - 9	52.1	46 860	47.9	43 026	100.0	89 886
	10 - 11	54.0	21 868	46.0	18 650	100.0	40 518
	12 - 14	52.4	36 398	47.6	33 117	100.0	69 515
	15 - 17	51.3	35 042	48.7	33 218	100.0	68 260
	Дүн	52.3	140 168	47.7	128 011	100.0	268 179
Баруун бүс		53.2	66 042	46.8	58 127	100.0	124 169
	Завхан	50.7	11 914	49.3	11 595	100.0	23 509
	Говь-Алтай	56.1	9 772	43.9	7 644	100.0	17 416
	Баян-Өлгий	54.4	20 197	45.6	16 911	100.0	37 108
	Ховд	51.7	11 790	48.3	11 004	100.0	22 794
	Увс	53.0	12 369	47.0	10 973	100.0	23 342
Хангайн бүс		49.4	63 477	50.6	64 981	100.0	128 458
	Орхон	50.4	10 196	49.6	10 037	100.0	20 233
	Өвөрхангай	50.0	13 962	50.0	13 937	100.0	27 899
	Булган	53.9	7 357	46.1	6 302	100.0	13 659
	Баянхонгор	51.8	8 229	48.2	7 667	100.0	15 896
	Архангай	48.0	10 677	52.0	11 571	100.0	22 248
	Хөвсгөл	45.8	13 056	54.2	15 467	100.0	28 523
Төвийн бүс		52.2	51 527	47.8	47 151	100.0	98 678
	Төв	55.5	10 601	44.5	8 492	100.0	19 093
	Говьсүмбэр	47.7	846	52.3	929	100.0	1 775
	Сэлэнгэ	52.7	10 437	47.3	9 377	100.0	19 814
	Дорноговь	50.5	7 490	49.5	7 343	100.0	14 833
	Дархан-Уул	53.0	9 366	47.0	8 322	100.0	17 688
	Өмнөговь	51.5	6 451	48.5	6 072	100.0	12 523
	Дундговь	48.9	6 336	51.1	6 616	100.0	12 952
Зүүн бүс		50.6	25 198	49.4	24 639	100.0	49 837
	Дорнод	49.8	7 497	50.2	7 565	100.0	15 062
	Сүхбаатар	49.3	7 032	50.7	7 239	100.0	14 271
	Хэнтий	52.0	10 669	48.0	9 835	100.0	20 504
Улаанбаатар		50.2	94 434	49.8	93 500	100.0	187 934

## Хүснэгт 2. 5-17 насны хүүхдийн тоо, байршил, бүс, аймгаар, өрхийн тэргүүлэгчийн хүйс, ам бүлийн тоогоор

Байршил, бүс	Өрхийн тэргүүлэгчээр		Өрхийн ам бүлийн тоо					Бүгд
